

ШИХИХУТУГ

ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ,
АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

Нэг дэх жилдээ
3/1999

ТӨРИЙН ОНОЛЫН АСУУДАЛД

АГУУЛГА

1. Д.Оюунцэцэг	«Шихихутуг» Хууль Зүйн Дээд Сургууль	4
2. Ж.Болдбаатар	Улсын дээд заргач Шихихутуг (1180-1262 он)	9
3. Г.Совд	Хүний эрх хуульчилсанаар аяндаа хэрэгждэггүй	20
4. Н.Лүндэндорж	Төр ёсны тухай үзэл санаа, түүний уг сурвалж (бодрол)	26
5. Д.Баярсайхан	Төрийн бүрэн эрхт байдал	32
6. Б.Мандахбилэг	Хууль зүйн зохицуулалтаар төр, засгийн хямралаас урьдчилан сэргийлэх нь	37
7. Ц.Минжин	Чингисийн төрийн үзэл	42
8. Б.Бат-Эрдэнэ	Эд хөрөнгийн бус гэм хорын тухай асуудлыг шинээр авч үзэх нь	45
9. Д.Үүрцайх	«Төрийн тэргүүн, түүний эрх зүйн байдал» сэдэвт магистрын зэрэг хамгаалсан бүтээлийн товч танилцуулга	51
10. Л.Мөнхжаргал	«Монгол Улс дахь хүн амын хөдөлмөр эрхлэлт, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал» сэдэвт магистрын зэрэг хамгаалсан бүтээлийн товч танилцуулга	63
11.	«Шихихутуг» ХЗДС-ийн 1999-2000 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам	72
12. Д.Үүрцайх	Суутнуудын хэлсэн үгээс	75

Эрхлэн хэвлүүлсэн
«ШИХИХУТУГ»
ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИ

Ерөнхий редактор

Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН

Редакцийн гишүүд

Галдангийн СОВД
Жигжидийн БОЛДБААТАР
Чимидийн ЭНХБААТАР
Жамсрангийн БЯМБАДОРЖ
Жаргалантын ЭЛБЭГСАЙХАН
Бирваагийн МАНДАХБИЛЭГ
Түдэврэнчингийн БАЯРМАА

Нарийн бичгийн дарга

Дащдондогийн ҮҮРЦАЙХ

Хаяг:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж,
«Шихихутуг» ХЗДС-ийн байр.
Утас: 323392, 320176

Жилд 4 дугаар хэвлэгдэн гарна
Улсын бүртгэлийн дугаар 173

Хэвлэлийн газар

Эрхэм уншигч танаа

Манай улсад 1990-ээд оноос өмнө хууль зүйн боловсон хүчнийг төрийн өмчийн ганц нэг их, дээд сургууль, түүнчлэн ЗХУ(хуучин нэрээр)-д бэлтгэж ирсэн билээ. 1991 онд төрийн өмчийн бус анхны хууль зүйн дээд сургууль болох «Шихихутуг» сургууль байгуулагдсан нь хууль зүйн мэргэжилтэн бэлтгэх салбарт шинэ амьсгал болон орж ирсэн юм.

Сүүлийн жилүүдэд төр ба эрх зүйг үзэх онол сэтгэлгээнд ч их өөрчлөлт гарав. 1980-аад оны эцэс, 1990-ээд оны эхээр иргэний, ардчилсан нийгмийг цогцлуулан байгуулах явдлыг нийгмийн гол идеал болгон тавьж, засаглал хуваах онол, зарчмыг баримтлан төрийн эрх мэдлийг зохистой хуваарилах, хууль дээдлэх зэрэг эрх зүйт төрийг төлөвшүүлэхтэй холбоотой олон асуудлаар хуульч эрдэмтэд санаа бодлоо илэрхийлж, зохиол бүтээлээ туурвисан нь Монголын хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн төвшинг илтгэсэн хэрэг байв.

Өдгөө манай улсад хууль зүйн сургалт явуулж буй сургуулиуд олноор ажиллаж, улс орны хэмжээнд эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Монголын эрх зүйн тогтолцоо, төр ёсны уламжлал, шинэчлэл, өрнө, дорнын эрх зүйн систем, шинэ тутам үүсэн бүрэлдэж байгаа эрх зүйн шинэхэн салбарууд зэрэг хууль зүйн шинжлэх ухааны онол, практикийн олон асуудлын талаарх эрдэмтэн, мэргэдийнхээ тайлбар, бодрол, бясалгал, үндэслэл, нотолгоог илэрхийлэх индэр «Шихихутуг» сэтгүүл эрхэм уншигч таны оюуны мэлмийд анхныхаа дугаарыг өргөн барьж байна.

Онол, бодролын энэхүү сэтгүүл улирал тутам гарах юм. Энэ дугаарт гол төлөв төр ёсны хөгжил, дэвшилтэй холбоотой асуудлууд орж байна. Цаашдаа төр, эрх зүйн чухал асуудлуудыг эрэмбэ дараатай, чиглэсэн зорилготойгоор цуврал болгон нийтлэх бодлого баримтална.

Эрхэм уншигч абугай танд номун далайгаас ухааныхаа шанагаар утгаж, эрдмийн сувд шүүрдэхийн ерөөлийг талибая. Болгоон соёрхоно уу.

Ерөнхий редактор



Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН

«ШИХИХУТУГ» ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

Манай сургууль нь 1991 онд Боловсролын сайдын зөвлөлийн 11 тоот шийдвэрээр байгуулагдсан Монгол улсын хувийн ууган сургуулиудын нэг юм. Бид сургуулиа Монгол улсад хууль зүйн салбараар өндөр мэргэжлийн, эрдэм оюун төгс боловсон хүчин бэлтгэх зорилгоор байгуулсан бөгөөд Эзэн Богд Чингис хааны есөн өрлөгийн нэг, Монгол төрийн нэрт зүтгэлтэн, бичиг ном, хууль цаазын их хүмүүн Шихихутугийн алдараар нэрийдсэн билээ.

Манай сургуулийн эрхэм зорилго бол сургуулийн материаллаг баазыг бэхжүүлж, багшлах бүрэлдэхүүнийг чадваржуулах, сургалтыг олон улсын жишигт хүргэх явдал юм. Бид энэхүү эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд тодорхой зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажилласаар ирсэн юм.

«Шихихутуг» ХЗДС нь «Эрх зүйч» мэргэжлээр дээд боловсролтой, бакалаврын зэрэгтэй хуульчдыг бэлтгэх зорилготой сургалт, эрдэм шинжилгээний байгууллага юм. Сургалтын хугацаа үндсэн ангид 4 жил, эцнээ ангид 2 жил бөгөөд сургалтын төлөвлөгөөний дагуу нэг курст жилд дунджаар 30-34 багц цагийн хичээл ордог. Манай сургууль 1998-1999 оны хичээлийн жилд сургах үйл явц, үр дүнг багц цагаар үнэлэх журамд шилжсэн бөгөөд оюутан суралцах хугацаандаа 120-150 багц цагийг цуглуулж, бакалаврын зэрэг авах болзлыг хангадаг юм.

Сургуулийн нийт багшлах бүрэлдэхүүний 70 гаруй хувь нь эрдмийн зэрэг, цолтойгоос гадна Улсын Их Хурлын болон Үндсэн хуулийн цэцийн гишүүд, Улсын Дээд шүүхийн шүүгчид зэрэг төрийн зүтгэлтнүүд, хууль зүйн ухааны нэртэй олон эрдэмтэн, мэргэжилтнүүд манай сургуульд багшилдаг юм. Тухайлбал, манай сургуульд Үндсэн хуулийн цэцийн анхны дарга асан хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол улсын гавьяат хуульч Г.Совд зөвлөх багшаар ажилладаг бөгөөд Улсын Их Хурлын гишүүн, доктор (Ph), профессор Д.Лүндээжанцан, С.Төмөр, Ж.Бямбадорж, Ц.Шаравдорж, Улсын Их Хурлын гишүүн асан, шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар, доктор (Ph), профессор С.Нарангэрэл, Н.Жалбажав, ахлах багш

Г.Ганболд, Д.Батбаатар нар төр, эрх зүйн хичээлүүдийг зааж ирэв. Үндсэн хуулийн Цэцийн гишүүд: доктор (Ph), профессор Ч.Энхбаатар, шинжлэх ухааны доктор С.Жанцан, Оюуны өмчийн газрын дарга Н.Чинбат, Үндсэн хуулийн Цэцийн гишүүн асан доктор (Ph), профессор Л.Баасан, Ж.Бямбаа нар тус сургуулийг байгуулагдсан цагаас эхлэн хичээл зааж байна.

Ерөнхий онолын суурь хичээлүүд болох эдийн засаг, философийн төрлийн хичээлүүдийг Улсын Их Хурлын гишүүн асан, эдийн засгийн шинжлэх ухааны доктор Г.Цэдэндагва, Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж байсан шинжлэх ухааны доктор Б.Түмэн агсан, эдийн засгийн ахмад эрдэмтэн Ү.Чимид, Хамба лам, гавж Д.Чойжамц, философич эрдэмтэн Г.Лхагвасүрэн зэрэг нэртэй хүмүүс зааж ирсэн юм.

Түүнчлэн Т.Сэнгэдорж, Т.Мөнхжаргал нарын зэрэг хууль зүйн нэртэй эрдэмтэд, Ч.Ганбат, Ж.Энхчулуун, Е.Сагсай, Д.Мөнхтуул зэрэг практикийн сайн хуульчид оюутнуудад лекц уншиж, дадлагын хичээлийг удирддаг.

Сургууль үйл ажиллагаагаа профессорын зохион байгуулалтын үндсэн дээр явуулдаг бөгөөд төр, захиргааны эрх зүйн; онол, түүхийн; эрүүгийн эрх зүйн; иргэний эрх зүйн гэсэн чиглэлээр 3-5 хүн нэг профессорын удирдлагын дор ажилладаг.

Манай сургууль материаллаг баазын хувьд нилээд бэхжсэн гэж үзэж болох бөгөөд 1998 онд өөрийн өмчийн хичээлийн байртай болсон юм. Түүнчлэн 10 гаруй мянган монгол, орос, англи хэл дээрхи мэргэжлийн болон бусад шинжлэх ухааны ном, сурах бичиг, сэтгүүл, гарын авлагатай тохилог номын сан, уншлагын танхимтай бөгөөд Монгол улсын их, дээд сургуулиуд, Үндсэн хуулийн цэц, Улсын Дээд Шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, шийдвэр гүйцэтгэх газар зэрэг хууль хяналтын байгууллагууд, Монгол улсын үндэсний номын сан, Улсын Их Хурлын номын сан, Үндэсний архив зэрэг байгууллагуудтай сургалттай холбогдсон болон бүх төрлийн мэдээлэл солилцох, номын сангаа баяжуулах чиглэлээр нягт хамтран ажилладаг юм.

Бидний үйл ажиллагаандаа баримталдаг гол зарчим бол цөөхөн оюутан элсүүлэн авч, чанартай хуульчид бэлтгэн гаргах

явдал бөгөөд 1998-1999 оны хичээлийн жилд өдөр болон эчнээ ангид нийтдээ 330 оюутан суралцаж байна. Манай сургууль байгуулагдсанаасаа хойшхи 8 жилийн хугацаанд үндсэн ангийн дөрвөн удаагийн, эчнээ ангийн хоёр удаагийн төгсөлт хийсэн бөгөөд төгсөгчдийн 90 гаруй хувь нь мэргэжлээрээ хууль хамгаалах болон төрийн захиргааны байгууллагад үр бүтээлтэй ажиллаж байна. Үүний нэг нотолгоо бол манай төгсөгчдийн дотроос өнөөдрийн байдлаар найман хүн хууль зүйн ухааны магистрийн зэрэг хамгаалсан, 1998 онд явуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалт болон Улсын прокурорын газраас явуулсан системийн ажилтнуудын мэргэжлийн аттестачлалд манай төгсөгчид 100 хувийн амжилт үзүүлсэн явдал юм. Манай сургуулийг төгсөгчид хууль зүйн ухааныг судлаж хуульч мэргэжил эзэмшихийн сацуу, зах зээлийн эдийн засгийн болон гадаад хэлний зохих мэдлэгийг эзэмшдэг. Энэ бүхний үр дүнд өнөөдөр манай төгсөгчид хөдөлмөрийн зах зээл дээр өөрийн гэсэн нэр хүндтэй, зохих эрэлттэй боловсон хүчний нөөцөд зүй ёсоор тооцогддог болоод байгаа билээ.

Сургууль нь ашгийн төлөө бус сургалт, эрдэм шинжилгээний байгууллага болохын хувьд санхүүгийн эх үүсвэрээ цэвэр суралцагчдын сургалтын төлбөрөөс гарган авдаг бөгөөд сургалтын төлбөрийнхөө хэмжээг ижил төрлийн сургуулиудын жилийн төлбөрийн дундаж хэмжээнээс бага зэрэг доогуур тогтоох бодлогыг баримталдаг. 1998-1999 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг 300 000 төгрөгөөр тогтоосон юм.

Манай сургуулийн гадаад харилцаа зохих төвшинд хөгжсөн бөгөөд гадаад түншүүдтэйгээ тогтоосон харилцааныхаа хүрсэн төвшинг бататган, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүч анхаарал тавин ажиллаж байна. Бид ХБНГУ-ын Боннын Их Сургуулийн хуулийн салбар, ОХУ-ын Уралын Хууль Зүйн Академи, Унгар улсын Будапешт хотын Төв Европын Их Сургуулийн Хууль зүйн факультет, БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн хуулийн салбаруудтай холбоо тогтоон, хамтран ажиллаж байна. Тухайлбал, манай сургуулийг онцсайн дүнтэй төгссөн, герман хэлний зохих мэдлэгтэй оюутныг ХБНГУ-ын Боннын Их Сургуулийн хуулийн салбарт сургах боломжтой бөгөөд гадаадаас эрдэмтэн, багш, мэргэжилтнүүдийг урьж ажиллуулна. Соросын сангийн шугамаар манай багш нар Төв

Европын Их Сургуульд тогтмол явж мэргэжлээ дээшлүүлж байгаа бөгөөд одоо манай сургуулийн профессор Ч.Энхбаатар тэнд докторантурт суралцаж байна.

«Шихихутуг» ХЗДС нь өнгөрсөн хугацаанд эрдэм шинжилгээний ажлын талаар нилээд их амжилтанд хүрсэн гэж үздэг. Манай сургуулиас хууль зүйн их, дээд сургуульд суралцагсдад зориулан нилээд тооны ном, сурах бичиг, гарын авлага эрхлэн гаргасан юм. Үүнд:

Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар нарын «Үндсэн хуулийн эрх зүй», Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нарын «Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал», Д.Лүндээжанцан, Н.Жалбажав, Д.Отгонтуяа нарын «Эрх зүйн философи», Т.Мөнхжаргалын «Иргэний эрх зүй», «Үүргийн эрх зүй», Д.Лүндээжанцангийн «Экологийн эрх зүй: хууль тогтоомж, зөрчил, харуцлага», Н.Орёлын «Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын хичээлийн материалууд» зэрэг сурах бичиг болон гарын авлагуудыг нэрлэж болно.

Тус сургууль 1999-2000 оны хичээлийн жилд үндсэн ангид 60, эчнээ ангид 80 оюутан элсүүлэн авч сургах бөгөөд үндсэн ангид элсэгчдээс нийгмийн тухай мэдлэг, гадаад хэлний /орос, англи/ мэдлэг, эчнээ ангид элсэгчдээс Үндсэн хуулийн болон гадаад хэлний мэдлэгийн шалгалтыг тестээр авна. Манай сургуульд элсэгчдэд боловсролын хувьд үндсэн ангид элсэх бол бүрэн дунд боловсролтой байхыг, харин эчнээ ангид элсэгчдээс хууль зүйн тусгай дунд болон өөр мэргэжлээр бол дээд боловсролтой байхыг шаарддаг.

Бид цаашид сургуулийнхаа эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сургалт эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлж, сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэх, оюутны үйлчилгээг сургууль дээрээ үр дүнтэй зохион байгуулах, ашгийн төлөө бус зөвхөн оюутандаа чиглэсэн үйл ажиллагаа явуулж, гадаад харилцаагаа өргөжүүлэх зэрэг зорилтуудыг тавин ажиллаж байна.

Бидэнтэй холбоо барих болон хамтран ажиллахыг хүссэн хэн бүхнийг бид найрсагаар хүлээн авч, таны төлөө ажиллахдаа

хэзээд бэлэн бөгөөд энэ нь бидний хувьд нэр төрийн хэрэг, их хүндэтгэл болох учир бид туйлаас баяртай байх болно.

Манай хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ү хороо, Баруун 4-н зам, "Өгөөж" компанийн замын урд талд байрлах "Шихихутуг" ХЗДС-ийн хичээлийн байр. /хуучнаар «Соёмбо» УУГ-ын байр/

Утас: 323392, 320176

Цаг заваа зорнуулж, бидэнтэй танилцсан танд баярлалаа.

Таныг хүндэтгэсэн,



«Шихихутуг» ХЗДС-ийн захирал
Дамбадаржаагийн ОЮУНЦЭЦЭГ

УЛСЫН ДЭЭД ЗАРГАЧ ШИХИХУТУГ (1180-1262 он)

© 1999 он. Жигжидийн БОЛДБААТАР¹

Монгол улсын түүх, нэн ялангуяа дэлхийн талыг эзэгнэсэн Монгол их гүрний түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн хүн бол монгол төрийн гарамгай зүтгэлтэн, их бичгийн хүмүүн, цэргийн жанжин, улсын дээд заргач Шихихутуг юм. Монголын түүхийн сурвалж болон судалгааны зохиолуудад түүний нэрийг Шигихутаг, Шихихутаг, Шихихутуг гэх мэтээр янз янз тэмдэглэжээ.

Шихихутуг түүхийн ямар үед амьдарч байсан нь тодорхой боловч, чухам хэдэн онд мэндэлсэн нь өдгөө хүртэл тодорхой бус явж ирэв. Ираны нэрт түүхч Рашид-Аддин «Судрын чуулган» хэмээх алдарт бүтээлдээ Шихихутуг Аригбөхийн самууны үеэр 82 хүрч нас барсан² гэж тэмдэглэсэн буй. Аригбөхийн самуун гэж 1260-64 онд Хубилай, Аригбөх хоёрын хоорондын хаан ширээний төлөө явагдсан тэмцлийг хэлж байгаа бололтой. Ингэхлээр Шихихутуг 1260-1264 оны хооронд 82 настай байхдаа нас баржээ. Академич Ш.Бира үүнээс таацуулан бодож, Шихихутугийн төрсөн оныг 1180 он, нас барсан оныг 1262 он гэж ойролцоогоор гаргасанд бүрэн тал өгч болох юм. Үүнээс нарийвчлах боломж тун бага тул түүний төрсөн оныг 1180 он гэж үзэж, мэндэлсний нь 920 жилийн ойг 2000 он - шинэ зуун эхлэхэд тэмдэглэж болох бөлгөө. Шихихутугийн амьдралын Чингис хаантай холбогдсон үеийг ном зохиолд их төлөв 1190-ээд он гэж үзэж байна. Академич Ш.Нацагдоржийн «Чингис хааны цадиг»-т 1196 онд Татартай хийсэн тулалдааны үед, «Чингис хааны тухай товч тайлбар толь»-д 1190 онд Татар аймагтай байлдах үед Шихихутугийг Чингис хаан олж авсан гэж бичсэн байна. Ш.Нацагдорж: «... алтан ээмэгтэй, булган дотортой эрүүвч өмссөн нэг бяцхан хөвүүнийг Чингисийн цэрэг олж аваад Чингист авчирч өргөжээ. Тэр хөвүүний байдал төрх ерийн хүнээс их л өөр учир Чингис Өүлэн эхдээ асруулан тэжээлгэхээр өгсөн байна. Өүлэн эх тэр хөвүүнийг сайн хүний үр гэж үзэж, таван хөвүүнийхээ дүү зургадугаар хөвүүн

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Цэгийн гишүүн, МУИС-ийн тэргүүлэгч профессор, түүхийн шинжлэх ухааны доктор.

болгоё гэж шийджээ. Тэгээд Шихихутуг гэж нэр өгчээ»¹ хэмээн тэмдэглэжээ. Харин Рашид-Аддин «Татаар угсаатныг хоосруулж байх тэр үед Чингис хаан бас л хүүхэдгүй байсан, түүний авааль гэргий Бөртэ үжин хүүхэдтэй болохыг хүсдэг байжээ. Чингис хаан замын хажууд унасан хүүхдийг гэнэт хараад өргөн авч, Бөртэ үжинд өгч явуулан: «Чи хүүхэдтэй болох гэж байнга хүсч байдаг болохоор өөрийн хүүхдийн оронд энэ хүүхдийг хүмүүжүүлж хайрла» гэжээ. Гэргий нь түүнийг төрсөн хүү шигээ гэр бүлдээ бүрэн хүндэтгэн, нэр төртэй хүмүүжүүлсэн билээ. Түүнийг өсөхөөр нь Шигихутуг гэсэн мөн Хутуг ноён гэж нэрлэдэг. Тэр Чингис хааныг эцэг, Бөртэ үжинийг тэргүүн эх гэж нэрлэдэг байв. Бөртэ үжин нас барахад тэр түүний авсыг гараараа дэлдэн «Ээ, сайн ээж минь» гэж хэлэн, цурхиран уйлж байсан гэж ярилцдаг» хэмээн бичсэн байна. Шигихутуг нэрийн тухайд Шиги гэдэг нь чигчий хуруу мэт бяцхан, хутуг гэдэг нь хурц ухаан гэсэн үг гэж зарим эрдэмтэд тайлбарласан байдаг. Гэтэл 1200 оны орчим Чингис хаан Тайчуудтай байддахад Шихихутуг хэдийнээ эрийн цээнд хүрсэнээр барахгүй, хааны итгэлт сайдын нэг болж, дайсангай баатарлагаар тулалдан магтуулж байсан тухай «Монголын нууц товчоон»-д өгүүлсэн байна. Чингис хаан Чахарай ханыг арлаж, Жалман ханыг өлгийлж явтал эзний дороос халтар тэх харайн гүйхэд нь харван авлажээ. Эзнийхээ авласан ангийн хишгийг авч ганзаглах гэтэл тэрбээр: «Үүнийг та нар үтэр өвчиж шар. Би тэр Шар дэвсэг дээр гарч бараа харъя» гээд одов. Тэнд эзний ноёр хүрч, толбот бор морины дэл дээр ташуураа тулж унтаад, нэг зүүд зүүдлэв. Чингис хаан сэрээд зургаан сайддаа ирж зарлиг болруун:

«Би нэг зүүд зүүдлэв.

Бор зүрх минь

Бол бол хийв

Богино хавирга минь

Шир шир хийв.

Болшгүй дайсан

Ирэх нь бололтой.. » хэмээгээд «Энэ зүүд минь хэрэв

үзэн бол зургаан сайд минь та нар яахав?» гэж асуухад тэдний дотроос Шихихутуг хэлэв:

«Хол ойрыг харагч

Хоёр хурц нүдээрээ

Монгол аймгийг

Мохтол

Мэргид аймгийг

Мэгэртэй
 Тэгчүүд амтгийг
 Дэлхийтэй
 Сарын гэсрэг
 Саравчлан харж
 Жингийн гэсрэг
 Жигзвчсэн үзэж
 Хар нүдний цэцгийнээр
 Хан яамтаа тусалга
 Эрхч нүдний харуулар
 Эзэн яамтаа тусалга гэжээ. Түүний дараа бусад сайд
 нар нь ч эзэнцээ үнэнч зүтгэхээ танигараглажээ. Чингис хаан:
 Шилцэг зургаан сайгийн
 Шиндээртэй үгийг соноож
 Шарсан тэхийн кахнаас
 Шаламтайлан нүгж лугсаал
 Шаргал моринь цубуурыг
 Шинхихүлгт өгч
 «Үсэн зүүлийн минь
 Үнэн хуулыг мэд» гэж явуулав.
 Шинхихүлгт шунхан шаргал моринь нь унаал
 Тал газар тавилж
 Тайга газар агилж
 Хөндий газар хатирүүлж
 Хөвч газар сажилуулж
 Шар тэвсэгт хүрээл
 Шалгаж сайтар харвал
 Бараан тугийг хийгсээн
 Балмаг дайснаг персэг
 Баямат тулгарахал
 Баятар Шинхихүлг
 Байсан газрын зүг
 Баямтан давхж ирсээ:
 «Шар тэвсэгт дээр
 Цочмог гарч очвол
 Турван зуун дайсангай
 Бачмаг тулгарч уулзвал
 Мэргийнх мэдсэнгүй
 Монголыг

Мохтол харж чадсангүй. Хойшоо ганцхан хяламхийн үзэхэд, эзний зүүдэнд үзсэн дайсантай адил мэт байна» гэжээ. Ойртон ирэхэд нь харвал Тайчууд мөн байсан тул тулалдан зуун хүнийг цавчин алж, хоёр зуун хүнийг дутаалгажээ. Энэ байлдаанд зуун морь, тавин хуяг олзлон авчээ. Эзэн зургаан сайдаа магтан дуулсны дотор:

«Мэргидийг мэгдүүлж
Монголыг мохоож
Тайчуудыг таньж
Дайсныг даралцсан
Татаарын Шигихутуг минь»⁴ гэжээ.

Түүнчлэн билгийн тооллын улаан барс жил - 1206 онд Их Монгол улс байгуулагдсаны дараа Чингис хаан хамтран зүтгэгсэддээ соёрхол хишиг хүртээхэд Шигихутугийн хэлсэн үг түүний алтан ургийнхтай холбогдсон түүх цадигийг тодотгох тухайд нэгийг өгүүллээ. «Монголын нууц товчоон»-ы 203-р зүйлд: Бас Чингис хаан хүргэдийн хамт эдгээр ерэн таван мянганы ноёдыг томилоод тэр дотор зарлиг болруун: «Өмөг туст нөхдөлөө өөр соёрхлыг өгье. Боорчи, Мухулай тэргүүтэн бусад ноёдыг ирүүлгүгэй» гэж гэр дотор байсан Шигихутугийг «Тэднийг урьж авчир» гэсэнд Шигихутуг өгүүллрүүн:

«Боорчи, Мухулай нар
Булт биднээс
Их тусалж
Илүү зүтгэсэн үү?
Тэмдэглэн соёрхоход
Тэдниэс би
Дутуу тусалж
Ядуу зүтгэсэн үү?
Өлгийтэй цагаасаа би
Өндөр босгы чинь түшиж
Өдий их сахалтай
Өвгөн буурал болтлоо
Өөр санаа санасангүй
Өршөөлд чинь багтсаар ирэв
Алмай бага наснаасаа би
Алтан босгы чинь түшиж
Амандаа өдий сахалтай
Ахмад настай болтлоо

Алжааж бэрхшээсэн зүйлгүй
Аль чадахаар зүтгэв.
Хөлдөө хэвтүүлж
Хөнжилдөө хучиж
Хөвүүн адилаар
Хүмүүжүүлэв намайг
Дэргэдээ хэвтүүлж
Дээлдээ хучиж
Дүү мэтээр
Түшиж өсгөв.

Одоо надад ямар соёрхлыг хайрлах вэ¹ гэж асуусан байна. Чингэхлээр 1200 оны орчим Чингис хаан Тайчуудтай байлдахад эрийн цээнд хүрсэн төдийгүй итгэлт сайд нь болсон, 1206 онд хишиг соёрхол хүртээхэд Шихихутуг өөрийгөө «өдий их сахалтай, өвгөн буурал болтлоо», «амандаа өдий сахалтай, ахмад настай болтлоо» гэх мэтээр хэтрүүлэл, зүйрлэл ихтэй хэлж байгаагаас харахад 1190-ээд оны орчим явч 5, 6 настай хөвгүүн Өүлэн эхийн юмуу, эсвэл Бөртэ үжиний асрамжинд ирээгүй бололтой. Түүнчлэн Шихихутуг 82 насандаа зарга шүүж, Хубилайн хаанчлалын эхний жилүүдэд насан өөд болсоноос үзэхэд тэрбээр XIII зууны босго алхахад лав л 20 орчим настай байсан байж таарна. Иймээс Шихихутуг 5, 6 настай байхдаа олзлогдсон бол 1180-аад оны дундуур, хэрэв 1190-ээд онд олзлогдсон бол 10 гаруй настай хөвгүүн байсан гэж үзэж болохоор байна.

Сурвалж бичиг, ном зохиолд Шихихутугийн сэргэлэн цовоо, авхаалж самбаатай баатарлаг хөвгүүн байсныг 12 настай үеэс нь эхлэн тэмдэглэсэн баримт тааралдаж байна. Тухайлбал, Рашид-Аддин «Судрын чуулган»-даа: «Нэлээд түрүүн Хутуг арван хоёр настай байхад нэг удаа Чингис хаан аян дайнд яваад гэрт нь эрэгтэй хүн үлдсэнгүй. Тайчууд аймгийн харъяаны дайсан болох нэг морьтой хүн хажуугаар өнгөрөхөд Чингисийн отгон хүү таван настай (Тулуй) хүү гэрийн гадуур гүйн тоглож байв. Тэр тайчууд хүн морин дээрээсээ бөхийн хүүг шүүрэн авч, толгойг нь сугандаа хавчуулан авч явах гэсэн, хүүгийн эх гүйн ирж хулгайчийн нэг гараас барьж, Хутуг нөгөө гарыг нь барьж авсан боловч, хулгайч хүүгийн толгойг чанга хавчсан болохоор түүнийг хулгайгаас салган авч огт дийлэхгүй байжээ. Хонь дагаж явсан Барака нохой үрэн хулгайчид халдахад хүүг түүний гараас салгаж авсан. Үүний

дараахан Чингис хаан ирээд хулгайчийн мөрөөр явж, олж аваад алжээ. Хулгайчтай тэмцэж эрэлхэг зориг гаргасанд Хутугийг маш их сайшаасан байна»⁶ гэжээ.

Шихихутуг Чингис хааны орд өргөөнөө Өүлэн эх, Бөртэ үжиний гар дээр өсөж өндийхдөө өдөр ирэх тутам ухаан тод, бас цэгц болохоо мэдрүүлж, моринд гарамгай, харваж намнахдаа цэц мэргэн, сэтгэл шулуун, зориг чанга болсоор байлаа. «Судрын чуулган»-ы бас нэгэн баримт дурдъя.

Өвөл Чингис хааны ордон нүүж байхад тэр арван таван настай байсан. Тэсхийм хүйтэн, давшгүй их цастай байлаа. Ийсут аймгийн Кучукур (Хүчүгэр) ноён ордныг даргалж байлаа. Гэнэт замын хажуугаар хунгар цасан дундуур сүрэг янгир гүйн өнгөрөхөд Хутуг Кучукурт «Эдгээр янгир их цасанд зугтаж чадахгүй, ингэхлээр би тэдгээрийг хөөн гүйцэж харвасугай» гэжээ. Кучукур «За яахав, болноо» гэжээ. Тэрбээр тэдгээр янгирыг хөөн одсон байна. Шөнө ордон хоноглохоор буугаад байхад Чингис хаан түүнийг дуудахад ирсэнгүй. Кучукураас түүнийг асуухад «Янгир хөөгөөд явчихсан» гэжээ. Чингис хаан асар их уурлан: «Ийм цас жаварт тэр хүү амь алдана» гээд Кучукурыг тэрэгний модоор цохьсон байна. Унтахаар хэвтэж байхад Хутуг иржээ. «Чи юу хийв?» гэж Чингис хаан түүнээс асуухад «Гучаад янгираас гурваас илүү нь зугатаж чадсангүй, бусды нь бүгдийг би алаад цасанд хаячихлаа» гэж харилджээ. Чингис хаан энэ хүүгийн эрэлхэгийг ихэд гайхжээ. Чингээд тэдгээр янгирыг авчруулахаар Кучукурыг хэдэн нөхөдтэй явуулжээ. Чингис хаан ийм шалтгаанаар Хутугт элэгсэг хайртай байсан аж. Ийнхүү Шихихутуг 15 настайдаа хэдийнээ харваж намнахдаа маш мэргэн цэцэн эрэлхэг дайчин болсон байв. Өвөр Монголын судлаач Алтаншва «Монголчуудын өчигдөрийн мөр» номондоо утга ижил боловч, арай өөр хувилбарыг тэмдэглэсэн байна. Үүнийг сийрүүлдэл: Нэг их цастай өдөр Шигихутуг сүрэг бугыг үзэж, хөөн намнасаар үдэш орой болтол буцаж ирсэнгүй тул Чингис хаан Хүчүгэрээс Шигихутагийг асуусанд Хүчүгэр: «Буга намнаад буцаж ирээгүй байна» гэв. Чингис хаан эс итгээд Хүчүгэрийг ташуурдах гэж байтал Шигихутаг буцаж ирээд: «30 бугатай тааралдаж 27-г нь харваж алав» гэжээ. Маргааш нь үнэхээр тэдгээр буга цасанд хэвтэж байхыг үзээд Чингис хаан ихэд гайхжээ.⁷ Ингээд Шихихутуг удалгүй эрийн цээнд хүрч, монгол

олон овог, аймгуудыг нэгтгэх Тэмүжиний тэмцэлд оройлон оролцож, амь огоорон зүтгэх болсныг өмнө дурьдсан «Нууц товчоон»-ы зарим баримтаас харж болно.

Шихихутуг 1206 онд Их Монгол улс байгуулагдахад улсын дээд заргачаар томилогджээ. «Монголын нууц товчоон»-д «... Чингис хаан, Шигихутугт өгүүлрүүн: «Чи миний зургадугаар дүү биш үү? Өргөмөл дүү чамд өөрийн дүү нарын адилаар өмч хувийг олгоё. Бас чиний хүргэсэн ач тусыг бодож, есөн ослыг хэлтрүүлэх болгоё» гэж зарлиг болов. «Мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохинуулж байхад чи, үзэх нүд, сонсох чих болж яв. Бидний эх ба дүү нар, хөвүүдэд эсгий туургатны дотроос эдлэх хувийг олгож, хавтсан үүдэтний дотроос харъяалах ардыг хувааж өг. Чиний тушаасан үгийг хэн ч өөрчилж үл болно» гэж зарлиг болов. Бас Шигихутугийг «Бүх улсын доторх хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, ялах ёстойг ялаж бай» гэж бүх улсын дээд заргач (шүүгч) болгов. Бас «Нийт улсын өмчийг хувааж, заргыг шийтгэж, түүнийгээ хөх дэвтэрт бичиж дэвтэрлэгтүн. Надтай зөвлөж, Шигихутагийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүгэй» гэж зарлиг болов. Шигихутуг өгүүлрүүн: «Миний мэтийн оргодол (өргөмөл) дүү, хааны дүүтэй адилаар хувь өмч авч яаж болох вэ? Хаан соёрхвол, байшин гэртэй, балгас хотын иргэдээс авъя» гэж өчвөл, «Чи өөрөө энэ хэргийг зүтгэж шийтгэх тул өөрөө мэдэж гүйцэтгэ» гэв»⁴ хэмээжээ. «Нууц товчоон»-ы энэ мэдээнээс үзвэл, улсын дээд заргач Шихихутуг нь:

-Хаанд зөвлөн, хааны нэрийн өмнөөс шүүн таслах ажиллагаа явуулах;

-Төрийн байгууллага, иргэдийн хуулиар зөвшөөрөгдсөн ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх;

-Хаан төрийн «үзэх нүд, сонсох чих» болж, улс үндэснийхээ аюулгүй байдлыг сахин хамгаалах;

-Бичмэл хууль цааз боловсруулж, хаанаар батлуулан мөрдөх зэрэг үүрэгтэй байжээ.

Улсын дээд заргач Шихихутуг Их Монгол улсын төрийн дотоод, гадаад чиг үүргийг чандлан хэрэгжүүлэх үйлсэд хичээнгүйлэн хүчин зүтгэж эхэлжээ. Тэрбээр цэргийн жанжны

хувьд Чингис хааны дорно, өрнө зүг хийсэн аян дайнд оролцов. Тухайлбал, 1216 онд Чингис хаан Алтан улсыг байлдан дайлаад, нийслэл хот Зүндү балгасын алт, мөнгө, ад агуурс, юмыг тоолуулахаар Шигихутуг, Үнгүр буурч, Архай Хасар гурвыг илгээжээ. Алтан улсын хаан Зүндү хотоос зайлахдаа Хада нэртэй ноёнд уг хотыг хариуцуулан орхисон аж. Шигихутуг нарыг хүрэлцэн очиход Хада ноён угтаж, алттай, хээтэй эд агуурсыг барьж хот дотроос гарч уулзсан байна. Хадад Шигихутуг өгүүдрүүн: «Урьд эн Жунду хот ба Жундугийн эд юм Алтан хааных байв. Одоо Жунду Чингис хааных болов. Чингис хааны эд агуурсыг чи яагаад далдуур хулгайлан авчирч өгч байна. Үүнийг би авахгүй?» гэж Шигихутуг эс авав. Үнгүр буурч, Архай Хасар хоёр авав. Энэ гурав Жундугийн юмыг тоолж ирэв. Тэнд Чингис хаан Үнгүр, Архай, Шигихутуг гурваас «Хада юу өгөв?» гэж асуувал Шигихутуг өгүүдрүүн: «Алттай, хээтэй эд агуурсыг авчирч өгөв. Миний хэлсэн нь: «Урьд энэ Жунду Алтан хааных байв. Одоо Чингис хааных болов. Хада чи, Чингис хааны эд юмыг далдуур хулгайлж яахин өгнө?» гэж би эс авав. Үнгүр, Архай хоёр, өгсний нь авлаа» гэв. Тэгэхэд Чингис хаан, Үнгүр Архай хоёрыг маш буруушаан донгодов. Шигихутугийг «Чи их ёсыг сэтгэжээ» гэж маш сайшаан соёрхож, «Чи миний үзэх нүд, сонсох чих бишүү» гэж зарлиг болгожээ.⁵ Ийнхүү монголын төр ёсонд хаан, төрийн өмчийг хайрлан арвижуулах «их ёс»-ны үндэс тавигджээ.

Гадаад байдлаа төвшитгөх зорилгоор Чингис хааны өрнө зүг хийсэн аян дайнд Шигихутуг голлох үүрэгтэй оролцож, Дундат Азид ялгуусан алдраа мандуулж, бас ялагдан дийлэгдэхийн сургамжийг ч авч байжээ. 1221 оны хавар Чингис болон Тулуйн цэрэг аян дайнаа үргэлжлүүлэхээр хөдлөх гэж байгаад Зебильстанд бэлтгэл хүч болгон суулгасан салаа цэргийг Хорезмийн шах Желал-Аддин бут цохиж устгасан тухай мэдээ авчээ. Ингээд Чингис хаан Шигихутугт гурван түмэн цэрэг өгч, манлай болгон нэгд, Желал-Аддиныг тагнах, хоёрт, их цэргийн аяныг хамгаалуулах үүрэгтэйгээр Зебильстан, Кабулын уулархаг нутагт томилжээ.¹⁶ Тэгээд Шигихутуг Парван тосгоны орчим Желал-Аддины долоон түмэн цэрэгтэй тулгаран байлджээ. Хоёр этгээд өдөр турш ширүүн тулалдсан боловч хэн нь ч дийлсэнгүй. Тэр шөнө Шигихутуг олон агтын нуруунд эсгий хөдсөөр үйлдсэн мануухай унуулан эсрэг этгээддээ нэмэлт хүч ирсэн мэтээр ойлгуулах арга сэджээ. Султаны цэрэг ч түүнд итгэж айн

балмагджээ. Гэвч Желал-Аддин үхэх сэхэхээ үзэлцэхээр зориглон шийдэж, цэргүүддээ: «Дайсны цэрэг олон боловч, айх хэрэггүй. Хоёр гардан байлдаж, ороон бүсэлж устгагтун!» гэсэн тушаал өгчээ. Шихихутуг эл ширүүн тулалдаанд цэргийнхээ хагас итүүг алдаж ялагдан, зам буруулжээ.

Чингис хаан Шихихутуг айн ялагдсан тухай мэдээг аваад онц ундуудаж хилэгнэсэнгүй. Түүнийг буцаж ирсэний дараа их хаан: «Өнгөрсөнд чн ер дайсанд дийлэгдэж үзээгүй тул өмгөрхог бардам болжээ. Энэ удаагийн ялагдлаас сургамж авбал зохино» гэсэн гэдэг. Тэгээд Чингис хаан өөрийн биеэр цэрэг авч, Желал-Аддиныг нэхэн хөөжээ. Замдаа Шихихутугийн ялагдсан газар ирж, хоёр этгээдийн цэрэг байрлуулан байлдсан газрыг байцааж үзээд: «Газрын байцыг муу сонголоо» гэж Шихихутугийг буруушаан зэмлэсэн аж.

Шихихутуг Өгөдэйн хаанчлалын үед ч Монголын төрд хүндтэй байр эзлэн, хааныхаа гол түшиг, дотнын нөхөр болж байв. Өгөдэй хаан түүнийг «Ахаа» хэмээн хүндэтгэн дуудаж, хожим хаан болсон Мөнхийн дээд талын суудалд суулгадаг байжээ. 1230 онд Өгөдэй хаан Умарт Хятадыг дайлахаар мордохдоо Шихихутугийг авч явжээ. Тэрбээр баруун гарын цэргийг захирсан Тулуй ноёны зөвлөх жанжнаар энэ дайнд оролцсон байна. Тэд 200 мянган цэрэг бүхий хамгаалалтын шугамын гол цэг - Тунгуань боомтонд хүрч очжээ. Энд Алтан улсын жанжин Хада их цэрэгтэйгээ уулын энгэрт модон хүрээ байгуулан, монгол цэрэгтэй эрэгчин эмэгчинээ үзэлцэхээр хүлээж байв. Эл байдлыг Тулуй олж мэдээд Шихихутугийг дуудаж: «Тунгуань боомт бол дөрвөн талаараа уул хайрханаар бүслэгдсэн бэрх бартаат газар болох бөгөөд Алтан улсын цэрэг ч уул энгэрт модон хүрээ татаад байлдахаар хүлээж байгаа тул бид заавал тэднийг өдөөн гаргаж ирээд байлдвал сая дийлж чадна. Иймээс чн 300 морьт цэрэг авч өдөржин, шөнөжин Тунгуань боомтыг өдөөн байлдагтун!» гэж тушаажээ. Шигихутуг шилдэг гавшгай 300 морьт цэргээн авч хэдэн өдөр өдөөн байлдсан боловч, Алтан улсын цэрэг хүн хүч ихдээн бардамнаад ер ойшоох ч үгүй байжээ. Иймд Тулуй: «Алтан улсын цэрэг уг орноосоо хөдлөхгүй бол бид байлдаж үл болно. Бид хойш ухарвал тэд улам омогших болно. Иймээс бид Алтан улсын нийслэл хотыг байлдан эзлэлбэл Тунгуань боомт аяндаан бууж өгөх болно» гэж хэлээд Шигихутугт цөөн тооны цэргийг үлдээн өгөөд, өөрөөн их цэргийг

авч, Бянь (Кайфин) хотыг эзлэхээр мордсон аж. Тийнхүү хэдэн өдөр өнгөртөл монголын цэрэг нэг ч үзэгдэхгүй болсон тул Хада их цэргээн авч араас нь нэхэмжлэхээр хөдөлжээ. Энэ үед Шигихутугийн захирсан цөөн тооны шидцэг морьт цэрэг сүүлдэн дагаад, Хадын цэргийг байлдах гэвэл Шигихутугийн цэрэг дутааж, Хадын цэргийг амдах гэвэл Шигихутугийн цэрэг байлдаж, өчүүхэн ч амруулахгүй үймүүлж байв. Хадын цэрэг энэ мэтээр хэдэн шөнө, хэдэн өдөр нойр хоолгүй аялаад, нэгэн сүрлэг уулын ойролцоо хүрч иртэл Өгөдэй хааны цэрэг голын хойт талаас хүрэлцэн ирж, Тулуйн цэрэг лүгээ нийлээд хоёр талаас нь хавчин байлдаж, бүх цэргийг нь бут ниргэжээ.

1234 онд Өгөдэй хаан Алтан улсыг бүрэн эзэлж аваад, Шигихутугийг дотор газрын захирагчаар томилсон байна. Тэрбээр 140 түм гаруй хятад өрх амыг данслан, тохинуулаад эх нутагтаа буцаж иржээ.

Чингис хаан болон Өгөдэй хааны үед Шигихутуг улсын дээд заргачаар өргөмжлөгдөж, «Дэлхий дахины ард иргэдэд их хишгийг түгээмэл хүртээгээд», Гүжог хийгээд Мөнх хааны төрд шударгаар үйлчилж, Хубилай хааны үед өтөл буурал насандаа хан хорвоогоос халин оджээ.

Шигихутуг насан огштлоо Монголын төр, цааз эрхэмжийг бэхжүүлэх үйлсэд чин журмыг барин хүчин зүтгэж, эзэнт гүрэн даяар бишрэл хүндэтгэлийг хүлээж байсан бөлгөө. Ираны алдарт түүхч Рашид-Аддин: «Тэр наян хоёр настайдаа заргыг шударгаар шүүж, ялтнуудад их туслаж, энэрч байжээ. Тэр «Айж, цочин хэрэг хүлээх хэрэггүй» гэж нэг биш удаа давтан хэлдэг байсан. «Айлтгүй үнэнээ хэл» гэж хэрэгтэн нарт хэлдэг байсан. Тэр үеэс одоо хүртэл Могулистанд ч, бусад нутагт ч түүний арга, барилын зарчмыг шүүхийн шийдвэрийн үндэс болгодог нь заргачдын (шүүгчдийн) маргаанаас тодорхой байна»¹¹ гэж тэмдэглэсэн байна.

Шигихутуг хуулийг дээдлэн, шударга, энэрэнгүй зарчим баримтлаж, шүүн таслах үйл ажиллагаандаа өөрийн гэсэн арга маяг, дэг сургуулийг бий болгожээ. Энэ дэг сургуулиар Монгол болон бүх орны заргач (шүүгч) нар ажиллаж байжээ. Шигихутуг Мөнх хааны үеийн нэрт шүүгч Мөнхсар ноён, Хубилай хааны

үеийн шүүгч Байжу, түүнчлэн олон хятад түшмэлийг өөрийн гараар сурган бэлтгэсэн аж.

Шихихутуг Монгол төрийн хууль цааз, түүхийн олон баримт бичгийг зохион боловсруулсан их бичгийн хүн байсан бололтой. «Нууц товчоон»-ы мэдээнээс үзэхэд, Шихихутуг «Их засаг» хуулийг анхлан боловсруулахад томоохон үүрэг гүйцэтгэсэн нь маргаангүй юм. Энэ утгаар нь түүнийг академич Ч.Жүгдэр: «... монголын хууль зүйн сэтгэлгээний анхны том төлөөлөгчийн нэг»¹² хэмээн тэмдэглэжээ. Бас зарим судлаачид Шихихутуг «Монголын нууц товчоо»-г зохиосон байж магадгүй хэмээх сонирхолтой таамаглал дэвшүүлсэн үзэгдэнэ.

Академич Ш.Бира: «Шихихутуг үнэхээр Монголын хууль цаазны гарамгай зүтгэлтэн, монгол төрийн агуу их түшээ байсан»¹³ гэж үнэлжээ. Тиймээ, Шихихутуг бол төрийг засах, цааз эрхэмжийг тогтоож, хэрэгжүүлэх, цэргийн стратеги, тактикийг хөгжүүлэх үйл хэрэгт насыг зарж, билэг ухаан, нөр их туршлагаараа тодрон товойсон монгол төрийн сэцэн билэгт гарамгай зүтгэлтэн байсан бөлгөө.

¹ Рашид-Аддин. Судрын чуулган. I боть, I дэвтэр. (Орчуулсан Ц.Сүрэнхорлоо) УБ., 1994. 61 дэх тал.

² Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ., 1991. 60 дахь тал.

³ Монголын нууц товчоо. УБ., 1976. 96 дахь тал.

⁴ Монголын нууц товчоо. УБ., 1976. 167 дахь тал.

⁵ Рашид-Аддин. Судрын чуулган. I боть, I дэвтэр. (Орчуулсан Ц.Сүрэнхорлоо) УБ., 1994. 62 дахь тал.

⁷ Алтаншаа. Монголчуудын өчигдөрийн мөр. Тэргүүн дэвтэр. 216-217 дахь тал.

⁸ Монголын нууц товчоо. УБ., 1976. 167-168 дахь тал.

⁹ Монголын нууц товчоо. УБ., 1976. 210-211 дэх тал.

¹⁰ Монгол цэргийн түүхийн товчоон. Тэргүүн дэвтэр. УБ., 1996. 239 дэх тал.

¹¹ Рашид-Аддин. Судрын чуулган. I боть, I дэвтэр. (Орчуулсан Ц.Сүрэнхорлоо) УБ., 1994. 61 дэх тал.

¹² Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухаанн сэтгэлгээ. УБ., 1987. 127 дахь тал.

¹³ BULLETIN. The IAMS News Information on Mongol Studies. 1997. №2 (20), 1998. №1 (21). p. 76.

ХҮНИЙ ЭРХ ХУУЛЬЧИЛСНААР АЯНДАА ХЭРЭГЖДЭГҮЙ

© 1999 он. Галдангийн СОВД¹

Монголын ард түмэн төрт ёсны түүхэн 2000 гаруй жилийн туршид дэлхийн бусад орны ард түмний нэгэн адил хүний эрх, эрх чөлөөний төлөө тэмцсээр иржээ.

Их Монгол улсыг эмхлэн байгуулагч Чингис хааныг бага байхад эцгийг нь хорлон егүүтгэж өнчрүүлснээс эхлээд эх, дүү нарынхаа хамт нутагт хаягдаж, сүүдрээс өөр нөхөргүй, сүүлнээс өөр ташуургүй болж, өвс үндсээр өл залгаж байсан өлсгөлөн амьдралын он жилүүд, Тайчуудад баригдан эрүү шүүлт тулгуулж, дөнгөлүүлэн тарчлаж байсан цаг мөч, найман шарга морио гэгээн цагаан өдрөөр дээрэмдүүлж байсан зэрэг нь өөрийн болон эх, дүү нарынхаа эрхийг тэмцлээс өөр аргаар хамгаалах аргагүйн тухай анхны сэдэвт бүрдүүлсэн нөхцөл байдлууд болсон нь эргэлзээгүй биз ээ.

Есөн настай Тэмүүжин хүү эцэг Есүхэй баатрыг Татаруудад хорлогдож амиа алдсаныг үзээд гашуудан унасан үед тэнд байсан Чирха өвгөн түүнийг сэргээж:

Тул загас мэт юунд

Тулбарин гаслана чи?

Туурга цэргээ /торгон цэргээ/ бэхжүүлье гэж

Туйлтай үгээ хэлэлцсэн биш билүү?

Усны загас мэт юунд

Ужран гаслана чи

Улс төрөө байгуулья гэж

Учиртай үгээ хэлэлцсэн биш билүү?² гэж сургамжлаж байсан нь ирээдүйн их хааны энэ бие, элгэн садныхаа эрхээс эхлээд улс үндэстнийхээ эрх, эрх чөлөөний төлөө тэмцэх ёстойг аавынх нь алтан шарил дээр андгай болгон гэрээслэсэн сургаал гэж үзэх үндэстэй. Их Монгол улсын ерөнхий заргач (шүүгч) Шигихутугт эзэн хаан Чингисийн итгэлийг хүлээх шударга чанар нь балчир настай өчүүхэн хүү байх үедээ дайны хөлд нэрвэгдэж, цус урсаж,

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дарга асан, «Шигихутуг» ХЗДС-ийн зөвлөх багш, хууль зүйн ухааны догтор, профессор.

нурам болсон нутагт хэний үр сад болох нь мэдэгдэхгүй хаягдаж өнчин хоцорсон гашуун зовлон түүнийг хүний эрхийн төлөө тэмцэгч болоход нөлөөлснийг үгүйсгэх аргагүй.

Тэр эрт цагаас хойш дундад зууны үеийн гадаад, дотоодын зээрхэг нарын эсрэг монголчуудын гаргаж байсан бослого, хөдөлгөөнүүд бүгд хүний эрх, эрх чөлөөний төлөө эцсийн зорилготой байсан. Эдгээрийн тод жишээ бол Манжийн колончлогчдын харгис дэглэмийг эсэргүүцэж 1755-1758 онуудад Ойрд Монголд ноён Амарсанаа, Халх Монголд Хотгойд Цингунзав нарын удирдаж нэг зэрэг гарсан бослого, ХХ зууны эхэн үед баруун Монголд гарсан Ард Аюушын бослого зэрэг олон тэмцлүүд нь зөвхөн Манжийн дарлалыг эсэргүүцсэнээр хязгаарлаагүй, дотоодын дарангуйлагч ноёд дээдсийн хэмжээгүй эрх, дархын эсрэг чиглэн өргөжсөөр улмаар 1911 оны Үндэсний эрх чөлөөний төлөө хувьсгалд хүргэсэн байна.

Хүний эрхийн төлөө гарч байсан дээрх тэмцлүүдийн үр дүн нь тухайн цаг үеийн нөхцөл байдлуудаас шалтгаалж хүний эрхийн асуудалд онцмын үр дүн авч ирээгүй боловч эдгээр тэмцлүүдийн Монголын түүхэнд оруулсан түгээмэл үнэлэмж бол хүний эрх, эрх чөлөөг хязгаарлагч нь хатуу, харгис засаг төрийн дарангуйлал байдаг гэдгийг баталж өгсөнд оршино.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1948 оны 12-р сарын 10-нд баталсан «Хүний эрхийн түгээмэл Тунхаглал»-ын оршил хэсгийн 3 дугаарт «Хүмүүс эзэрхэг засаглал, дарлалын эсрэг өөрийн эрхгүй эцсийн арга болгон зэвсэглэн босоход хүрдэгийг анхааран» тэмдэглэн байдаг.

Хүний эрхийн төлөө Монголын ард түмний олон үеийн тэмцэл нь 1921 оны ардын хувьсгалын ялалтад хүргэсэн бөгөөд түүний үр дүн нь 1924 онд Монголын түүхэнд анх удаа Үндсэн хууль баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласан явдал билээ. Үндсэн хууль гэдэг бол хүн төрөлхтний түүхэнд гарч байсан хүний эрхийн төлөө тэмцлийн үр дүнд буй болсон соёлын үнэт зүйл бөгөөд юуны өмнө хүн, төр хоёрын харилцааг зохицуулах үндсэн чиг үүрэгтэй хууль зүйн үйлчилгээний хувьд хамгийн дээд хүчинтэй хууль зүйн хэм хэмжээний цогц юм.

Үндсэн хууль болон Үндсэн хуульт ёсны үүсэл хөгжлийн үндсийн үндэс нь хүний эрхийн тухай асуудал байсаар ирсэн. «Үндсэн хуулийг буй болгосон гол үзэл санаа бол хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг юуны өмнө төрийн засаглалын дур зоргоос хамгаалахад оршино».³

1924 оны 11-р сарын 26-ны өдөр Улсын анхдугаар Их Хурлаар баталсан Монголын анхны Үндсэн хууль бол Монгол Улсын төрт ёсны түүхэнд анх удаа буй болсноороо хүний эрхийн тухай асуудлыг хуулийн дээд хүчин чадалтай актаар хамгаалахаар тунхаглан зарласан юм.

Монгол Улсын Анхдугаар Үндсэн хуульд хүний эрхийн тухай асуудлыг нэгдүгээр бүлгийнхээ 3 дугаар зүйлийн 6-11 дахь хэсгүүдэл:

1/ шүтэх, итгэх; 2/ элдэв хэргийг шүүмжлэн хэлэлцэх; 3/ хуралдах, цэнгэх, баяр үйлдэх; 4/ эвлэл, хоршоо байгуулах; 5/ эрдэм, соёлд боловсрох; 6/ угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй ялгаваргүй адил эрхийг эдлэх гэсэн дараалалтай хуульчилан тунхагласан байна. Энэ бүгдээс үзэхэд монголын анхдугаар Үндсэн хуульд хүний эрхийн асуудлыг 1789 онд баталсан Францын хүний болон иргэний эрхийн тунхаглалд үндэслэн тухайн үед Европод тогтсон Үндсэн хуульт ёсны соёл иргэншлийн түвшинд Монголд эрт дээр үеэс уламжлан ирсэн үүрэгт тулгуурласан хүний эрхийн соёлд нийцүүлэн хуульчилсанд түүний соёл гэгээрүүлэх ач холбогдол оршино. БНМАУ-ын 1940 онд шинэчлэн найруулсан Үндсэн хуулийн аравдугаар бүлгийн 89-100 дугаар зүйлүүдэд хүний эрхийн тухай ард иргэний үндсэн эрх, үүргүүд нэртэй хуульчилан тунхаглажээ. Эдгээр нь: 1/ амрах; 2/ үнэ төлбөргүй боловсрох; 3/ хөдөлмөрийн чадвараа алдахад эдийн тусламж авах; 4/ угсаа, үндэстэн ялгаваргүй тэгш эрх эдлэх; 5/ эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш эрх эдлэх; 6/ шашин шүтэх, эс шүтэх; 7/ эвлэлдэн нэгдэх; 8/ төрийн дээд байгууллага хүртэл өргөдөл, гомдол гаргах; 9/ чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа сонгох; 10/ чөлөөтэй үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан, жагсаал ёслол хийх; 11/ шүүхийн тогтоолгүй буюу прокурорын зөвшөөрөлгүйгээр үл халдах эрх эдлэх; 12/ орон сууцны болон захидал харилцааны халдашгүй эрхтэй байх эрхүүд юм.

БНМАУ-ын 1960 оны шинэчлэн баталсан Үндсэн хуулийн долоодугаар бүлэгт «Иргэдийн үндсэн эрх ба түүнийг хангах баталгаа» гэсэн нэртэй 76-88 дугаар зүйлүүдэд хүний эрхийн тухай доорх заалтуудыг тунхаглан хуульчилсан. Үүнд: 1/ БНМАУ-ын иргэд эрэгтэй, эмэгтэй, арьс, үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаваргүй тэгш эрхтэй; 2/ хөдөлмөрлөх, цалин хөлс авах; 3/ амрах; 4/ эдийн тусламж авах; 5/ сурч боловсрох; 6/ нийгэм, аж ахуйг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох; 7/ эвлэлдэн нэгдэх; 8/ төр, аж ахуй, соёл, нийгэм, улс төрийн бүх ажилд тэгш эрхтэй оролцох; 9/ эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил эрх эдлэх, 10/ өргөдөл, гомдлоо чөлөөтэй гаргах, 11/ шашин шүтэх, эс шүтэх; 12/ үг хэлэх, хэвлэх, нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх; 13/ амь бие, орон сууц, захидал харилцааны нууцын халдашгүй эрхээр хангагдах явдлууд бөгөөд шүүхийн тогтоол, прокурорын зөвшөөрөлгүйгээр хэнийг ч баривчилж болохгүйг заасан байлаа.

Дээр дурдсан хуулиудад хүний эрхийг өмнөх үсүдтэй нь харьцуулахад яах аргагүй ихээхэн дэвшилттэй заасан нь эргэлзээгүй. Гэхдээ нэгдүгээрт хүний эрх, эрх чөлөө болон тус улсаас олон улсын харилцаанд хүлээх ёстой үүргийг хүндэтгэн үзээгүй, хүн төрөлхтөний түгээмэл үнэт зүйл болдог ардчиллын гол гол зарчмууд бүрэн тусгагдаагүйгээр барахгүй хязгаарлалттай байв. Энэ нь зөвхөн нэг үзэл суртлыг сонголтгүй удирдлага болгож байснаас захиргаадалтын тогтолцоонд хүлэгдэн амь алдаж, улмаар төрийн тоталитар дэглэмд автагдан ихэнх заалт нь хоосон тунхаглал болж хувирсан юм. Жишээ нь анхдугаар Үндсэн хуульд тунхагласан хүний эрх зөвхөн ард анги гэдэг бүлэглэлд хамаарч, язгуур угсаатан, лам санваартан, хөрөнгөлөг болон худалдаа арилжаа эрхэлдэг хүмүүсийг феодал анги хэмээн эрхийг нь хасах заалтыг шууд хуульчилсан байсан юм. 1940, 1960 оны Үндсэн хуулиудад шүүхийн тогтоолгүй буюу прокурорын зөвшөөрөлгүй хэнийг ч баривчилж болохгүй гэсэн заалт байсан боловч 1930-40-өөд оны их хэлмэгдүүлэлтийг тусгай комисс, онц бүрэн эрхт комисс гэх мэт байгууллагууд шууд биечлэн гүйцэтгэж байжээ. Түүнчлэн 1960-70-аад оны үед сэхээтний төөрөгдөл, намын эсрэг бүлэг гэх мэт янз бүрийн нэр хаяг зүүлгэсэн «тэрс үзэлтнүүд»-ийг хууль бусаар цөлөх, хорих, эд хөрөнгийг хураах зэргээр хэлмэгдүүлдэг байсан байна. Ялангуяа дээрх Үндсэн хуулиудаар тунхагласан иргэдийн хувийн халдашгүй эрх болон улс төрийн

эрхүүд ил далд аргаар ноцтой зөрчигдөж байснаас гадна 1960 оны Үндсэн хуулиар хүний угаас заяасан эрхийн нэг болдог эд хөрөнгө хувьдаа өмчлөх эрхийг хүртэл хүлээн зөвшөөрдөггүй байсан билээ.

Монголд 1980-аад оны сүүдчээр өрнөсөн ардчилсан хувьсгалын нэг гол лоозон бол хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ ёсоор баталгаатай эдлүүддэг нийгмийн байгууллыг бүрдүүлэх явдал байсан юм. Тийм учраас ардчилсан хувьсгалт хөдөлгөөн бүх нийтийн идэвхийлэл оролцоог эгшин зуурт өөртөө татаж, 1990 оны ардчилсан хувьсгалыг тайван замаар явуулав. Энэ хувьсгал тайван замаар явсны нэг гол шалтгаан нь түүний хүний эрхийг хүндэтгэсэн зорилготой холбоотой байсан билээ.

Монголд 1990 онд ялсан ардчилсан хувьсгалын хамгийн гол үр дүн, эрх зүйн баталгаа нь 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хууль мөн. Энэ хуулиар хүний эрхийн асуудлыг хуульчлан бэхжүүлсэн гол концепци нь уг хуулийн оршил хэсэгт «эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцдуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно» гэж зорилгын туйлаа тодорхойлсноор тайлбарлагдана. Үндсэн хуулиар зарлан тунхагласан иргэний ардчилсан нийгмийг байгуулах асуудал бол төрийн эрх барьж, хууль тогтоох дээд байгууллага Парламентын болон төрийн тэргүүн Ерөнхийлөгчийн сонгуулийн гурав, дөрвөн ээлжит сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр биш Монгол орны хөгжил цэцэглэлт, мандал бадралын ирээдүйн чиг замыг тодорхойлсон зорилгын туйл (идеал) учраас бүх нийтийн идэвхи санаачлага, бүтээлч үйл ажиллагааны үр дүнд хэрэгжүүлэх түүхэн хөгжлийн аажим процесс юм. Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт заасан хүний эрхийн тухай асуудлууд ч гэсэн аяндаа шууд хэрэгждэггүй. Иргэд болон төрийн зүгээс байнгын санаачлага, идэвхтэй ажилласны дүнд олон зүйл саад бэрхшээлийг даван хэрэгжих учиртай. Иймд Үндсэн хуулиар баталгаажуулсан учир Монголд хүний эрх хангагдсан гэж үзэж болохгүй тул хүний эрхийг хэрэгжүүлэх материаллаг болон сэтгэл зүй, оюун санааны бүх баталгааг бүрдүүлэх учиртай. Монгол улс дахь хүний эрхийн соёл нь түүхийн хувьд эртнээс уламжлалтай боловч нийгмийн хөгжлийн зохих үе шатанд цаг үетэйгээ зохицон хүн, төр хоёрын хоорондын зөрөг, сөрөг харилцааны дүнд хөгжсөөр эдүгээг хүрч иржээ. Хүний эрхийн соёлыг түүхэн уламжлалт хэвшлийн хувьд

өрнөдийн буюу эрхээр дулдуйдаж үүргийг тодорхойлдог бардам (schulz) соёл, дорнын буюу үүргийг дагалдуулж эрхийг тодорхойлдог бүрэг (scham) соёл гэж ангилдаг. Монголчуудын хүний эрхийн соёл нь уламжлалын хувьд дорнын соёлд хамаардаг байв. Орчин үед нийгийн хөгжлийн дэлхий нийтийн түгээмэл хандлагатай зохицож хүний эрхийн соёлд олсон амжилт нь хүний эрхийн талаар өрнийн, дорнын гэх эрс ялгаатай байдлыг арилгаж, 1948 оны 12 дугаар сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар баталсан «Хүний эрхийн түгээмэл тунхаглал»-ыг гаргасан байна. «Хүний эрхийн түгээмэл тунхаглал» бол олон улсын харилцаанд бүх нийтээр сахин биелүүлэх, хүний эрх, эрх чөлөөний хүрээг дэлхийд анх удаа тогтоосон, улс, үндэстэн, өрнө, дорно, бүс нутаг болон бусад ямар нэг ялгаваргүйгээр хамтран ажиллах олон улсын эрх зүйн хэм хэмжээний эх сурвалж юм.

¹ «Монголын нууц товчоо» Улаанбаатар., 1990 он, 43-44-р талд.

² Конституционное /государственное/ право зарубежных стран. Общая часть, Москва., 1996 г. Стр 104.

**ТӨР ЁСНЫ ТУХАЙ ҮЗЭЛ САНАА,
ТҮҮНИЙ УГ СУРВАЛЖ
(бодрол)**

© 1999 он. Нанзаддоржийн ЛҮНДЭНДОРЖ¹

«Төр» хэмээх ойлголт дэлхий дахинаа түгээмэл хэрэглэгддэг нэр томъёо болсон хэдий ч түүнд улс үндэстэн хэрхэн хандах арга, ухаан, соёл, эрх зүйн ухамсар харилцан адилгүй. Үүнээс хамаарч төрийн зохион байгуулалт, үүрэг, зорилго, үйл ажиллагаа, хөгжлийн төвшин, хандлага янз бүр. Энэ бүхнийг нөхцөлдүүлэгч оюуны соёлын гол хүчин зүйл нь «төр ёс» юм.

«Төр ёс» - төр орших, үүрэг зорилгоо хэрэгжүүлэх оюун санааны үндэс. Харин төр - төр ёсоос шууд хамаарч байдаг, түүний илрэх хэлбэр, биежсэн дүр төрх юм. Иймээс төр ёсны мөн чанар, элементүүдийг задлан шинжлэх нь аливаа улс, үндэстний төрийн хөгжлийн мөн чанар, зүй тогтол, онцлог, уламжлал, шинэчлэлийг тодорхойлох гол цэг, арга зүйн чухал үндэслэл мөн. Гэтэл уг ойлголт манай оронд төдийгүй, дэлхийн улс орнуудад ч шинжлэх ухааны хувьд нэг мөр тайлбарлаж, тодорхойлсон зүйл одоогоор нэи ховор бөгөөд харин олон улс гүрэнд өргөн тархсан хэлний толь бичгүүдэд аливаа улс, үндэстний төр, оршихуйн нөхцөл гэсэн нийтлэг утгаар тодорхойлсон нь харагдана. Тухайлбал,

1. «Аливаа үндэстэн хараат бусаар оршин тогтнох нөхцөл» (Dictionary contemporary English Longman. 1987.)

2. «Төр оршин тогтох, байгуулах нөхцөл, статус бөгөөд тэрхүү статус нь олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн байх байдал» (Random house Webster's college dictionary. 1995. New-York.) хэмээжээ.

3. «Төр ёс-төр оршихуйн нөхцөл» (Merrian Webster's collegiate dictionary. London. 1997.)

4. «Төрөөр илэрхийлэгдсэн ёс журам, төрийн засаглал нийгэмд орших бодит илрэл.. . Бусдаас хараат бус байх байдал, тусгаар улс, үндэстэн байгуулах нөхцөл, статус мөн.» (Political science. Washington. 1993.) гэжээ.

5. Герман хэлэнд «төр ёсыг» - Staatlichkeit гэж нэрийдэх бөгөөд уг ойлголтын агуулгад - «төрийн статусыг ойлгоно» (Duden Deutschess Universal Worter-buch /A-Z/ Dr.Gunter Mahuhiem. Leipzig, Wien, 2 urich. 1989.) гэсэн байна.

¹ МУИС-ийн профессор, гүн ухааны доктор (Ph).

Тэгвэл Европ дахин тийм биш юм. Тэдний өргөн уудам бичиг газар нутаг нь амьдралын эрчимтэй хэв шинжийг нөхөжүүлж өрсөн. Н.А.Бердяевын бичсэнээр германчууд бүх

төртэй байдаг нь амьдралын нэг гол хууль мөн. Ийм болит ахуйтай үлс үндэстэн мөн л түүнийг нь тохирсоон төр ёс, эрчимтэй бүс хэв шинжийг өөрийн эрхгүй буй болгоосон байна. Нөхцөлгүйлсэн гэж хэлж болно. Энэ нь нийгмийн амьдралын байдал болон сахигчид зохихон байгуулалтын сул чанарыг я мөн татаас өргөн уудам нутаг амьдралын цагтар наагай урсгал болон төрийн ашиг сонирхолд захирагдаж байсан байна. Нөгөө иржээ. Хувийн болон хувь хүний эрх, ашиг сонирхол нийтлэг амьтгалыг хамтаар хүчээр даван туулах шаардлага тулгарсаар сонирхолд нийлүүлэх, байгалийн эрс тэс хатуу ширүүн үүр тувшинд төвлөрүүлжээ, нийгмийн бүх амьдралыг төрийн ашиг хамгаалалтын онцгой зорилгыг төрөөс шаардсан төдийгүй өнөө харуулаар иржээ. Тухайндал, монголч өргөн уудам нутаг үндэстэн өнөөдөр хортан зууны туршид үйлс гэгдээ арга ухаан байгалийн нөхцөлөөр тодорхойлогдон гэсэн алдарт өмнөх 4 зууны үеэ тухайн үлс орны лотоод ул чанар, амьдрах багана. Энэ тухай эртний Грекийн түүхч Геродот манай эртний түүхийн хэргээс, шаардлага, ач холбогдлыг үлснээс хамгаалж, аршиншиг, итгэл бишрэл, захирагч захиралыг ёс хангах хандлага, дэвсгэрийн хэмжээгээр нөхцөлөөс үндэстний сэтгэл зүй, зан үнийг нөхөжүүлжээ гол хүчин зүйл байгалийн нөхцөл, нутаг нийгмийн тэргүүлэгч нь өөр хоорондоо алдарь байсан гэдэг. Тогоо, баригч, засах арга, ухаанч анхны шав тавилжээ. Хүний эрх хайлмыг үр дүн байлаа. Энэхүү эрх хайлмыг үр дүн төрөө өөрсөө бүтээсэн. Гэхдээ үрт удаан хугацааны тэмцэл, бодрол, байгуулалгүй. Төрийн хүмүүс ухамаар, мэдрэмж, хүсэл зорилгоороо Төрийг бүрхэн я бүтээжээгүй, ертөнцийн эснэ я зохихон

сулалтаа, тайлбар шаардсан асуудал мөн. Тодорхойлогч элементүүдийг тодруулах нь шинжилж ухааны орших нөхцөл, үндэс гэдгийг хүрээнд юул ойлгох, түүний гол орших нөхцөл, үндэс, стаяг гэж авч үзсэн байна. Харин төр

Ийнхүү «төр ёс» - ухагдахууныг хэл зүйн үүднээс «төр бичигт: төр ёсыг-тогтоосон ёс, хуульчтай байхыг хэлнэ гэжээ.

6. Я.Цэвэл агсны Монгол хэлний товч тайлбар товч

талаасаа хавчигдмал, яг л уутанд байгаа юм шинг гэдгээ мэддэдэг аж. Тиймээс тэд өөрсдийн зохион байгуулагдсан эрч хүчийг аврах идэвхитэй эрэл хайлтыг байнга хийж байдаг. Өндөр сахилга бат, хариуцлагагүйгээр тэд оршиж чадахгүй. Германчууд герман тэднийг аврахгүй, харин германыг германчууд аврана гэдгийг мэддэдэг бол оросуудын хувьд яг эсрэгээр нь ханддаг² гэжээ. Германчуудын сэтгэл зүйн энэ онцлог мөн л түүнд тохирсон амьдралын зохион байгуулалт, төр ёс, төр хуультай байх нь мэдээж юм. Өнөөгийн бодит дүр төрх нь ч энэ онцлогоо тусгасан байгааг харахад төвөгтэй биш юм.

Тэгэхлээр төр нь төр ёсыг бүтээдэггүй, харин төр ёс нь төрийг тогтоодог аж. Тэрхүү төр ёсны үндэс, бүтээгч нь үндэстэн мөн.

«Үндэстэн» - ойлголт судлаач, сэтгэгчдийн судалгааны эргэлтэд эртнээс орж, цагийн аясад өөрчлөгдөн хөгжиж ирсэн байна. Анх түрүүн «nation» - «нийтлэг гарал үүсэлтэй» хүмүүс буюу «gens» - «овог» гэсэн ойлголттой утга нэг ойлгож байсан байна. Харин түүхийн дундад үед уг ойлголт нутаг дэвсгэр, хэлний нийтлэг гэдэг утгаар баяжсан бөгөөд Лютерийн үеэс тухайн төр улсад багтаж байгаа бүх хүмүүсийн нийтлэгийг ойлгох болсон аж. Улмаар Францын хувьсгалын үеэс «үндэстэн» гэсэн ойлголт улс төрийн шинжтэй болж нийтлэг хуулинд захирагддаг төрийн иргэдийг ойлгох болсон байна. Орчин үед «үндэстэн» - ойлголтыг угсаатны зүйн болон улс төрийн талаас нь ойлгож тайлбарлах боловч агуулга, харилцааны нэгдлийг мөн л олоогүй байна.

Ямар ч гэсэн үндэстэн нь хүмүүний хамтаар аж төрөх ёсыг угсаатны болон улс төрийн талаас тусган илэрхийлдэг, төр, хууль цаазтай, өөртөө эзэрхэн оршихын оюун соёлын үндсийг тодорхойлогч хүмүүсийн нийтлэг гэж үзэж болно.

Үндэстэн бүрэлдсэнээр тэдний онцлогийг тусгасан үндэсний үзэл, мэдрэмж төлөвшиж, улмаар төр ёсны үзэл бүрэлдэж төр улс тогтдог ажээ. Иймээс төр ёс - үндэстний хүсэл зориг, дотоод мэдрэмжийг тусгасан төр барих, засах, төрд хандах, захирагдах арга, ухаан, соёлын нийлбэр цогц мөн.

Төр ёс - үндэстний оюун соёлын бүрэлдэхүүн тэгэхдээ төр

иргэндээ, иргэн төрдөө хандах ёсоор түүний агуулга тодорхойлогдоно.

Төр иргэндээ хандах ёс нь үндэстний сэтгэл зүй, хүсэл зориг, ашиг сонирхолыг илэрхийлсэн төрийн гүн ухаан, засаглах арга билэг байдаг бол иргэн төрдөө хандах ёс нь үндэстний эрх зүйн ухамсар, соёлыг өөртөө агуулна.

Төрөөс иргэндээ хандах ёс нь түүний засаглалаа хэрэгжүүлэх арга ухаанаар илэрдэг. Тэрхүү засаглалын агуулга нийтлэг эрх ашгийг хамгаалахад чиглэгддэг. Нийтлэг эрх ашгийг хамгаалахдаа ямар хүсэл зоригт тулгуурлах нь тухайн төрийн хөгжлийн төвшин, түүхэн нөхцөл байдал, нийгэмд төрийн гүйцэтгэж буй үүрэг, иргэний нийгмийн төлөвшлөөс шууд хамаарна.

Онол, улс төрийн хувьд тайван цагт ардчилсан үндсэн хуультай улс оронд төрийн хүсэл зориг бус ард түмний хүсэл зориг давамгайлах ёстой гэж үздэг. Гэвч энэ зарчмыг шууд утгаар ягштал баримтлахад ихээхэн бэрхшээлтэй. Тухайлбал, манай орны хувьд ардчилсан Үндсэн хуультай, улс төрийн нөхцөл байдал тийм ч ноцтой биш. Гэвч төрийн засаглалд ард түмний хүсэл зориг давамгайлах ахуй, нөхцөл алга байна. Үүнийг сонсоод Монгол улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийг (Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна) санах нь мэдээж. Хэрэг дээрээ энэ нь ардчилсан улс орон бүрийн Үндсэн хуульд байдаг тунхаглал, дээд эрмэлзлэл болохоос бодит практик, амьдрал биш юм. Ард түмэнд хуулиар олгогдсон бололцоо болохоос бодит байдал биш. Бололцоо бодит байдал болох нь тэднээс биш, эрх баригчдаас, элит хэсгээс шууд хамаарч байдаг. Ард түмэн гэдэг бол үнэн чанартаа хэн ч биш, эрх баригчид, элит хэсэг тэднийг хэзээ ч, яаж ч аргалж чаддаг жамтай. өргөн уудам нутаг дэвсгэр, тархай бутархай суурьшил төрийн хүсэл зоригт тулгуурласан зохицуулалт оролцоог хүссэн хүсээгүй ч нөхцөлдүүлж байна.

Иргэний нийгэм ардчилсан утгаараа төлөвшөөгүй, төрийн сөрөг хүчний статусаа эзэмшээгүй байгаа болон ардчилсан төр дөнгөж бүрэлдэж, төрийн албан тушаал нэр төр, ёс суртахууны үнэлэмжээ олоогүй бизнесийн талбар мэт байгаа өдгөөгийн

нөхцөлд ямар хүсэл зориг давамгайлах нь нэн ойлгомжтой. Энэ бол зөвхөн манай зовлон ч биш, бидний муугийнх ч биш хүн төрөлхтний туулдаг зам бололтой.

Нийгмийг хуулийн засаглалаар удирдахуйн үндэс нь эрх зүйн зохицуулалт мөн. Эрх зүйн зохицуулалт зөвшөөрлийн болон хориглолтын ямар аргад голлон тулгуурлах нь төр иргэн, хүнд хэрхэн хандаж байгааг илэрхийлэх төдийгүй, тухайн төрийн шинж чанар, загварыг тодорхойлж байдаг. Эрх зүйн зохицуулалт, зөвшөөрлийн механизмд тулгуурлаж байвал төрөөс иргэд, нийгэм өөрийн хүсэл зоригоо тулгасан төр ёс хэрэгжинж буй хэрэг. Харин хориглосон зарчимд тулгуурлаж байвал (хэрвээ тэрхүү хориглолт нь жам ёс, үнэт зүйлсийг хамгаалахад чиглэгдсэн бол) төрийн хүсэл зориг хязгаарлагдаж буйн илрэл мөн. Энэ хоёр механизмын аль нь давамгайлах нь тухайн төрийн бодит ахуйгаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, сонголтын агуулга тийм ч гол хүчин зүйл боддоггүй. Аль нэг улс оронд дарангуйлагч тогтолцоо гарч ирэх нь гэжээтийн бөгөөд тохиолдлын үзэгдэл биш, бодит нөхцөл, шалтгаан, үр дагавар байдаг. Дэлхий дахинд социалист тогтолцоо бий болсон нь Маркс, Лениний дур зорго байгаагүй. XIX зууны Европ дахины түүхэн нөхцөл, бодит байдлын үр дүн, илрэл байсан.

Эцэст тэмдэглэхэд төрөөс иргэд, хүмүүст хандахдаа бодит олон хүчин зүйлээс хамаарч удирдлага - засаглалын янз бүрийн арга механизмыг хэрэглэдэг ч эцсийн эцэст төрийн бүрэн эрхт байдлаа бататгах хамгаалахад чиглэгдсэн төрийн бодлогод л тулгуурлана. Төрийн бүрэн эрхт байдал гэдэг бол Ж.Бодены тодорхойлсон хэнд ч юунд ч хязгаарлагдахгүй төрийн дээд засаглал гэхээсээ илүү төрөөс иргэд, нийгэм, иргэншил соёлоо хамгаалж хөгжүүлэх төрийн чадвар, дээд эрмэлзэл, төр ёсны гол элемент мөн.

Иргэд төрдөө хандах ёс мөн л олон хүчин зүйлээс шалтгаална. Юуны өмнө, тухайн ард түмний иргэншил соёл, төрөөс иргэдэд хандах ёс, түүний илрэх механизм, нийгэмд төрийн гүйцэтгэж буй үүрэг, эрх зүйн ухамсар, соёл, төрийн бодлого, дэглэмийн шинж чанар зэрэг багтана. Гэвч төрд хандах ёсны гол агуулга нь газрын дээр төрж, төрийн дор амьдардаг тэрхүү жам ёсны хэрэгцээгээр тодорхойлогдоно.

Хүн төрийн гадна оршиж чаддаггүйн учрыг Аристотель түүний улс төрийн мөн чанартай холбоотой гэдгийг нотолсон байдаг. Төрд тоологдох бус багтах нь үр удмаа үлдээх, хэрэгцээгээр нөхцөлдсөн засаглах харилцаа, хүний хүсэл зоригоо илэрхийлэх онцгой шинж, ашиг сонирхолоо хэрэгжүүлэх байнгын эрмэлзэл, тэмцэлтэй шууд холбоотой. Төрд багтахгүйгээр энэ бүхэн нь тэдэнд гай зовлон авчирдаг учраас хүмүүс төрийг өөрсдөө бүтээсэн. Төр бүтээгчдээсээ хүнийсэх явдал түүхэнд олонтаа байсан ч төр - хүн төрөлхтний онцгой үнэт зүйл байсаар ирсэн, байж ч байна.

Энэ хувьд нь хүмүүс төрийг дээдэлж хүндэтгэж, хүлээн зөвшөөрч үзэл соёлын тогтолцоог бүрдүүлжээ. Иймээс төрийг хүндэтгэх, түүний засаглалыг хэрэгжүүлэх үзэл сэтгэлгээ, ухамсар бол төр ёсны бас нэг багана мөн. Ийнхүү төр ёс нь төрөөс иргэн, иргэнээс төр гэсэн хос баганын уулзварт оршдог үзэл санаа, үйл ажиллагаа мөн.

² Н.А.Бердяев. Судьба России /1915/. М., 1990. С. 66-68

ТӨРИЙН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ

©1999 он. Должингийн БАЯРСАЙХАН¹

Аливаа төрийн оршин хөгжих үндсийг тодорхойлоход төрийн бүрэн эрхт байдал онцгой байрыг эзэлдэг.

«Бүрэн эрхт байдал» гэдэг нэр томъёо нь латины «super» - «оройн дээд», «дээдлэгдэх» гэсэн язгуур үгийн утгаас эх үндэстэй. Энэ ойлголт нь Францаар «souverainete», немцээр «soveranitat», англиар «sovereignty», оросоор «суверенитет» гэсэн нэр томъёогоор хэрэглэгдэж, илэрхийлэгдэхдээ «засгийн дээд эрх» ба «тусгаар тогтнолыг нэгтгэн хангагч төрийн бие даасан байдлын статус» гэсэн нийтлэг агуулгыг тусгах ажээ.

Эдүгээгээс 400 гаруй жилийн тэртээ Францын нэрт сэтгэгч Жан Бодин (Jean Bodin) «Бүгд Найрамдах Улсын тухай зургаан ном»²-доо (1576) уг ойлголтыг анх удаа «souverainete» гэсэн нэр томъёогоор хэрэглэсэн байдаг. Тэрээр «... Бүрэн эрхт байдал бол төрийн өөрийнх нь уг шинж мөн болохыг дурдаад засгийн дээд эрх хийгээд төрийн нэгдмэл, тогтвортой хараат бус оршин тогтнох чадвар нь тухайн улсын бие даасан, тусгаар байдлыг хангах баталгаа нь болох ёстой»-г нотлон тэмдэглэсэн билээ. Энэ үндэслэл өнөө хир ач холбогдлоо алдалгүйгээр түүхийн аясыг дагаж, улам баяжин хөгжсөн бөгөөд Жан Бодиний сургаалийн гол агуулга нь эдүгээгийн ойлголттой нилээд дүйцэж очсон байдаг.

«Бүрэн эрхт байдал» гэдэг ойлголт нь «Тусгаар тогтнол» (independence) гэдэг ойлголттой салшгүй холбоотой. Эдгээр нь хоорондоо зүй тогтолт шүтэлцээтэй юм. «Бүрэн эрхт байдал» нь төрийн дээд эрх мэдлийн чадварын шинжийг илүү илэрхийлсэн байхад, «Тусгаар тогтнол» нь улс орны эдийн засаг, улс төр, соёлын талаарх хөгжлийн бие даасан байдал, түүний түвшинг тусгана. Бүрэн эрхт байдал нь тусгаар тогтносон байх шинжийг өөртөө агуулдаг учраас эрх зүйн хувьд илүү өргөн хүрээтэй ойлголт юм.

¹ МУИС-ийн ХЗДС-ийн профессор, доктор (Ph).

Тусгаар тогтнол ба бүрэн эрхт байдлын харьцааг зохистойгоор уялдуулж тогтоосноор улс орны үндэсний аюулгүй байдал найдвартай хамгаалагдах нөхцөл бүрдэнэ.

Анхны бичмэл Үндсэн хууль (1787) үүсч, түүнээс хойш дэлхийн улс орнууд Үндсэн хуульд байгуулалд шилжин орсоноор төрийн бүрэн эрхт байдлын эрх зүйн үндэслэл улам бэхжин, түүнийг дагалдан уг ойлголт нь улс төрийн төдийгүй хууль зүйн агуулгыг тусган хэрэглэгдэх болжээ.

Төрт ёс түүхэн үзэгдлийн хувьд анхлан үүссэнээс хойш 2500 гаруй жилийг ардаа орхисон хэдий ч тухайн төрийг «улс» («state») гэдэг шалгуураар ойлгон тодорхойлдог болсон үеэс (1648) «Бүрэн эрхт байдал»-ын хэмжигдэхүүн нь олон талт, гүн гүнзгий агуулгаар илрэх болсон ажээ. Үүний хамт дэлхий дахинд улс төр-эрх зүйн нийтлэг жишиг, түгээмэл хэм хэмжээ тогтож, үндэстэн ард түмний оршин тогтнох нөхцөл нь олон улсын амьдралаас ихээхэн хамааралтай болж ирсэн ХХ зууны II хагасаас төр нь сонгомол хэв шинжийг илэрхийлэн шинэчлэгдэн хөгжжээ. Гэхдээ төрийн үүслийн хэв шинжүүд илэрч байсан түүхэн хөгжлийн аль ч үед «Бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол» нь «төр» гэдэг субъектийн шалгуур шинж нь болсоор ирснийг үгүйсгэж болохгүй. Төр судлаач эрдэмтдийн дунд³ «Бүрэн эрхт байдал буюу тусгаар тогтнол»-ыг төрийн үндсэн ба шалгуур шинж мөн эсэх талаар маргаантай ба энэ талаар нэгдмэл ойлголт хараахан бий болоогүй харагддаг. Ер нь ч «Бүрэн эрхт байдал» бол төрийн шалгуур шинж төдийгүй Еллинекийн дэвшүүлж байсан төрийн гурван шинжтэй дүйцэхүйц дөрөвдөгч шинж мөн болохыг шууд няцааж боломгүй санагдана. Ийм байр суурьтай судлаач, эрдэмтэд манайд цөөнгүй бий. Тухайлбал, төр судлаач, дэд доктор А.Цанжид «Шинэ толь» сэтгүүлийн 1994 оны №2-т нийтлүүлсэн өгүүлэлдээ: «Эртний ба орчин үеийн төр, төсөөт байгууллагыг ижилсүүлж байгаа буюу мөн чанарыг нь тодорхойлсон нэг үндсэн шинж нь төрийн тусгаар тогтнол (суверенитет-өөртөө эзэрхэх ёс) гэдгийг тэмдэглээд энэхүү үндсэн шинжээс төрийн мөн чанартай холбогдож дурддаг бусад бүх шинжүүд урган гарна» гэж бичжээ.

«Тусгаар тогтнол» буюу «Бүрэн эрхт байдал» гэдэг нэр томъёог хамтад нь тусгасан эрх зүйн баримт бичгүүд нилээд байдаг нь санамсаргүй зүйл биш. НУБ-ын дүрмийн I дүгээр зүйл,

НҮБ-ын 1949, 1960, 1966, 1974 оны конвенц, гэрээнүүдэд уг ойлголтыг олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ болгон тогтоосон байна. Улсуудын эрх, үүргийн тухай Америкийн улсуудын 1933 онд Монтевидеод батлан гаргасан конвенцэд төрийн үндсэн шинжийг анх удаа бүрэн утгаар нь тодорхойлсны дотор «бусад орнуудтай бие даан харилцах чадвар (sovereignty) нь ямар ч улсын гол шинж, шалгуур болох»-ыг заасан байдаг.

Аливаа төр нь тусгаар тогтносон байхын тулд тодорхой нутаг дэвсгэрт хүн амыг (өөрийн үндэстэн, ард түмнийг) харьяалж, гадна, дотны ямар нэг субъектийн дарамт, нөлөөнд автахгүйгээр улс төрийн бодлого, засаглалыг бие даан хэрэгжүүлэх онцгой чадвартай байх ёстой.

Төрийн бүрэн эрхт байдал нь үндэстэн, ард түмний тусгаар тогтнолтой зайлшгүй хамааралтайн дээр зөвхөн тухайн орны бие дааж тусгаар тогтнох эрхээр хязгаарлагдахгүй. Харин бусад улсын дотоод хэрэгт үл оролцох, бүрэн эрхийг нь хүндэтгэх явдалтай шууд холбоотой. Энэ нь төрийн эрх мэдлийн дээдлэгдэх, зайлшгүй хийгээд, бие даан харьцангуй тусгаар орших чадвар юм. Төрийн бүрэн эрхт байдлын шинж олон талт шалгуурыг тусгах болсныг харгалзан зарим судлаачид⁴ тусгаар тогтнолыг хангах баталгаажилтын түвшингээр нь *a/ бүрэн тусгаар тогтнол, b/ харьцангуй тусгаар тогтнол, в/ хязгаарлагдмал тусгаар тогтнол* гэж ангилсан явдал бий. Өөрөөр хэлбэл, Бенн, Петерс болон Вильсон, Хинсли нарын зэрэг өрнөдийн судлаачид уг судлагдахууныг орчин цагийн олон улсын эрх зүйн субъектэд тавигдах шаардлагын түвшинд, нилээд өргөн хүрээнд авч үзэх болсон нь сонирхол татаж байна. Түүнчлэн орчин үеийн улс төр судлалд «олон түмний» (popular), нэрийдсэн (nominal), «улс төрийн» (political) бүрэн эрхт байдал гэж ангилан тогтоож үзсэний дээр уламжлалт монист үзлийн эсрэг шүүмжлэлтэй хандсан тайлбарууд⁵ байдаг нь хууль зүйн талаас нь бодсон ч шинэлэг дэмжүүштэй санаа юм.

Угаасаа ч бүрэн эрхт байдлын түвшин, баталгааг бүх талаас нь бүрэн дүүрэн хангасан орон гэвэл маш цөөн (их гүрнүүдийг эс тооцвол). Орчин үед улс орнуудын хоорондын хамааралт байдал нэмэгдэж, олон улсын эрх зүйн харилцаа шинэ шатанд гарч, гүнзгийрэн хөгжиж буй өдгөө үед төрийн бүрэн эрхт

байдлын баталгааг эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн харьцангуй буюу зохист түвшинд нь авч үзэх нь илүү нийтлэг хандлага болсон гэлтэй.

Бүрэн эрхт байдлын эрх зүйн үндэслэл нь дэлхийн улс, орны Үндсэн хуулиудад тусахдаа нэг талаас үндсэн агуулгаараа нэг бүлэг, институт болж илэрхийлэгдсэн байхад нөгөө талаас энэ нь Үндсэн хуулийн бусад хэм хэмжээнүүдэд задарч, хуваарилагдан томъёологдсон байдаг. Түүнчлэн аль алиныг нь хослуулж тодорхойлсон (Франц, ОХУ) Үндсэн хуулиуд ч бий. Зарим орон эдийн засгийн бодлогоо өөрсдөө тодорхойлж чаддаг хэдий ч түүнийг хэрэгжүүлэх баталгаа нь бусад орноос хамааралтай түвшинд байх нь бий.

Монгол улс 1911 онд үндэсний тусгаар тогтнолоо сэргээж чадсан бол 1921 онд энэ нь ард түмэн гэсэн нийтлэгийн хүрээнд бэхжин тогтсоны дээр 1921-1992 он хүртэлх 70 жилд монголын төрийн бүрэн эрхт байдал нь хагас буюу хязгаарлагдмал түвшинд байсан гэдэг нь сүүлийн үеийн судалгаанаас⁶ нилээд ажиглагдах болов. Харин 1990-ээд оноос, тэр тусмаа 1992 оноос Монголын төрийн бүрэн эрхт байдал нь хязгаарлагдмал хүрээгээс ангижирч, харьцангуй бөгөөд бүрэн утгаараа бэхжин хөгжих болсон билээ.

Үндэстэн ард түмэн Төр гэсэн хамаарлын хүрээнд улсын тусгаар тогтнол бэхжин тогтдог болох нь шинэ үеийн түүхийн бүхий л үеийн туршлагаар нотлогдсоор байна. Тус улсын бүрэн эрхт байдлын үндсэн чиг хандлага нь орчин цагийн шаардлага, дэлхий дахины түгээмэл зарчим, хэм хэмжээг монголын үндэсний түүхэн уламжлалтай нягт хослуулан монгол төрийн уламжлалт хэв шинж, түүхийн давтагдашгүй өвөрмөц дүр төрхийг хадгалан хамгаалж, бэхжүүлэхэд оршино.

Монголын ард түмний хүсэл зоригийн дээд илэрхийлэл болсон Монгол Улсын Үндсэн хууль бол монголын төрийн бүрэн эрхт байдлын эрх зүйн уг сурвалж, баталгаа мөн. Үндсэн хуулиндаа тунхагласан бүрэн эрхт байдлын үндэс, зарчмыг бүх талаар бэхжүүлж, Үндэсний аюулгүй байдлын тогтвортой, найдвартай байдлыг хангах нь төрийн бодлогын хойшлуулагшгүй тулгамдсан зорилт болж байна. Үүний тулд юуны өмнө монголын төрийн бүрэн эрхт байдлын Үндэсний номлол боловсруулах; тус

улсын эдийн засгийн гадны орноос хамаарах хүчин зүйлийн сөрөг нөлөөллийг бууруулах; Үндсэн хуулийн хэм хэмжээ идэвхтэй үйлчлэх эрх зүйн механизмыг оновчтой бүрдүүлэх; төрөө дээдлэх, түүний бодлого, зарчмыг эрхэмлэн сахих үзэл санааг төлөвшүүлэх; Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтыг олон улсын эрх зүйн нийтлэг хэм хэмжээнүүдтэй уялдуулан зөв зохистой хангахад онцгойлон анхаарч, төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

¹ On sovereignty: Four chapters from the six Book of the commonwealth. Cambridge., 1992. p 49.

² Benn st.J. The Uses sovereignty. NY., 1972.

Н.Лунцэндорж. Төрийн онол. УБ., 1997.

Ц.Сарангуза. Төрийн ерөнхий онол. УБ., 1998. г.м.

⁴ Publius. The Journal of Federalism. 1995. № 1. p. 175-178.

⁵ F.H.Hinsley: Sovereignty. London. Cambridge Univ. Press 1985. p. 220-224.

⁶ Д.Баярсайхан. Государственный суверенитет Монголии: Конституционно-правовые проблемы. Автореферат. дисс. канд. юр. наук. Улан-Батор. 1998. стр.

ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТААР ТӨР, ЗАСГИЙН ХЯМРАЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

© 1999 он. Бирваагийн МАНДАХБИЛЭГ¹

Хууль цаазат (эрх зүйт) төрийн нэг зорилго буюу зарчим нь улс төрийн харилцааг аль болохоор хууль зүйгээр зохицуулахад оршдог билээ. Тиймээс ч «том улс төрийг» Үндсэн хуулиар зохицуулахыг эрмэлздэг бөгөөд энэ хууль зүйн салбарыг Үндсэн хуулийн эрх зүй (Төрийн эрх зүйн зонхилох хэсэг) хэмээдэг.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар өмнөх хоёр жилийн ардчилсан ололтоо Монгол үндэстэн баталгаажуулж парламентын засаглалтай болсон билээ. Тэр үед АИХ-ын депутатуудын дунд хэт өөдрөг үзэл давамгайлан 1998 оных шиг төрийн дээд байгууллагуудын (УИХ, ЗГ) хямралт нөхцөл байдал үүсч болохыг урьдчилан харсан хүнгүй бололтой. Гэхдээ монголчуудад илүү тохирох Ерөнхийлөгчийн БНУ-ын хэлбэрийг сонгон авахын төлөө АИХ-ын депутатуудын олонхи нь анх байсан гэдгийг энд дурьдмаар байна: энэ нь 2 санал хураалтаар тодорхой харагдсан билээ. Гэвч «хүчтэй Ерөнхийлөгч нь амархан дарангуйлагч болж хувирна» гэсэн аргументыг дэвэргэн улс төрийн зөвшилцлийн механизмын арга замаар Монгол улс маань «саармаг» Ерөнхийлөгчтэй парламентын БНУ болж хувирсан билээ. Ер нь тэр үед монголчууд шинэ Үндсэн хуулиа баталж, улс төрийн томоохон амжилт гаргасныг үгүйсгэх гээгүй байна. Харьцангуй сайн Үндсэн хууль болсон гэж өгсөн үнэлэлт ч үндэстэй. Гэхдээ гоц сайн Үндсэн хууль бүтээсэн гэж хэтрүүлж магтсаар төрийн зохион байгуулалт, тогтолцоог дутуу зохицуулсан, цоорхой зүйлийг нь манай улс төрчид болон хуульчид нэг талаар анхаарахгүй эсхүл мэдэрч чадахгүй; нөгөө талаар Үндсэн хуулийг халдашгүй мэт үзэн сайжруулах,

1 Гаднад Харилцааны Яамны мэргэжилтэн, хууль зүйн ухааны доктор. Тэрээр 1998 оны 7 дугаар сард ХБНГУ-ын Хайдельберг хотын Их сургуулийн Хуулийн факультетэд эрдэнийн зэргийг «Райхын захиргааны зарим байгууллагын эрх хамгаалах ажиллагаа нь захиргааны шүүхийн урьдчилсан шат болсон тухай» сэдвээр хамгаалсан болно. Ийнхүү тэрээр Өриодол хууль зүйн ухааны докторын зэргийг анх удаа хамгаалсан Монгол Улсын иргэн болжээ. Тэрээр 1994 оны 12 дугаар сард мөн сургууль дээр «Германы Үндсэн хуулиар засаглал хуваарилэх хөндлөн харилцааг зохицуулсан нь» сэдвээр магистрын зэргийг бас хамгаалжээ.

боловсронгүй болгох оролдлогыг таашаахгүй байсаар олон жилийн цаг хугацааг өнөөг хүртэл дэмий өнгөрөөв.

Өнгөрсөн 1998 оны парламент, засгийн газрын хямрал нь улс төрийн цаад учир шаалтгаантай хэдий ч хууль зүйн зүгээс дүгнэхэд хуулийн цоорхой эсхүл дутуу зохицуулалт нь түүнд бас дэм болсон гэдгийг үгүйсгэх аргагүй юм. Монголын бодит амьдрал дээр энэ хямрал тохиолдож төрийн байгуулалтын дээд хэмжээнд хуулийн зохицуулалт дутуу байна гэдгийг мэдрүүлж өгч нотолсонд л миний бодлоор хямралын ганцхан «нааштай» тал оршиж байх шиг байна.

УИХ-ын гишүүн сайдын албыг хашиж болно, болохгүй гэдгийг Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д тодорхой заагаагүй, ердийн хуулиар зохицуулахаар үлдээснээс болж «мөрдөхын хазгай» гэгчээр ер нь Засгийн газрын хямралын эхлэл тавигдсан гэж үзэж болох билээ. Уул нь парламентын БНУ гэдгийг сонгодог утгаар нь ойлгоход Засаглалыг хуваарилах зарчим зохих модификацид орж хууль тогтоох, гүйцэтгэх засгийн зарим төлөөлөгч аль альд нь байхыг зөвшөөрдөг. Улс, нийгмийн амьдралыг гардан зохицуулж, удирдаж буйн хувьд гүйцэтгэх засгийн үүрэг ролийг илүү их ач холбогдол бүхий хэмээн үзэж, улс төрийн нам, хүчний удирдагчдаас засгийн газрыг бүрдүүлдэг ёс, уламжлал сонгодог парламентын БНУ-д (жишээлбэл Герман, Их Британи) тогтжээ. Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийн дагуу манайд тогтсон одоогийн хүчин төгөлдөр Үндсэн хуулийн эрх зүйн ёсоор Засгийн газрын гишүүн (сайд) болгохын тулд намууд нөлөө бүхий хүмүүсээ парламентын сонгуульд нэр дэвшүүлэхгүй байх, эсхүл сонгогдсоных нь дараа УИХ-ын гишүүний мандатаас нь татгалзуулах, эсхүл ерөөсөө сул боловсон хүчинээр Засгийн газрыг бүрдүүлэх аргыг хэрэглэх болоод байгаа нь огт зохимжгүй нь илт байгаа билээ. Иймд Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д УИХ-ын гишүүн сайдын албыг нэгэн зэрэг хашиж болох тухай шинэ заалтыг Үндсэн хуулийн цэцэд ямар ч эргэлзээ төрүүлэхгүй байх томъёолтойгоор оруулах нь зүйтэй гэж үзнэ. Харин тэгэхдээ сайд нэгэн зэрэг эрхэлж буй салбарт нь холбогдох УИХ-ын байнгын хорооны дарга, гишүүн байх, мөн парламентын удирдах албан тушаалыг давхар хавсрах нь мэдээжийн хэрэг зүйд нийцэхгүй тул Үндсэн хуульд үүнийг бас тусгах хэрэгтэй болно.

Төр засгийн хямралын хууль зүйн өөр нэг хүчин зүйл нь Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 6-д УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны хүчинтэй байх ирцийг (кворум) хэт дээгүүр (66,6 хувь) тогтоосонд оршиж байгаа юм. Сонгуульд ялагдал хүлээж сөрөг хүчний үүрэг роль гүйцэтгэж буй улс төрийн хүчин болон намын бүлгийн бүрэлдэхүүнд ордоггүй сул гишүүд энэхүү заалтыг урвуулан ашиглаж, засгийн эрх барьж хариуцлага хүлээж буй улс төрийн хүчний үйл ажиллагааг бойкотлох боломжийг үүгээр нээж өгч байгаа юм. Дэструктив чиг хандлага нь давамгайлсан, зөвшилцөлд хүрэх талаараа дутагдалтай, өөр ажил хөөцөлдөөд хурлаа таслах дуртай монголын улс төрчдийн хувьд хуралдааны нийм өндөр кворум тохирохгүй байгааг амьдрал харууллаа. Иймд УИХ-ын ирцийг гишүүдийн ердийн олонхи, өөрөөр хэлбэл, 39 гишүүн байхаар бууруулж өөрчлөх нь зүйтэй байна.

Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3-т сайд нарыг нэг бүрчлэн парламент томилодог журмыг өөрчилж зөвхөн Ерөнхий сайдыг УИХ томилж байхаар Үндсэн хуульд тусгамаар санагдана. Ингэснээр хувийн амбицда хөтлөгдөн өөрөө сайд болохын тулд өөрийн бүлэг, эвслийн нэр дэвшигчийг унагаадаг муухай үзэгдэл ч үгүй болно. Ерөнхий сайд Засгийн газрыг толгойлж эцсийн эцэст хариуцлага хүлээх тул багаа дангаар бүрдүүлэх хууль зүйн эрхийг нь түүнд өгөх хэрэгтэй. Мэдээжийн хэрэг улс төрийн аргаар Ерөнхий сайдад нам нь, эвслийн түнш нь нөлөөлж болох юм. Одоо харин Ерөнхий сайдтайгаа таарж тохирохгүй олон хүний цуглуулгыг Монгол Улсын Засгийн газар гэж үзнэ гэхэд хилсдэхгүй байдал үүсэх боломжийг манай Үндсэн хууль бүрдүүлж өгч байгаа юм. Ийм маягийн бүлэг хүмүүст улс орны хувь заяаг атгуулах нь ихэд аюултай тоглоом билээ. Ерөнхий сайдыг томилохдоо УИХ-ын гишүүд илээр санал өгөх тухай санал гараад байгааг чөлөөт ардчилсан ёсонд харшлах тул хүлээн зөвшөөрч болохгүй юм. Нууцаар санал өгнө гэдэг маань аливаа чөлөөт сонгуулийн салшгүй арга хэрэгсэл гэдгийг мартмааргүй байна. Сонгогч (энэ тохиолдолд императив биш, чөлөөт мандаттай УИХ-ын гишүүн) аливаа дарамт нөлөөлөлд үл автан өөрийн дотоод итгэл үнэмшлийн дагуу л шийдвэрээ гаргах боломжтой байх ёстой билээ.

Ерөнхий сайд (Засгийн газар)-ыг огцруулах, өөр Ерөнхий сайдыг томилох журмын хувьд ХБНГУ-ын Үндсэн хуулийн 67,

68 дугаар зүйлийн «бүтээлчээр (конструктив) үл итгэх» зарчмыг нэвтрүүлэх хэрэгтэй гэж үзнэ. Ваймарын БНУ-ын үед райх-ын засгийн газрыг райхстаг (парламент) олон удаа огцруулж харин шинээр байгуулах үүрэггүй байсан тул («дэструктив» бүрэн эрх) эл гашуун туршлагаасаа германчууд суралцан парламентыг сахилгажуулж, канцлэрыг огцруулахдаа шууд дараагийн канцлэрыг парламент заавал томилох нөхцөлтэй уялдуулах болсон ажээ. Шинэ канцлэрыг томилоогүй бол урьдах нь огцроогүй гэж тооцогдоно. Манайд удаан оршин тогтносон «Үүрэг гүйцэтгэгч Засгийн газар» гэсэн ойлголт ийнхүү Германд байхгүй болсон ажээ, хуучин эсхүл шинэ л Засгийн газар (канцлэр) байна. Ийм байдлаар парламентаас томилогдсон канцлэр-ыг Улсын Ерөнхийлөгч нь шууд хүлээн зөвшөөрөх үүрэгтэй. Сонгуулийн дараа парламентын шинэ бүрэн эрх нь эхэлж буй нөхцөл байдлаас шал өөрөөр хандаж Улсын Ерөнхийлөгчийн оролцоогүйгээр ийнхүү Канцлэрыг (Ерөнхий сайдыг) томилох ажиллагаа явагдаж байгааг бас харгалзах хэрэгтэй.

Сонгуулийн хугацаа дусаагүй байхад ийнхүү засгийн газраа өөрчлөх бүрэн эрх парламентын БНУ-д парламентад дангаар хадгалагддаг аж. Тэгэхдээ Засгийн газрыг байгуулах, огцруулахад сонгуулийн үр дүнг «байнга» харгалзах гэдэг нь хэтэрхий догматик үзэл билээ. Засгийн газрыг бүрдүүлж буй олонхи хагарах тохиолдолд парламент доторхи сөрөг хүчинтэй хагарсан олонхийн аль нэг хэсэг нь эвсэх замаар засгийн эрхийг барих шинэ олонхи үүсч болох юм. Парламентад засгийн эрхийг барих эрмэлзэлтэй ийм шинэ олонхи бодит байх тохиолдолд заавал «хуучин олонхид» Засгийн газар байгуулах эрхийг өгөөд байх утгагүй юм. Манай одоогийн практикт Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1-ийн 2-ыг их догматик байдлаар хэрэглээд байна: заавал «УИХ-д олонхи суудал авсан намтай .. зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг» УИХ-д Ерөнхийлөгч оруулаад байгаа билээ. Гэтэл жишээлбэл, Германд 1982 онд ГСДН ба ЧАН-ын эвслийн (канцлэр Х.Шмидт-ын) засгийн газрыг ЧАН-ын нэлээн хэдэн гишүүн «урваж» сөрөг хүчинтэй (ХАХХНХ) нийлж Х.Коллийг гаргаж ирж байсан билээ.

Сая дурьдсан Үндсэн хуулийн заалтын дагуу Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх үйл ажиллагаанд нэг талаас Ерөнхийлөгч, нөгөө талаас олонхи болсон нам, эвсэл зөвшилцэх ёстой байгаа

билээ. Харин зөвшилцөж чадахгүй байх тохиолдолд УИХ Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1-ийн 6-д заасан үндсэн бүрэн эрхээ Ерөнхийлөгчийн оролцоогүйгээр дангаар хэрэгжүүлэх ёстой юм. Монгол Улсаас гадаад оронд суух Элчин сайдыг томилох процедурт (Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1-ийн 5) иймэрхүү практик тогтоод байгаа билээ: УИХ-тай зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Ерөнхийлөгч үндсэн бүрэн эрхийнхээ асуудлыг дангаар шийдэж буй.

Эцэст нь УИХ өөрөө тарах, түүнийг тараах тухай Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн 2-ын зохицуулалтыг харж үзмээр байна. Энд бас л юмыг урьдчилан харах чадавхи дутсан шиг санагдана: өөр нэг субъект тарахыг санал л болгохоос биш УИХ-ыг тараах хууль зүйн нөхцөл, боломж байхгүй, гишүүдийнхээ гуравны хоёроос доошгүйн саналаар УИХ өөрөө тарах л боломжтой юм. (Гэхдээ тус заалтын текстийг уншихад УИХ ердийн олонхийн шийдвэрээр ч тарж болохоор ойлгогдоод байгааг бас анхаарууштай). Миний энэ талаархи санал бол ердийн олонхи нь л УИХ тарах шийдвэр гаргахад хангалттай юм: УИХ-ын 39 гишүүний саналаар УИХ тарах тухай шийдвэрээ гаргана гэсэн үг. УИХ-ын гишүүдийн дотор олонхи нь УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж зохих дүгнэлт хийгээд байгаа нь угтаа УИХ тарах хангалттай үндэслэл юм; тэгээд ч хуулийн хүчээр нийм УИХ-ыг албадан байлгаад байх утгагүй юм.

Улс орны амьдралд учирч буй саад бэрхшээл Үндсэн хуулийн дутуу буюу алдаатай зохицуулалтаас шууд бус, гэхдээ хамааралтай гэдэг нь нэгэнт тодорхой болоод буй энэ үед Үндсэн хуульд цаг алдалгүй зохих засвар өөрчлөлтийг хийх шаардлага байна гэж үзэж байна. Энэ өгүүллийг бичихдээ аль нэг улс төрийн хүчний байр сууринаас хандаагүй гэдгийг энд зориуд дурьдах байна.

ЧИНГИСИЙН ТӨРИЙН ҮЗЭЛ

© 1999 он. Ц.МИНЖИН¹

Их хаадын оршин ахуй тэр л үеэс эдүгээ хүртэл түмэн үеийн баатруудын билэг төгс сургаал оюуны мөнхийн бүтээлд шингэх ертөнцийг үзэх үзлийн нэгээхэн хэсэг төрийн үзлийн талаарх их хүмүүний үзэл бодлыг тольдвоос: Европ, Азийг нэгтгэсэн их гүрний төрөөс явуулж буй гадаад дотоод бодлого нь Чингис хааны төрийг үзэх үзлийн илрэл байв. Тэрээр дотоод бодлогоо феодал ангийн эрх ашигт тохируулан шийдвэрлэж байсан нь тухайн үедээ илүү дэвшил бүхий нийгмийг цогцлоход хүргэжээ. Үүний зэрэгцээгээр улс аймаг уруу довтолон газар нутаг, ард түмнийг өөрийн эрхшээлд оруулж, хялбар замаар шинэ хүчийг бүрдүүлэх гэсэн гадаад бодлогоор хэрэгжиж байв.

Чингис хааны төрийн бодлого нь бүх улс орны амьдралыг цэргийн зохион байгуулалтад оруулж, улмаар харь орнуудын эсрэг шууд түрэмгийлэл хийхэд хүрчээ. Нүүдэлчдийн эдийн засгийн харьцангуй хязгаарлагдмал нүүдлийн мал аж ахуй нь феодал ноёдын өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангаж чадахгүйд хүрэв. Тэрээр Монголын нийгэм дэх дотоодын дайн самуунаа даван туулж, нэгдмэл хүчийг буй болгов. Чухам энэ л үед феодалын шинэ залуу хүчирхэг нэгдсэн төр улсыг толгойлж, өөрийн тойрон хүрээлэгчдийн эрх ашгийг ард түмэнд тулган хүлээлгэх болов. Үүгээр л Чингисийн улс төр, цэргийн үйл ажиллагаа нь тодорхойлогдож байв. Талын нүүдэлчдийн үзэл санаа нэвт шингэсэн Чингис тулгар төрийн дээд ангийг бүрдүүлж буй алтан ургийн улс язгууртны улс болж, Их гүрний эзэн хаан тэнгэрийн хүү гэгдэх болов. Чингис насан турш тэнгэрийн зарлигаар бүх дэлхийг эзлэн захирах заяатай хэмээн өөртөө итгэж явжээ.²

Тэр үеийн гадаад улс орны хооронд Монголын хүчирхэг болж буй нь уг улсын удам, түүний эзэн Тэмүжин хуучин тэнгэрлэг язгууртай Хияд яснаас гаралтай ба тэнгэрийн цээлийн алтан гадас од дугаа тохиолдон төрсөн тул тэрхүү улстай хамаагүй халдан харилцаж болохгүй³ хэмээн хэлэлцэж байжээ.

¹ «Шихихутуг» ХЗДС-ийн ГҮ дамжааны оюутан.

Монголын цэрэг арми, зэвсэг техник, цэргийн ухаан, сахилга бат, зохион байгуулалт нь феодалын төрийн хүчирхэг хэрэгсэл болж улмаар тэдний байлдан дагуулалтыг амжилттай болгоход хүргэсэн чухал хүчин зүйлийн нэг мөн.

Чингисийн цэргийн тоо их биш боловч хөдөлгөөнт чанараар гавшгай тул олон цэрэг мэт үзэгдэх аж. Тийнхүү нүүдэлчдийн морин цэрэг байлдах гайхамшигт ур чадвартай хурдан шаламгай нь ялангуяа нэгдмэл удирдлага, нарийн боловсруулсан довтолгооны төлөвлөгөө, төмөр мэт сахилга баттай хосолсон үед улам ч хүчтэй байжээ.⁴ Үүний хамт тэр үедээ харьцангуй өндөр цэргийн техникийг хэрэглэсэн явдал, мөн түүнчлэн монгол цэргийн жанжуудын дайн явуулах урлаг нь монголчуудыг ялалтад хүргэх бас нэг чухал зүйл болж байв.⁵

Ази, Европын улсуудын феодал хоорондын дотоодын самуунд доройтон суларсан явдал мөн дотоод зөрчилдөөндөө идэгдсэн хөгжингүй феодалын тархай бутархай улс орны цэргийг монголын байлдан дагуулагчид харьцангуйгаар бут ниргэжээ.

Чингис хаан өөрийн ноёд түшмэдэд хандаж хэлсэн нь: «Алтан улсын хаад нь зөөлөн намуун, жаргал цэнгэлд шунаж, бичгийн түшмэдийн хоосон хоншоорыг чимэглэх үгсэд хууртан, төрийн хүнд эрхийг цөм бичгийн сайдад бариулснаар цэргийн түшмэд цөм цэргийн эрдмийг орхин гээгээд бичигт орон хичээллэж, эрхэм ихийг хөөцөлдсөнөөр улсын цэргийн суртлыг нэг мөсөн дуусгаж, баахан авууштай хүн боловоос бичгийн замаар баян эрхэмийг хичээсээр цэргийн хэрэгт шунах хүнгүй болжээ. Хэдийгээр цэргийн хэргийн тушаалтан байвч хоосон нэрийн төдий гээгдэж орхигдсон үлэмж мунхаг хүн болжээ. Нэг ч үнэн эрдэм чадалт ихэс жанжууд үгүй болсон тул дор цэргийн ард шууд морь унан зэвсэг барин чадахгүйд хүрчээ»⁶ гэв. Тэрээр Алтан улсын сайдад явуулсан бичигтээ: «Эдүгээ танай Алтан улс хөвгүүн нь эцэг, эхээ хороож, түшмэл нь эзнээ алж, ах, дүү харилцан тэмцэлдэж, иргэн нь эзнээсээ урваж, эрх буян-үнэн эрдэмгүйн туйлд хүрсэн тул энэ мэт олон аймаг улсууд харилцан тэмцэлдэж, дөрвөн зуун он илүү дэлхий дахины хүн амьтныг өчүүхэн ч амраалгүйд би тэнгэрийн бошгоор нэгэн үзүүрт сэтгэлээр 13 наснаас цэрэг байгуулж, дөрвөн зүг дайран явж, бага аймаг 75, их улс 12-ыг тус тус түвшитгэж, одоо амар тайван суусугай гэтэл

Алтан улсын хэсэг хүмүүс харанхуй харгист тэсэхгүй болж, надад заргалдахаар ирснийг уламжлав»⁷ гэж өгүүлжээ.

Ийнхүү Монголын нэгдсэн тулгар төрийг байгуулж, түүний үүрэг ач холбогдлыг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийг өмнөх төрүүдээс улам нарийсгаж, хууль цаазыг буй болгон мөрдүүлж, үлгэр жишээ болохуйц цэрэг арми байгуулан бэхжүүлж, хатуу чанга сахилга бат тогтоож, төрийг байнга хайрлан бэхжүүлэхийн чухлыг бүх талаар үндэслэсэн нь Чингис хааны төр ёсны үзэл байв. Энэхүү үзэл нь түүний үйл хэргийг цааш залгамжлан үргэлжлүүлсэн үр, ач нарынх нь үед уламжлан хөгжиж байлаа. Тэгэхдээ тухайн шинэ нөхцөл байдлын дагуу зохих өөрчлөлтүүд гарч байсан бөгөөд нягталбаас уг төр нь цэргийн засаглалаас иргэний засаглалд улам бүр шилжих болсон нь түүхэн үнэн ажээ.

² Владимирцов.Б.Я. «Чингис хаан» Берлин., 1922 он, 152-р тал

³ Фидлинс.Е.Д. «Монголын түүх. Чингис хаан хийгээд түүнийг залгамжлагчид» Өвөр Монгол хэвлэл. Хөх хот. 1983 он, 61-р тал

⁴ «Монгол татарууд Ази, Европт» эмхтгэл. УБ., 1984 он. 137-р тал

⁵ Ч.Жүгдэр. «Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ». 111-р тал

⁶ Инокимаш. «Хөх судар» 1,2,3-р дэвтэр. Өвөр монгол хэвлэл. 363-364-р тал

⁷ Инокимаш. «Хөх судар» 1,2,3-р дэвтэр. Өвөр монгол хэвлэл. 1796-р тал

ЭД ХӨРӨНГИЙН БУС ГЭМ ХОРЫН ТУХАЙ АСУУДЛЫГ ШИНЭЭР АВЧ ҮЗЭХ НЬ

©1999 он. Балдангомбын БАТ-ЭРДЭНЭ¹

Гэм хорын тухай асуудал эртний улсуудад эрх зүйн тухай анхны үзэл номлол бий болсон үеэс эх үндэстэй. Түүнээс хойш энэхүү ойлголт нь деликт буюу гэрээний бус үүргийн эрх зүй хэмээх иргэний эрх зүйн бие даасан институт болон хөгжиж иржээ.

Иргэний эрх зүйд гэм хор гэдэгт бусдын эд хөрөнгийн болон бусад хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөний дүнд үүссэн тааламжгүй үр дагавар, өөрчлөлтийг хамааруулан авч үздэг. Бусдад учруулсан гэм хорын мөнгөөр илэрхийлэгдэх нэгж нь хохирол юм. Гэм хорыг учирсан хохирлоор нь шалгуур болгон хоёр ангилж болох бөгөөд хохирол нь тодорхой мөнгөн дүнгээр хэмжигдэж байгаа нөхцөлд эд хөрөнгийн буюу материаллаг гэм хор, эсрэг тохиолдолд эд хөрөнгийн бус гэм хор гэж ялган үзэж болно. Материаллаг гэм хор нь эд юмс үрэгдэх, гэмтэх, цалин орлого, хөдөлмөрийн чадварыг тодорхой хугацаагаар алдах эсвэл бусад нэмэлт зардал гаргах зэргээр хохирогчийн эд хөрөнгийн байдалд өөрчлөлт оруулдаг байна. Тэгвэл эд хөрөнгийн бус гэм хор нь эдийн засгийн буюу таваар-мөнгөний агуулдаггүй байдаг ба түүнд сэтгэл санааны гэм хор багтдаг.

Сэтгэл санааны гэм хор гэж юуг ойлгох, түүний төрөл хэлбэр, гэм хор учруулагчид хүлээлгэх хариуцлагын тухай ойлголт саяхныг хүртэл эрх зүйч эрдэмтдийн дунд маргаантай асуудлын нэг байсан юм. Өргөн утгаараа «Сэтгэл санааны гэм хор гэж иргэний төрөлхийн заяагдмал эсвэл хуулиар олгогдсон материаллаг бус баялагт халдсан, түүнчлэн иргэний хувийн эд хөрөнгийн бус эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас учирсан бие махбодь, санаа сэтгэлийн зовлон, шаналгаа юм»¹. Энэхүү зовлон шаналгаа нь хүчтэй өвдөлтийг мэдрэх, өлсөж цангах, даарч хөрөх гэх мэтчилэн хүний бие эрхтний тааламжгүй сэрлийн хэлбэрээр болон айдас түгшүүр, гомдол бухимдал, ичгүүр, гашуудал зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийн байдлаар хүний сэтгэцэд нолоолддог. Сэтгэл санааны гэм хор нь нийгмийн амьдралд идэвхитэй оролцох

¹ «Шинэхутуг» ХЗДС-ийн III дамын аюулан.

боломж нь хязгаарлагдах; гэр бүлийн болон хувийн нууцыг задруулсан, үнэн байдалд нийцэхгүй мэдээ баримт тарааснаас нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд унах; өөрийнхөө дутууг цаг ямагт мэдрэх; эрхэлсэн ажлаа алдсанаас санаа сэтгэлийн таагүй үр дагаврыг амсах; осол гэмтэл болон өвчлөлтэй холбоотойгоор бие махбодийн шаналал амсах зэрэг ямар ч байдлаар илэрч болно. Сэтгэл санааны гэм хор нь ихэвчлэн туйлын эрхийн харилцааг зөрчсөний дүнд үүсдэг бөгөөд гэм хорын асуудал гагцхүү оюун ухаант бодгаль болох хүн дээр яригддаг онцлогтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд тунхаглан заасан иргэний хувийн эрх, эрх чөлөө, бусад материаллаг бус баялаг нь Иргэний хуулийн 377 дугаар зүйлд амь бие, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамааруулан тусгагдсан байна. Гадаад орнуудын иргэний хууль тогтоомжоос үзэхэд материаллаг бус баялаг, хувийн эд хөрөнгийн бус эрхэнд юу хамаарагдахыг дэлгэрэнгүй заасан байх бөгөөд ингэснээр иргэн хүн өөрийн субъектив эрхээ хэрэгжүүлэхэд нь тус дөхөм болдог байна. Тэдгээрт нийтлэг зүйл нь амь бие, эрүүл мэнд, хувийн халдашгүй дархан байдал, алдар хүнд, нэр төр, ажил хэргийн нэр хүнд, хувийн амьдралын болон гэр бүлийн нууц, түүний халдашгүй байдал, чөлөөтэй зорчих, түр ба байнга оршин суух газраа сонгох эрх, зохиогчийн эрх болон бусад материаллаг бус баялаг, эд хөрөнгийн бус эрхийг хамааруулжээ. Польшийн Иргэний хуульд хүний гадаад төрх, орон байрны халдашгүй байдлыг оруулсан бол Унгарын Иргэний хуульд хөрөг зураг, дуу бичлэг, хувь хүнд хамааралтай компьютерийн мэдээллийг багтаасан байна. Материаллаг бус баялаг, эд хөрөнгийн бус эрх нь хувь хүнээс салшгүй, зөвхөн төрснөөр болон хуулиар иргэнд харьяалагдах бөгөөд өөр бусад замаар шилждэггүйгээрээ онцлог юм.

Гэрээний бус үүргийн эрх зүйн нийгмийн үнэ цэнэ түүний бусдад учруулсан хохирлыг бүрэн арилгуулахад чиглэдэгт оршино. Сэтгэл санааны гэм хорын хувьд хохирол нь бодитой бус, хүний сэтгэцэд сөргөөр туссан нөлөөлөл байдаг учир хохирлыг арилгах бус харин иргэний эрх зүйн харилцаага, нөхөн олговрын асуудлыг авч үзэх нь зүйтэй. Учир нь хүний амь нас, нэр алдар зэрэг материаллаг бус баялгийг мөнгөөр үнэлэх

боломжгүй билээ. Сэтгэл санааны хохиролд нөхөн олговор гаргуулах ерөнхий үндэслэлд гэм хор учруулагчийн бусдын эд хөрөнгийн бус эрхийг зөрчсөн болон бусад материаллаг бус баялагт халдсан үйлдэл, эс үйлдэл; тухайн иргэн бие махбодь, санаа сэтгэлийн хувьд зовлон шаналгааг биеэр амосан байх; сэтгэл санааны хохирол үйлдлийн хоорондох шалтгаант холбоо; гэм хор учруулагчийн гэм бурууг хамааруулдаг. ОХУ-ын Иргэний хуулийн 1100 дугаар зүйлд орчин тойрондоо онц аюултай эх үүсвэрээс амь бие, эрүүл мэндэд гэм хор учирсан; бусдыг хууль бусаар хорьсон, эрүүгийн хариуцлагад татсан, захиргааны журмаар баривчлах болон засан хүмүүжүүлэх ажил хийлгэсэн, таслан сэргийлэх арга хэмжээг хууль бус хэрэглэсэн болон бусдын алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ мэдээлэл тараасан тохиолдолд сэтгэл санааны хохиролд гэм хор учруулагчийн гэм буруугаас үл хамааран нөхөн олговор гаргуулахаар заажээ.

Монгол Улсын Иргэний хуульд сэтгэл санааны гэм хорын талаар 392 дугаар зүйлд заасан байдаг. Гэвч дээрх зүйлд явцуу хүрээгээр тусгагдсан учир иргэд сэтгэл санааны гэм хор гэдэгт хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэн байдалд нийцэхгүй мэдээ, баримт тараасны дүнд үүсэх санаа сэтгэлийн таагүй байдлыг ойлгодог байна. Энэ нь шүүхээс хянан шийдвэрлэж байгаа материаллаг бус гэм хортой холбоотой иргэний хэргийн дийлэнх хувийг энэ төрлийн маргаан эзэлж байгаагаас харагдаж байна. Анх 1995 онд сэтгэл санааны хохиролд 380 мянган төгрөгийн нөхөн олговор гаргуулах шийдвэрийг Баянгол дүүргийн шүүхээс гаргажээ. Үүнээс өмнө сэтгэл санааны хохиролд мөнгөн хэлбэрээр нөхөн олговор гаргуулах явдлыг үгүйсгэж байсан юм. Энэ нь тухайн үеийн нийгмийн үзэл сурталтай холбоотой бөгөөд хүний эрхэм нандин зүйл болох нэр төр, алдар хүндийг мөнгөнд шилжүүлэх нь социалист ёс суртахуунд харш зүйл хэмээн үзэж байв. Гэвч сүүлийн үед нэр төрөө гутаалгасны сэтгэл санааны хохиролд нөхөн олговор гаргуулах асуудал, түүний нэхэмжлэлийн үнийн дүн тогтмол өсөж ирсэн нь анхаарал татаж байна. 1996 онд иргэдээс нэр төрөө гутаалгасны хохиролд нийт 142.8 сая төгрөг нэхэмжилж байсан бол 1998 онд зөвхөн нэг нэхэмжлэлийн үнийн дүн 100 сая төгрөг болж өссөн нь дээрх хэм хэмжээг өнөөгийн нөхцөлд тохируулан боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Эх газрын эрх зүйн системийн орнуудын Иргэний хуульд гэм хорын тухай ерөнхий зохицуулалт үйлчлэхээс гадна сэтгэл санааны гэм хорын талаар тодорхой тусгагдсан байдаг. Германы Иргэний хуулийн 253 дугаар зүйлд сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах ерөнхий зохицуулалт үйлчлэхээс гадна 12, 847, 1300 зэрэг зүйлүүдэд сэтгэл санааны гэм хорын тодорхой хэлбэрүүдийг тусгасан байдаг бол ОХУ-ын Иргэний хуулийн шинэчилсэн найруулгад сэтгэл санааны гэм хор, түүний нөхөн олговрын асуудлыг ерөнхий байдлаар дэлгэрэнгүй тодорхойлсон байна. Эх газрын эрх зүйн системийн орнуудын сэтгэл санааны гэм хорын тухай зохицуулалтын ерөнхий хандлагыг авч үзвэл түүнийг бүрэн үгүйсгэх, хуульд заасан тодорхой төрлийн эд хөрөнгийн бус гэм хорыг хүлээн зөвшөөрөх эсвэл ерөнхий зохицуулалтаар нээлттэй байдлаар шийдвэрлэх гэсэн үндсэн гурван чиглэлтэй байна. Англи-Саксоны эрх зүйн системд ерөнхий деликт үйлчилдэггүй бөгөөд сэтгэл санааны хохиролд нөхөн олговор гаргуулах талаар эх газрын орнуудын зохицуулалттай ойртох хандлагатай байна. Энэ нь сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтооход шүүхэд өргөн боломж олгодгоороо давуу талтай юм.

Сэтгэл санааны хохирлын нөхөн олговрын хэмжээг бодитой тогтоох нь онолын болоод шүүхийн практикт маргаантай асуудлын нэг юм. Учир нь сэтгэл санааны гэм хор нь материаллаг бус байдлаар илэрхийлэгддэгээрээ шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхэд бэрхшээл учруулдаг байна. Эндээс үүдэж сэтгэл санааны нөхөн олговрын хэмжээг хууль тогтоомжид хэрхэн тусгах тухай асуудал гарч ирдэг. Үүнийг эх газрын эрх зүйн системд хуульд нэг мөр зааж өгөх, түүний дээд доод хэмжээг тогтоох, эсвэл шүүхээс тогтоох гэсэн гурван хэлбэрээр зохицуулж болох юм. Иргэний эрх зүйн түүхэн уламжлалыг эргэн харахад эртний Ромд бусдын бие эрхтэнд гэм хор учруулсны торгуулийг хатуу тогтоосон нь зөрчлийн онцлогийг харгалзан үзэхэд бэрхшээл учруулж байсан учир претороос хэргийг шийдэж байгаа магистратын үзэмжээр тогтоож байхаар өөрчилж байжээ. Өнөө үед зарим орнууд сэтгэл санааны хохирлын нөхөн олговрын дээд хэмжээг хуулиар тогтоосон байдаг. Мексикийн Иргэний хуульд сэтгэл санааны хохирлын нөхөн олговрын хэмжээ материаллаг хохирлын гуравны нэгээс хэтэрч болохгүй гэж заасан бол Литва улсад мэдээллийн хэрэгслээр бодит байдалд нийцэхгүй мэдээ,

мэдээлэл тараасан тохиолдолд иргэнд олгох нөхөн олговрын дээд хэмжээг хуулиар шууд тогтоосон байна. Монгол Улсын Иргэний хуульд хохирлын хэмжээг шүүхээс тогтоож байхаар хуульчилжээ.

Сэтгэл санааны хохирлын нөхөн олговрын хэмжээг шүүхээс тогтоохдоо гэм хор учруулагчын гэм буруу, нэхэмжлэгчийн бие махбодийн болон санаа сэтгэлийн зовлон, шаналал амссан шинж байдлыг харгалзан үзэх ёстой. Зовлон, шаналгааг амссан шинж байдлыг тодорхойлохдоо сэтгэл санааны хувьд хохирсон этгээдийн нас, хүйс, сэтгэцийн онцлог шинж, эрүүл мэндийн байдал зэрэг хувийн болон бусад нөхцөл байдлуудыг авч үзэх нь зүйтэй юм. Сэтгэцийн шинж гэдэг нь тухайн хувь хүнд байдаг түүний үйл ажиллагаа, зан төрхийг тодорхойлж өгдөг сэтгэцийн тогтвортой бүрдэл бөгөөд хүний зан төлөв, темпераментийг өөртөө багтаадаг.

Сэтгэл санааны хохирлын нөхөн олговрын хэмжээг тогтооход баримтлах ерөнхий зарчмыг зарим орнууд иргэний хуульдаа тодорхойлсон байдаг. Гэвч нийгмийн амьдралын олон талт байдлаас шалтгаалаад тухайн тодорхой хэрэг бүр өөрийн онцлог шинжийг агуулдаг тул шүүхээс сэтгэл санааны хохирлын нөхөн олговрын хэмжээг тогтоохдоо шударга, бодитой хандахыг шаарддаг. Бусдын эрүүл мэндэд хор учруулсан тохиолдолд гэмтлийн зэрэг, шинж байдал, түүний үр дагавар арилах эсэхийг тогтоох нь чухал ач холбогдолтой. Гэмтлийн улмаас тахир дутуу, сохор, дүлий болсон үед сэтгэл санааны гэм хор нь тухайн хүн нийгмийн амьдралд идэвхитэй оролцож чадахгүйгээс болж сэтгэцэд тусч байгаа сөрөг нөлөөллөөр илэрдэг. Дотны хүнээ алдсаны сэтгэл санааны хохиролд нөхөн олговор гаргуулахаар нэхэмжилсэн үед тэдний хэр зэрэг ойр дотно байсан, түүнчлэн мэдээллийг хүлээж авсан арга буюу уг явдал хохирогчийн нүдэн дээр болсон эсэх зэрэг нь шүүхээс анхаарвал зохих нөхцөл байдлууд юм.

Сэтгэл санааны хохирлын нөхөн олговрын хэмжээ бага байх нь зүйтэй юм. Учир нь сэтгэл санааны хохирлын нөхөн олговор нь зөрчигдсөн эрх, ашиг сонирхлын мөнгөн эквивалент бус, харин хохирогчид учирсан санаа сэтгэлийн таагүй үр дагаврыг ямар нэг хэмжээгээр багасгах, түүнчлэн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэдэг. Манай улсын

хувьд сэтгэл санааны хохирлын нөхөн олговрын дээд хэмжээг хуудьчлан тогтоож, зах зээлийн харилцаа бүрэн төлөвшөөгүй, мөнгөний ханш байнга өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд энэхүү хэмжээг хүн амын амьжиргааны түвшинтэй уялдуулан Улсын Дээд Шүүхээс тухай бүр шинэчлэн тайлбарладаг практик хэвшүүлж болох юм. Шүүхээс энэхүү хязгаарын дотор нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хэргийн онцлогоос шалтгаалан хэмжээг эцэслэн тогтоох ба ингэснээр үндэслэлгүйгээр хэт их мөнгө нэхэмжлэх, үл ялиг шалтгаар нэхэмжлэл гаргах зэрэг иргэдийн материаллаг сонирхол буурахын зэрэгцээ иргэдээс зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахдаа сонгох нөхцлийг илүүтэй бүрдүүлнэ. Иргэдийн материаллаг бус баялаг, эд хөрөнгийн бус эрх нь иргэний төдийгүй эрүүгийн болон бусад салбар эрх зүйн хамгаалалтанд байдаг. Үүний жишээ нь, саяхан сонинь сурвалжлагчдад хүний нэр алдрыг гутаасан мэдээ тараасны учир шүүхээс эрүүгийн харнуцлага хүлээлгэсэн явдал юм. Түүнчлэн шүүхээс эд хөрөнгийн бус хохирлыг заавал мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх бус төрөл бүрийн үйлчилгээ, туслалцаа үзүүлэх, эд зүйлс өгөх, няцаалт хийлгэхийг үүрэг болгох зэргээр барагдуулж болох юм.

Эцэст нь дүгнэж хэлэхэд сэтгэл санааны гэм хорыг мөнгөөр үнэлэн тогтоох боломжгүй бөгөөд түүний нөхөн олговор нь иргэдийн санаа сэтгэлд сөргөөр туссан үр дагаврыг цайруулахад чиглэсэн нийгмийн үнэлэмж юм гэдгийг дурдах нь зүйтэй.

¹ ОХУ-ын Дээд Шүүхийн бүгд хурлын 1994 оны 12 дугаар сарын 20-ны тогтоол

**“ТӨРИЙН ТЭРГҮҮН, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ”
СЭДЭВТ МАГИСТРЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН
БҮТЭЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Удирдсан: Хууль зүйн ухааны доктор /Ph/, профессор
Д.Лүндээжанцан.

Шүүмж бичсэн: Хууль зүйн ухааны доктор /Ph/, профессор
С.Төмөр.

Гүйцэтгэсэн: “Шихихутуг” ХЗДС-ийн багш, хууль зүйн
ухааны магистр Дашдондогийн Үүрцайх.

Хүн төрөлхтөн хөгжлийн тодорхой төлөвийг олсон үеэс эхлээд өнөөг хүртэл бид хэн нэгнийхээ удирдлагаар амьдарч ирсэн.

Хүмүүс овог бүлгээрээ амьдардаг байсан эртний үед тэдний хооронд өөрсдийн төрөлх эрхээ эдлэх, хэрэгжүүлэх явцад аяндаа зохицох боломжгүй, эвлэршгүй зөрчил гарсан бөгөөд цусан өшөө авах, хүчтэй нь хүчгүйгээ дарлах, хүчгүй нь үргэлж буруутгах байдлаас гарахын тулд хүмүүс овог дотроосоо хүч чалалтай, ухаалаг нэгнийгээ овгийн ахлагчаар томилж, өөрсдийгөө удирдуулах болсон байна. Ийнхүү анхны овог аймаг, улмаар төр улсууд үүссэн бөгөөд овгийн ахлагч нар бол үнэн хэрэгтээ анхны төрийн тэргүүнүүд байжээ.

Төрийн тэргүүн, түүний эрх зүйн байдлын талаарх асуудлыг судлах нь төрийн удирдлагын хэлбэрээ зөв сонгох, засаглалын эрх мэдлийг хуваарилах зарчмыг тухайн орны нөхцөл байдалд үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

Төрийн тэргүүний эрх зүйн байдал тухайн орны төрийн удирдлагын хэлбэр, засаглалын эрх мэдлийн хуваарилалт зэргээс шалтгаалаад улс орон бүрт харилцан адилгүйгээр тодорхойлогдсон байдаг. Ихэнх ардчилсан улс оронд төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч байдаг бөгөөд зарим улсад хаан байна. Төрийн тэргүүн гэдэг нь төрийг бүрэн эрхтэй төлөөлж, улс үндэстнийхээ эв нэгдлийг ханган баталгаажуулагч байдгаар түүний эрх зүйн байдлын үндсэн онцлог илэрнэ.

Төрийн тэргүүн, түүний эрх зүйн байдлын талаарх асуудлууд нь улс төр судлал, төрийн онол, Үндсэн хуулийн эрх зүй зэрэг олон шинжлэх ухааны үндэс судлагдаг өргөн хүрээтэй асуудал юм.

Монголын эрх зүйн шинжлэх ухааны түүхэнд өнөөг хүртэл төрийн тэргүүний эрх зүйн байдал, түүнийг боловсронгуй болгох асуудлаар төрийн онолын болон Үндсэн хуулийн эрх зүйн аспектаар

авч үзсэн бие даасан судалгааны ажл болон нэг сэдэвт зохиол бүтээл хараахан гараагүй байна.

Уг ажлыг бичих явцд боловсруулж, гарган тавьж буй санал дүгнэлтүүд нь Монгол улсын төрийн удирдлагын хэлбэрийг өөрчлөх боломж, шаардлагыг тодорхойлох, Монгол улс дахь өнөөгийн төрийн тэргүүний эрх зүйн байдал болон засаглалын эрх мэдлийн хуваарилалтыг боловсронгуй болгоход чиглэгдсэнд энэхүү судалгааны ажлын практик ач холбогдол оршино.

“Төрийн тэргүүн, түүний эрх зүйн байдал” хэмээх энэ ажил маань бүтцийн хувьд удиртгал, “Төрийн тэргүүний тухай ойлголт, түүний засаглалын эрх мэдлийн хүрээнд эзлэх байр суурийн талаарх онолын үндсүүд”, “Төрийн тэргүүний эрх зүйн байдлын талаарх түүхэн уламжлал”, “Төрийн тэргүүний эрх зүйн байдал” гэсэн гурван бүлэг, дүгнэлт, ном зүйгээс бүрдэж байгаа юм.

“Төрийн тэргүүний тухай ойлголт, түүний засаглалын эрх мэдлийн хүрээнд эзлэх байр суурийн талаарх онолын үндсүүд” хэмээх эхний бүлэгтээ төрийн тэргүүний институтыг өнөөгийн дэлхийн улс гүрнүүдийн нийтлэг үнэт зүйлс болоод байгаа эрх зүйт төрийн онол, засаглалын эрх мэдлийг хуваарилах онол, бүгд найрамдах ёсны онол болон төрийн удирдлагын хэлбэрийн талаарх сэтгэгчдийн үзэл сургаал, орчин үеийн онолын үндсэн чиглэлүүдэд хэрхэн авч үздэг талаар судалсан юм.

“Төрийн тэргүүний эрх зүйн байдлын талаарх түүхэн уламжлал” хэмээх хоёрдугаар бүлэгтээ Монгол улсын төрт ёсны түүхэн дэх төрийн тэргүүнүүдийн тухай, тэдгээрийн бүрэн эрх, үйл ажиллагааны талаар товчоолон авч үзсэн бөгөөд ингэхдээ тодорхой түүхэн үе шатууд дахь төрийн тэргүүнүүдийн эрх зүйн байдлын нийтлэг болон онцлог талуудыг голлон харуулахыг оролдсон билээ.

“Төрийн тэргүүний эрх зүйн байдал” гэсэн гуравдугаар бүлэг нь гурван зүйлээс бүрдэж байгаа бөгөөд эхний зүйлд галаад орнуудын Үндсэн хуулинд төрийн тэргүүнүүдийн эрх зүйн байдлыг хэрхэн зохицуулсан талаар болон Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны аспектаар төрийн тэргүүнүүдийн хууль зүйн хэлбэрүүд, тэдгээрийн бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх баталгаа, сонгох, үе залгамжлах процессийн журам, төрийн тэргүүнүүдэд туслах байгууллагуудын талаар товч харьцуулан авч үзсэн юм.

“Монгол улсын төрийн тэргүүний эрх зүйн байдал” гэсэн

хоёр дахь зүйлд Монгол улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг төрийн онолын болон Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаануудын аспектаар ялгамжтай судлах оролдлогыг хийсэн.

Харин “Монгол улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал болон үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд” хэмээх гурав дахь зүйлдээ өмнөх бүлгүүдээр хийсэн судалгаандаа үндэслэн өөрийн дэвшүүлж буй гол санал, дүгнэлтүүдээ гаргасан юм.

Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог төлөвшүүлэх үйл явцд эргэлт буцалтгүй нэгдэн орсон нь 1990-ээд оны ардчилсан хөдөлгөөний түүхэн ололт бөгөөд бид эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх Үндсэн хуулийнхаа зорилгыг тодорхойлж, ардчилсан Үндсэн хуулиа батлан мөрдөж байгаа билээ.

Монгол улсын төрийн байгууллагын шинэ тогтолцоо нь ардчилсан нийгэмд үйлчилдэг тэр ерөнхий жишгийн дагуу улс орныхоо өвөрмөц онцлогийг тусгасан байдлаар төлөвшин тогтож байна.

Улс төрийн шинэтгэлийн явцаар төрийн байгууллагын тогтолцоо улам боловсронгуй, харилцан нөхцөлдсөн, тогтвортой системийг бүрэлдүүлэн хөгжсөөр байгаа боловч зарим учир дутагдалтай зүйлүүд, сонголтын алдаанууд байсаар байна.

Монгол улс Бүгд найрамдах ёсыг 1924 оны анхдугаар Үндсэн хуулиараа дэлхий нийтийн хандлагад нийцүүлэн сонгож авсан боловч түүний дараах социализмын гэгдэх 70 шахам жилийн турш явагдсан улс төр, эрх зүйн өөрчлөлтийн явцд үнэн хэрэгтээ ард түмэн төрийн эрхийг барьдаг, ард түмний бүрэн эрхээс төрийн бүрэн эрх урган гардаг сонгодог бүгд найрамдах ёсны утга учир алдагдаж, нэг хүнийг тахин шүтэх, нам төр, хуулиас дээгүүр төвшинд гарч, засаглалыг хэрэгжүүлэх, шууд ардчиллын элементүүд хумигдан, хүний эрх, эрх чөлөө үнэн хэрэгтээ хэрэгжихгүй байдалд хүрсэнээр бид түүхэн боломжоо алдсан билээ. Харин шинэ Үндсэн хуулиараа бид Монгол улс нь тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс болохоо тунхаглан зарлаж, ард түмэнд төрийн эрх мэдэл жинхэнэ утгаараа шилжсэн гэж болно.

Монголчууд бид Үндсэн хуулиа засаглалын эрх мэдлийг хуваарилах онолын “зөвлөн” хувилбарыг авч хэрэглэсэн бөгөөд энэ хүрээнд хууль тогтоогчид төрийн тэргүүний эрх мэдлийг тогтоон тодорхойлохдоо ХБНГУ-ын Үндсэн хуулийн загварыг гол болгон

бусад орнуудын Үндсэн хуулинд засаглалын эрх мэдлийг хуваарилсан туршлагыг харгалзан үзэж тодорхойлсон байна.

Төрийн эрх мэдлийг хуваарилах буюу засаглал хуваах онолыг авч үзэхэд “засаглалын эрх мэдлийг хуваарилах”, “засаглал хуваах” гэсэн ойлголт, нэр томъёоны асуудлыг жигдлэх, нэг мөр ойлгох шаардлага зайлшгүй гарч ирнэ.

Төрийн эрх мэдлийн хуваарилалтын талаарх онол, сургаал, зарчмын асуудлыг “засаглал хуваах онол” гэдэг түүхэн томъёолоор нь бус, түүнийг нийтлэг жишгийн дагуу тус улсад хэрэгжүүлсэн, хууль тогтоомжинд тусгалаа олж хэлбэржсэн утгаар нь “төрийн эрх мэдлийг хуваарилах” гэж томъёолох нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь улсын дотор засаглал нь нэгдмэл байх ёстой. Харин эрх мэдлийн хүрээгээр харилцан тэнцвэртэй хуваагдаж, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах нь гарцаагүй чухал болохыг олж харахыг хүсвэл хүн төрөлхтний түүхийн мянга мянган жилийн гүнээс хайх хэрэгтэй болно.

Орчин үеийн эрх зүйт, ардчилсан, төрийн эрх мэдлийг хуваарилсан, бүтд найрамдах төрийн тухай онол сургаал нь олон зууны тэртээ бий болж, төрийн эрх мэдлийг дангаар эзэгнэх явдал буюу хэмжээгүй эрхт хаант ёсыг халж, Бүтд найрамдах засгийг тогтоох үйл явцаар практикт биелэлээ олсон бөгөөд өнөөдөр бараг бүх дэлхийн улсуудын нийтлэг жишиг, үнэт зүйл нь болон хувираад байна. Дээрх онол сургаалиудын үндсэн дээр эртнээс тогтож ирсэн уламжлалт төрийн тэргүүний төвлөрсөн эрх мэдэл нь засаглалыг хэрэгжүүлэгч субъектүүдэд харилцан тэнцвэртэй байхаар хуваарилагдаж, харин түүний салшгүй шинж болсон дотоод галаалад төрөө бүрэн эрхтэй төлөөлөх, үндэстэн ард түмнийхээ эв нэгдлийг илэрхийлэх болон бусад билэг тэмдгийн шинж чанартай бүрэн эрхүүд нь үлджээ.

Төрийн тэргүүний засаглалын эрх мэдлийн хүрээнд эзлэх байр суурь нь түүний бүрэн эрхийн хүрээгээр, тухайн улсын төрийн удирдлагын хэлбэрээр тодорхойлогдох асуудал юм.

Монгол улсын ерөнхийлөгч нь төрийн эрх мэдлийн аль салбарт хамаарах нь манай Үндсэн хуулинд зохицуулалтгүй орхигдсон юм. Үндсэн хуулийн анхны төсөл болон, түүний танилцуулагаас үзэхэд Монгол улсын ерөнхийлөгч нь УИХ, Засгийн газар, УДШ-ийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, чиглүүлэх зорилготой “зохицуулагч”-ийн үүргийг гүйцэтгэхээр тусгаж байжээ.¹ Мөн Үндсэн хуулиар тодорхойлогдсон түүний бүрэн эрхийн шинж

байдал, онцлог зэргийг харгалзан үзвэл тэрээр гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний субъект байж болохоор байгаа юм. Ер нь засаглал хуваарилах онол болон олон улсуудын Үндсэн хуулийн агуулгаас үзэхэд төрийн тэргүүн нь гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний субъект болж байдаг. Иймээс Үндсэн хуулинд түүнийг засаглалын эрх мэдлийн аль салбарт хамаарах субъект болохыг нь шууд тодорхойлон зааж өгөх шаардлагатай гэж үздэг.

Бид засаглалын эрх мэдлийг төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад хуваарилахдаа өөрийн орны онцлог байдлыг тусган өвөрмөц маягаар хуульчлан тогтоосныг анхны ерөнхийлөгч П.Очирбат Ардын Их Хурлын хуралдаан дээр хэлсэн үгэндээ “Бид Ерөнхийлөгч бүхий парламентын бүгд найрамдах улсын хэлбэрийг сонголоо” гэж тодорхойлжээ. Гэвч энэ нь учир дутагдалтай дүгнэлт болжээ гэж үзэж байна. Учир нь БНЗасгийн, хаант засгийн, зөвлөлийн засгийн аль ч үед, ерөөс аль ч төрд төрийн тэргүүн /ерөнхийлөгч, хаан/ байдаг бөгөөд эдгээр нь харин эрх мэдлийн хувьд хүчтэй юу, аль эсвэл билэг тэмдгийн төдий бүрэн эрхийг хэрэгжүүлдэг үү гэдгээр нь тухайн улсын төрийн удирдлагын хэлбэрийг тодорхойлдог.

Зарим судлаачид Монгол улсыг хүчтэй ерөнхийлөгчтэй парламентын БНУ гэж төрийн удирдлагын хэлбэрийн хувьд тодорхойлдог. Үнэхээр бид тэр бүр тохиолдоод байхгүй өөрсдөө ч ойлгохгүй өвөрмөц төрийн удирдлагын хэлбэрийг тогтоон хуульчилсан юм.

Миний бодлоор Үндсэн хуулийн 31-р зүйлд зааснаар Монгол улс нь Ерөнхийлөгчөө нэр төдий бүх ард түмнээс сонгодгийг эс тооцвол сонгодог парламентын засаглалтай улс гэж боддог.

Монгол улсын Ерөнхийлөгч бол билэг тэмдгийн төдий бүрэн эрхтэй төрийн тэргүүн гэж боддог. Учир нь манай улсын ерөнхийлөгчид байдаг засаглалын эрх мэдлийн хүрээнд хэн нэг нь эрх мэдлээ хэтрүүлсэн тохиолдолд хэрэгжүүлж болох ганцхан бодитой эрх нь УИХ-тай харилцах харилцаанд тогтоосон хуулинд хориг тавих эрх юм. Гэтэл энэ эрх нь хүртэл УИХ-ын гишүүдийн 2/3 нь хүлээж аваагүй тохиолдолд хүчингүй болдог. Тэрээр засаглалын эрх мэдлийн хуваарилалтыг “тэнцвэржүүлэгч”-ийнхээ үүргийг ихэвчлэн “тохиролцооны арлчиллын” зарчмаар хэрэгжүүлэх болдог. Харин хүчтэй ерөнхийлөгчтэй улсуудын ерөнхийлөгч нь Засгийн газрын ерөнхий сайдыг парламентад санал болгох, засгийн газрын гишүүдийг томилгох, чөлөөлөх, шаардлагатай тохиолдолд парламентыг тараах бүрэн эрхтэй байдаг. Иймээс Монгол улсын ерөнхийлөгч нь тийм

ч хүчтэй ерөнхийлөгч биш гэж үзэж болно.

1992 онд шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх үед төрийн удирдлагын ямар хэлбэр Монгол улсад тохиромжтой болохыг сонгох явдал нь нилээд маргаан дэгдээсэн бөгөөд бид парламентын БНУ-ын хэлбэрийг сонгож авсан юм. Парламентын БНУ-ын хэлбэр Монгол орны нөхцөлд тохирох төрийн удирдлагын хэлбэр гэдгийг нотлож байсан эрдэмтэн, судлаачдын онолын үндэслэл нь:

- Парламент олон хүнээс бүрэлдсэн байдаг учир ямагт ухаалаг шийдвэр гаргах боломжтой, харьцангуй тогтвортой төрийн байгууллагуудын тогтолцоог бүрэлдүүлнэ, ямагт нийгмийн тусгал болж байдаг.
- Хууль тогтоох эрх мэдлийг зөвхөн парламент хэрэгжүүлнэ. Гэтэл Ерөнхийлөгчийн засаглалтай зарим улс оронд парламентаас асуудлыг нь шийдэж өгөөгүй тохиолдолд өөрөө батлаад хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байдаг. /Франц/
- Ерөнхийлөгч төрийн тэргүүний үүргийг Засгийн газрын тэргүүний үүрэгтэй хавсран гүйцэтгэж байгаа үед Засгийн газар нь хямарч унах тохиолдол бүрт түүнээ дагаж унаж байдаг. Ингэснээр төрийн тэргүүн маань байнга муу хэлүүлж, баталгаа муутай, сонгогчдыг сонгуулиас залхаадаг.
- Парламент хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсийг хуулиар тогтоохоос бусад хэлбэрээр тэдгээрийн үйл ажиллагаанд оролцохгүй. Харин Ерөнхийлөгчийн удирдлагын хэлбэр бүхий улсад хууль тогтоох байгууллагаас үл хамаарсан байдалтайгаар бүрэн эрхээ хэрэгжүүлдэг. Энэ нь эцэстээ “засаглалын эрх мэдлийг хуваарилах” зарчмын тэнцлийг алдагдуулахад хүргэж, зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийг хэт өндөрсгөх талтай.
- Парламентын БНУ-ын хэлбэртэй үед төрийн тэргүүний болон засгийн газрын тэргүүний чиг үүрэг нарийн зааг ялгаатай байдаг бол Ерөнхийлөгчийн БНУ-ын үед энэхүү хоёр субъектийг чиг үүргийг ингэж нарийн зааглах боломжгүй байдаг. Ингэснээр удирдлагын төвлөрөл хэт ихсэх хандлага бий болохын зэрэгцээ эдийн засаг, зэвсэгт хүчний болон захиргааны эрх мэдэл бүхэлдээ төрийн тэргүүний мэдэлд шилжин төвлөрөх нөхцлийг бүрэлдүүлж, улс орон ард түмний хувь заяа зөвхөн ганц хүнээс хамаарах болж, хүчирхийлэл,

хэлмэгдүүлэлт ч гарч болзошгүй юм.

- Парламентын удирдлагын хэлбэрийн үед гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох, өөрчлөх, огцруулах эрхтэй байдаг. Харин Ерөнхийлөгчийн удирдлагын хэлбэр бүхий улсад Ерөнхийлөгч нь засгийн газрын гишүүдийг томилох, өөрчлөх эрх эдэлдэг учраас Засгийн газар хууль тогтоох байгууллагаас илүү Ерөнхийлөгчийн өмнө хариуцлага хүлээдэг зэрэг байжээ.¹

Миний бодлоор энэхүү үндэслэл, тайлбар нь зөвхөн парламентын удирдлагын хэлбэрийг зөвтгөхөд чиглэгдсэн байна. Ерөнхийлөгчийн Бүгд найрамдах улсын үед ч бас давуу талууд байдаг бөгөөд засаглалын эрх мэдлийг мөн л харилцан тэнцвэртэйгээр, нэг нь нөгөөгөө хянаж байх боломжтойгоор хуваарилах боломж бодитойгоор оршин байдаг учир дээр дурьдсан шиг удирдлагын төвлөрөл ихсэж, хүчирхийлэл газар авах гэх мэтийн сөрөг үзэгдэл гарах магадлал бас үгүй юм.

Ерөнхийлөгч нь басхүү бүх ард түмнээс ардчилсан, чөлөөт сонгуулийн үндсэн дээр сонгогддог тохиолдолд нийгмийн нийтлэг ашиг сонирхолыг төлөөлөх чадварыг бас эзэмшсэн байдаг. Түүнчлэн түүний дэргэд хууль тогтоох болон хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх эрх мэдэл бүхий байнгын ажиллагантай парламент бас ажиллаж байдаг.

Шилжлтийн зураас үед хүчтэй төрийн тэргүүнтэй байх тухай эртний сэтгэгчдийн үзэлд туссан байдаг бөгөөд ардчилсан тогтолцоонд бидний адил шилжиж байсан орнуудын ихэнх нь ерөнхийлөгчийн, эсвэл хүчтэй ерөнхийлөгчтэй парламентын БНУ-ын төрийн удирдлагын хэлбэрийг сонгон авч байсан. Ерөнхийлөгчийн удирдлагын хэлбэрийн үед улс төрийн шийдвэр гаргах процесс харьцангуй түргэсдэг бөгөөд энэ нь шилжлтийн үед тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, улс төрийн аллага хямралаас гарахад чухал үр нөлөөтэй байдаг.

Ерөнхийлөгчийн удирдлагын хэлбэрийн үед төрийн тэргүүний өмнө Засгийн газар хариуцлага хүлээж, харин Ерөнхийлөгч нь парламентын өмнө хариуцлага хүлээдэг тогтолцоо ч байдаг. Ерөнхийлөгч нь заавал Засгийн газар бүрийг дагаж огцроод байх шаардлага тэр бүр байдаггүй. Мөн Засгийн газар заавал парламентын өмнө хариуцлага хүлээж байх албагүй.

Миний бие энэ бүгдийн эцэст парламентын болон ерөнхийлөгчийн удирдлагын хэлбэрийн аль нэгийг нь зөвтгөхийг

оролдоогүй бөгөөд харин аль алинд нь байдаг давуу, ашигтай талуудыг олж харахыг хичээсэн юм.

Монгол улсын хувьд тухайн үеийн түүхэн нөхцөл байдалд ямар нэгэн диктатор гарч ирж болзошгүй, ардчилсан ололтоо бататган бэхжүүлэх боломжоо алдаж болзошгүй зэрэг сөрөг хүчин зүйлүүдээс болгоомжилсон байж болох юм. Гэвч бид өнөөдөр улс төрийн хариуцлагыг хэнд хүлээлгэхээ мэдэхгүй, зөвхөн өөрөө тардаг супер парламентынхаа бүрэн эрхийн хугацаа дуусаж, дараагийн сонгууль болохыг хүлээж цаг алдсаар, улс төрийн гүнзгий хямралд автагдсаар байна шүү дээ.

Бид энэхүү шилжилтийн үед нилээд эрх мэдэл бүхий парламенттай Ерөнхийлөгчийн БНУ-ын хэлбэрийг сонгож авсан бол шинэчлэл харьцангуй түргэн хийгдэж, баруун Европын шинээр ардчилсан орнууд шиг амжилтанд хүрэх боломж байсан болов уу. Манай орны төрт ёсны хөгжил, түүхэн уламжлал, тухайн үед бүхэл бүтэн тогтолцоогоороо өөрчлөгдөх шилжилтийн үед тулж ирээд байсан, манай улстай адил шилжилтийн үед явж байсан болон ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоо амжилттай хөгжсөн Ази, Европын олон орны туршлага, түүхэн сургамж, сэтгэгчдийн онолын ухаалаг үндэслэл зэргийг харгалзан үзэж төрийн удирдлагын хэлбэрээ сонгож авах хэрэгтэй байсан. Энэхүү шилжилтийн үеийг харьцангуй шийдвэртэй, түргэн даваж гарсны дараа тайван, уян хатан улс төрийн бодлого явуулах парламентын тогтолцоонд шилжих боломж байсан гэж үзэж байна.

Ер нь дэргэдээ хяналтын чиг үүрэг бүхий парламенттай, улс төрийн олон намын тогтолцоотой, ард түмнээс чөлөөт, ардчилсан сонгуулийн зарчмаар хатуу тогтоосон хугацаагаар сонгогддог, эргээд ард түмний өмнө хариуцлага хүлээдэг, шаардлагатай бол парламентын өмнө ч хариуцлага хүлээж болохоор, эрх мэдэл нь хуваарилагдсан, эрх зүйт, ардчилсан төрийн үе дэх хүчтэй ерөнхийлөгчөөс айх шаардлага бидэнд үгүй билээ.

Одоо бид засаглалын болон улс төрийн тулгамдсан хямралаасаа гарихын тулд Үндсэн хуулиндгаа өөрчлөлт оруулж, төрийн тэргүүний эрх мэдлийг парламентын удирдлагын хэлбэртэй үеийн хүчтэй ерөнхийлөгчийн хэмжээнд тодорхойлон хуульчлах шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Өнөөгийн нийгмийн сэтгэл зүйн голлох хандлага ч энэхүү хямралт байдлаас болоод хэн нэг хүчтэй ерөнхийлөгчийг хүсэх биш харин ч бүр диктаторыг хүсэх байдлаар илэрч байна. Зарим судлаачид үүнийг хуучнаа санагалзаж байгаа "солжирол"-оор нөхцөлдсөн сэтгэл зүй гэж тайлбарлаж байгаатай бүрэн санал

нийлэх боломжгүй юм.

Ерөнхийлөгчийг хүчтэй болгохын тулд Засгийн газрын гишүүдийг томилдог, чөлөөлдөг бүрэн эрх болон хуульд заагдсан тодорхой тохиолдлуудад парламентыг тараах эрхийг тус тус олгох шаардлагатай гэж үзэж байна.

Ерөнхийлөгчий сонгуулийн процессод анхаарууштай, онолын хувьд зөрчилтэй зүйлүүд байна гэж үздэг.

Үндсэн хуульд зааснаар Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь бүх ард түмний, парламентын гэсэн хоёр үе шаттай явагддаг билээ. Ийнхүү ерөнхийлөгчийг сонгож байгаа нь ерөнхийлөгчийн болон парламентын удирдлагын хэлбэртэй төрүүдийн аль алиных нь шинжийг агуулж байгаа юм. Гэтэл энд ард түмнээс сонгогдоод ирсэн ерөнхийлөгчийг УИХ-аас бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахгүй бол яах вэ гэсэн асуудал гарна. Ард түмний бүрэн эрхийг илүүтэй гэж үзэх үү, эсвэл ард түмнийг төлөөлж байгаа гэдэг утгаар нь УИХ-ын бүрэн эрхийг илүүтэй гэж үзэх үү? Нөгөө талаас төрийн тэргүүнээр сонгогдож байгаа хүнд төрийн тэргүүн болоход нь харшлах зүйл байгаа эсэхийг тодорхой түвшинд нарийн шалгаж тогтоох боломжийг олгож байгаа болон бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль "гаргана" гэсэн учир УИХ-д үүрэг болгосон агуулгатай заалт гэж үзвэл тэр бүр буруутгах боломж бас хомс юм. Гэтэл бас УИХ-д үүрэг хүлээлгэсэн шинжтэй заалт юм бол УИХ-аас үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай асуудал бас зохицуулалтгүй орхигдсон байна. Хариуцлагагүй үүрэг бол үүрэг биш юм.

Энэ нь улс төрийн тодорхой нөхцөл байдал, хүчний харьцаа зэргээс шалтгаалаад УИХ-аас хууль гаргана гэдгийг янз бүрээр тайлбарлах, түүнчлэн бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргаагүй тохиолдолд сонгууль олон дахин явуулах болж, ард түмнийг сонгуулиас залхах нөхцөл байдал ч үүсэж болзошгүй юм. Иймээс хүчтэй ерөнхийлөгч бүхий парламентын БНУ-ын нийтлэг жишгийг баримтлан Ерөнхийлөгчийг УИХ-ын гишүүд, аймаг бүрээс сонгогдсон тодорхой тооны төлөөлөгчдөөс бүрдсэн сонгогчдоос сонгож байвал зүйтэй болов уу.

Түүнчлэн энэ тогтолцоогоо хэвээр хадгалж үлдсэн тохиолдолд тухайн нэр дэвшигч Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд харшлах зүйл байгаа эсэхийг нэр дэвшүүлэх шатанд нарийн тогтоож, нэр дэвших эрхийг олгодог механизмыг бүрдүүлэх нь

ард түмний хийсэн сонголтыг үр дүнгүй болгохоос урьдчилан сэргийлэх, ард түмний бүрэн эрхийг бодитой хэрэгжүүлэхэд илүү нийцэнэ гэж бодож байна.

Монгол улсын төрийн тэргүүний үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, бүрэн эрхийн хүрээг судлаж үзэхэд бүрхэгдмэл, салаа утгатай зүйлүүд нилээд байдаг бололтой.

Тухайлбал, Ерөнхийлөгч нь Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох эрхтэй, “УИХ-д олонхийн суудал авсан намтай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол УИХ-д суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг ерөнхий сайлаар томилох саналыг УИХ-д оруулах” гэсэн ерөнхийлөгчийн бүрэн эрхийн тухай Үндсэн хуулийн заалтуудын “зөвшилцөх” гэдэг үгийг янз бүрээр тайлбарлан маргалдаж, энэ маргааны явцад Ерөнхийлөгч зарим элчин сайдыг томилохдоо Улсын Их Хурлын байр суурийг харгалзалгүй томилсон тохиолдол гарч, 1996 оны сонгуулиар УИХ-д олонхийн суудал авсан “Ардчилсан холбоо эвсэл”-ийн парламент дахь бүлэг өөрсдийн эрх ашигт нийцсэн албан ёсны тайлбарыг хүртэл УИХ-аар батлуулж байсан билээ. Энэ үед харин Үндсэн хуулийн цэц төрийн эрх мэдлийн хүрээнд дэх “тэнцвэржүүлэгч”-ийнхээ үүргийг сайн биелүүлж, асуудлыг хууль зүйн дагуу нэг мөр болгон шийдвэрлэсэн билээ.

Үүний нэгэн адил жишээ болох “Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцана” гэсэн Үндсэн хуулийн заалт нь энэ хоёр субъектын харилцааны нэг гол механизм мөн. Гэтэл үүнийг улс төрчид, хуульчид мөн л янз бүрээр ойлгож, ажил хариуцах практик бас л тодорхойгүй байдлаар үргэлжилсээр байна.

Энэ мэтчилэн УИХ-ын шийдвэрт ерөнхийлөгчийн тавьсан хориг, түүнийг Үндсэн хуулийн цэцээр хэлэлцсэн дүгнэлтийг УИХ-аар хэлэлцэх, Ерөнхийлөгчөөс УИХ-д оруулсан санал, Засгийн газарт өгсөн чиглэл, ҮАБЗөвлөлөөс гаргасан зөвлөмж зэрэг засаглалын дээд шатны үйл ажиллагааны функциональ харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад эдгээрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, эргэж тайлагнах зарчим зэргийг нэгдмэл тогтолцоонд оруулахад чиглэсэн төрийн цогцолбор үйл ажиллагаа дутмаг байгаагаас болж хариуцлага, хяналтын механизм суларч, эзэнгүйдэл газар авч буйг анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн УИХ-аас баталсан хуулиудаар ерөнхийлөгчид олгогдсон бүрэн эрхүүд нь гүйцэтгэх эрх мэдлийн чиглэлээр нилээд

өргөжсөн байгаа бөгөөд энэ нь Засгийн газрын хариуцлагыг судруулах, түүнийг ерөнхийлөгчийн ам харах, болгоомжлох байдалд хүргэж болзошгүй байдал үүсээд байна.⁴

Үндсэн хуулинд Ерөнхийлөгч нь үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, ажлын алба байгуулж болно гэж хуульчилсан боловч өнөөдрийг хүртэл ийм алба байгуулагдаагүй байгаа нь ерөнхийлөгчийн хязгаарлагдмал эрх зүйн байдалтай нь холбоотой гэж үзэж байна.

Цаашид төрийн тэргүүний эрх зүйн байдал, үйл ажиллагааных нь эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлд хийвэл зохих алхмууд амьдралаас урган гарч ирсээр байна.

Үндсэн хууль хэдийгээр тогтвортой үйлчлэх ёстой, хичэээн боловсронгуй байлаа ч гэсэн цагийн аясаар, амьдралын шаардлагаар өөрчлөгдөж байх ёстой. 1787 онд батлагдсан дэлхийн анхны Үндсэн хууль болох АНУ-ын Үндсэн хуульд 1791 онд буюу ердөө таван жилийн дараа гэхэд “Эрхийн тухай билл” гэдэг нэрээр түүхэнд орсон 10 нэмэлт өөрчлөлтийг оруулж байсныг энд дурдах нь зүйтэй болов уу.

Өнөөгийн манай Ерөнхийлөгч парламентын БНУ-ын үеийн төрийн тэргүүний билэг тэмдгийн шинжтэй бүрэн эрхээс илүү бодитой бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй байгаа нь төрийн эрх мэдлийг хуваарилах хүрээнд “тэнцвэржүүлэгч”-ийнхээ үүргийг бодитой хэрэгжүүлж чадахгүйд байдалд хүргээд зогсохгүй, харин ч өнөөдөр тулгараад байгаа улс төрийн хямралыг даамсруулах нөхцөл болон хувираад байна. Энэ нь ямар нэг хувийн субъектив санаа зоригоос шалтгаалсан хэрэг биш манай тогтолцооны учир дутагдалтай байдалтай холбоотой байна гэсэн дүгнэлтэд хүргэж байгаа юм.

Иймээс дээрх засаглалын хүрээнд дэх хямралт байдлыг даван туулах, тогтолцоогоо эрүүлжүүлэхийн тулд төрийн тэргүүнийхээ бүрэн эрх, засаглалын эрх мэдлийн хүрээнд эзлэх байр суурийг нь өргөсгөж, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй байгууллагуудад тодорхой бодитой нөлөөлөл үзүүлэх боломж нөхцлийг нь хангаж өгөх нь зүйтэй бөгөөд өнөөгийн Монгол улсад хүчтэй ерөнхийлөгч бүхий Парламентын БНУ-ын төрийн удирдлагын хэлбэр зохимжтой байгаа юм.

Ерөөс төрийн байгууллагуудын тогтолцоог эрүүлжүүлэх, үр дүнтэй, харилцан тэнцвэртэй, тогтвортой ажиллуулах нь зөвхөн төрийн тэргүүний эрх зүйн байдлыг боловсронгуй болгосноор шийдэгдэх асуудал биш бөгөөд бусад тогтолцоо бүрдүүлэгч

субъектуудын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зорилт, чиг үүргийг нь оновчтой хууваарилах, үйл ажиллагааны хүрээг зөв тодорхойлох гэх мэт нийгмийн амьдралын бүх хүрээнд хэрэгжүүлэх цогцолбор арга хэмжээ шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Эцэст нь хэлэхэд миний дэвшүүлсэн санаануудаас гадна Монгол улсын төрийн тэргүүний эрх зүйн байдал болон үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар хөндөгдөөгүй орхигдсон, цаашид улам боловсронгуй болгох асуудлууд амьдралаас урган гарсаар байхыг үгүйсгэхгүй байна.

© 1999 он.

¹ БНМАУ-ын АИХ. ХН-375. "БНМАУ-ын Их цэвэр /Үндсэн хуулийн/-ын хувилбарууд болон засагдаж шинэчлэгдсэн төслүүд, танилцуулаг" I, II боть. УИХ-ын архив. 1991.Ү.20.

² БНМАУ-ын АИХ. ХН-375. "БНМАУ-ын Их цэвэр /Үндсэн хуулийн/-ын хувилбарууд болон засагдаж шинэчлэгдсэн төслүүд, танилцуулаг" I, II боть. УИХ-ын архив. 1991.Ү.20.

³ Монгол Улсын Үндсэн хууль. 1992.

⁴ Д.Батмөнх, Г.Чулуунбаатар. Төрийн байгууллагын тогтолцоо, түүний өндөрлөг дэх эздрээтэй асуудлууд. ЗГМ. 1997. № 230,232.

**“МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ,
ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ”
СЭДЭВТ МАГИСТРЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН БҮТЭЭЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Удирдсан: Хууль зүйн ухааны доктор /Ph/, профессор Л.Баасан.

Шүүмж бичсэн: Хууль зүйн ухааны доктор /Ph/, профессор
Д.Лүндээжанцан.

Гүйцэтгэсэн: УИХ-ын Тамгын газрын референт, хууль зүйн
ухааны магистр Лувсандоржийн Мөнхжаргал.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4, 17 дугаар зүйлийн 2-т Монгол улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй. Хөдөлмөрлөх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэж заасан. Эдгээр заалт нь иргэд ямар нэг албадлага, шахалтгүйгээр, сайн дураараа чөлөөтэйгээр хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулан хангахад чиглэгдсэн юм.

Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн эдийн засагт шилжих болсноос хойш улс орны эдийн засгийн хямрал хамгийн түрүүнд хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдалд хүндээр нөлөөлж, олон жилийн турш бүрэн хэмжээний хөдөлмөр эрхлэлттэй байсан манай орны ажиллах хүчний бүрэлдэхүүнд агуулгын гүн гүнзгий өөрчлөлт оруулж, ажилгүйчүүдийн тоог асар богино хугацаанд их хэмжээгээр нэмэгдүүлсэн юм.¹

Ажилгүйдэл, ядуурлын өсөлтийг зогсоох, улмаар бууруулах асуудал өнөө үед нэн хурцаар тавигдаж байгаа учраас хүн амын хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих, ажилгүйдлийг бууруулах зэрэгт эрх зүйн орчин бүрдүүлэх, нэгэнт тогтоосон эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг их бүрэн зохицуулсан багц хууль одоогоор Монгол улсад хараахан байхгүй байгаа тул уг асуудлыг Монгол улсын Хөдөлмөрийн хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн тухай болон прокурорын байгууллагын тухай хууль зэрэг хууль, түүний дагуу Засгийн газар, эрх бүхий бусад байгууллагаас гаргасан эрх зүйн актуудаар зохицуулж байна. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тус улсад байхгүй бөгөөд /Засгийн газрын 1998-6-5-ны одрийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зарим арга хэмжээний тухай 87 тоот тогтоолыг эс тооцвол/ дээрхи төрийн бодлого, хуулийг яаралтай батлан гаргах шаардлагатай байна. Эдгээрээс шууд хамааран хүн амын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг

тусгайлан судлах эрэлт хэрэгцээ аяндаа тавигдах болсон юм.

Хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг эрх зүйн үүднээс зохицуулах, түүний нийгмийн шинжийн тухай асуудлыг Монгол Улсын хуульчид, судлаачид бараг хөндөж байсангүй гэхэд хэлсдэггүй болов уу. Харин хууль зүйн ухааны дэд доктор, дэд профессор Л.Баасан "Монгол улсын Хөдөлмөрийн эрх зүй" /тусгай анги/ сурах бичигтээ иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр зохион байгуулалтын асуудлийг нэг бүлэг болгон авч үзсэний дээр хөдөлмөр эрхлэлтийн тухай ойлголт, хэлбэрүүд, ажилгүйдлийн эрх зүйн байдал, Монгол улс дахь хөдөлмөр эрхлэлтийн алба, тэдгээрийн эрх үүрэг, ажилгүйдлийн тэтгэмж зэрэг асуудлийг товч авч үзжээ.² ОХУ-ын эрдэмтэн А.С Пашков "ОХУ-ын Хөдөлмөрийн эрх зүй" сурах бичигтээ Хөдөлмөр эрхлэлт болоод хөдөлмөр зохион байгуулалтын талаар авч үзсэн байна.³ Түүнчлэн ОХУ-ын эрдэмтэн В.Н Толкунова К.Н Гусов нар "ОХУ-ын Хөдөлмөрийн эрх зүй" сурах бичгийнхээ тусгай ангид хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөр зохион байгуулалт тэдгээрийн баталгааны талаар онолын тайлбар, үндэслэлүүдийг гаргажээ.

Эл ажил нь оршлын болон дүгнэлтийн хэсэг, 2 бүлэг, 5 зүйл, ном зүйгээс бүрэлдэж байна. Судалгаанд өөрийн орны болон гадаадын эрдэмтэн судлаачдын 30 гаруй судалгааны ном зохиол, эх сурвалжуудыг ашигласан юм. "Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн асуудал" гэсэн нэгдүгээр бүлэгт хөдөлмөр эрхлэлтийн тухай ойлголт, түүний төрөл, хэлбэр, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжоор зохицуулж ирсэн тухай түүхэн уламжлалын асуудал, хөдөлмөр эрхлэлтийн талаарх олон улсын конвенциудын талаар авч үзсэн. "Ажилгүйдлийн эрх зүйн зохицуулалтын онөөгийн байдал" гэсэн хоёрдугаар бүлэгт ажилгүйдлийн тухай ойлголт, энэ талаарх монгол орны эрх зүйн зохицуулалт, бусад орны практик, ажилгүй байх үеийн нийгмийн баталгаа ба ажилгүйдлийн тэтгэмжийн тухай асуудлуудыг хамааруулан судлаж, өөрийн санал дүгнэлтийг гаргасан юм.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг өргөн ба явцуу хүрээгээр тодорхойлж болно. Өргөн утгаараа хөдөлмөр эрхлэлтийн тухай ойлголтыг ажилтай байх, хийх зүйлтэй байх явдал гэж *түгээрүлэйдэ бйрү*.⁴ Өөрөөр хэлбэл нийтлэг утгаараа хөдөлмөр эрхлэлт гэж хөрс орлоготой эсэхээс үл хамаарч зорилготой, үр ашигтай хөдөлмөрийн бүтээлч үйл ажиллагаа гэж болно. Энэ үйл ажиллагаанд иргэд хөдөлмөрийн гэрээ болон иргэний эрх зүйн гэрээний дагуу хөдөлмөрлөх, цэргийн алба хаах, их, дээд, дунд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцах, хувиараа эрхлэх аж ахуй хөтлөх, бусдын аж ахуйд тэдний төлөө хөдөлмөрийн хөдлөлтэй

болон хөлсгүйгээр хүчин зүтгэх, үр хүүхдээ асарч хүмүүжүүлэх, өрх гэрийн аж ахуй хөтлөх зэрэг үйл ажиллагаануудыг багтааж болох юм. Хөдөлмөр эрхлэлтийн тухай дээрх ойлголт нь хувь хүн хөдөлмөрийн хөлс, орлого авч байгаа эсэхийг харгалздаггүйгээрээ онцлогтой юм. Харин нийгмийн болон хувь хүний зохистой үйл ажиллагаа, сонирхлоос ихсэхэн хамааралтай байдаг байна. Жишээ нь, эх хүн насанд хүрээгүй хүүхдээ асрамжлан өрх гэрийн аж ахуйг хөтлөн явуулах хөдөлмөрийн хөлс орлогогүй боловч нийгэмд үр ашгтай үйл ажиллагаа буюу хөдөлмөр эрхлэн гүйцэтгэж байгаа явдал мөн.⁵

Явцуу утгаараа хөдөлмөр эрхлэлт нь иргэд хөдөлмөрийн болон иргэний гэрээ, бусад үндэслэлээр байнгын орлоготой хөдөлмөр эрхэлж байгаа үйл ажиллагаа юм.

Хөдөлмөр эрхлэлтийн тухай явцуу ойлголт бол тодорхой хэсэг хүмүүс, тухайлбал, цалин орлоготой хүмүүсийг хамарсан байдгаараа онцлогтой.

Хөдөлмөр эрхлэлтийн тухай энэхүү явцуу ойлголтыг ямар хүрээнд авч үзэх вэ? гэдгээс шалтгаалан Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, ажилгүйдлийн тэтгэмж олгох зэрэг хөдөлмөр зохицуулалтын үндсэн асуудал зохицуулагдана. Иймд хөдөлмөр эрхлэлтийн тухай ойлголтыг өргөн ба явцуу хүрээний аль алинаар нь авч үзүүштэй байна. Жишээ нь, боловсрол эзэмших, өрх гэрийн аж ахуйг дэмжих бодлогын үүднээс аж ахуй эрхлэлтийн тухай өргөн ойлголтыг баримтлах нь зайлшгүй. Түүнчлэн энэ хүрээнд иргэн аж ахуйн нэгж байгуулахгүйгээр хөдөлмөр эрхлэх асуудлийг ч авч үзэх хэрэгтэй болно.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлуудын нэг нь ажилгүй хүн, ажилгүйдэлд өртөгдөж болзошгүй хүний тухай асуудал юм. Ажилгүй хүн гэдгийг Олон улсын стандарт аргачлалын дагуу авч үзвэл хөдөлмөр эрхлэх боломжтой, ажил идэвхтэй хайж буй, хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн, хөдөлмөрийн чадвартай иргэнийг ажилгүй хүн гэж үзэж болох ба эл агуулгаар ажилгүй хүний тухай асуудлийг хуульчлах шаардлагатай байна. Өнөө үед судалгаа шинжилгээний хүрээнд тэр бүр тусгагдаагүй, тэр бүү хэл хуульд байхгүй нэгэн асуудал бол ажилгүйдэлд өртөгдөж болзошгүй хүний тухай асуудал бөгөөд эл асуудал Япон, Польш зэрэг улсын хуульд өргөнөөр тусгагджээ. Ажилгүйдэлд өртөж болзошгүй хүн гэдгийг хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай мэдэгдэл авсан, хөдөлмөрийн чадвараа алдсан буюу орон тооны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт зэрэг шалтгаанаар ажилгүй болж болох магадлалтай байгаа хүмүүсийг оруулах нь зүйтэй гэсэн үзэл бодлыг бид дэмшүүлж байна. Энэ нь нийслэл Улаанбаатар хот, төв

суурин бусад газарт асар их тохиолддог асуудал болно. Эдгээрийг хуульчилсан зохицуулалт тус улсад одоогоор байхгүйг цохон тэмдэглэх нь чухал.

Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын зөвлөмж, зарим улс орны туршлагаас үзэхэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь ажилд зуучлах, ажил мэргэжлийн талаар зөвлөгөө өгөх, мэргэжлийн чиг баримжаа олгох, сургалт зохион байгуулах, хувиараа хөдөлмөр эрхлэхийг дэмжих, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, гадаадад ажиллах хүч гаргах/экспортлох/ зэрэг талаар дамжин хэрэгжиж байна. Үүнд:

-Ажилд зуучлах: Энэ нь хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн байгууллага, албад хөдөлмөр эрхлэхийг хүссэн ажилгүй хүнийг бүртгэж, ажилд зуучилж оруулах буюу ажил олгогчид захиалгын дагуу ажиллах хүчийг нийлүүлэх үндсэн зорилтыг хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд хөдөлмөр зохицуулалтын албад бүртгэлтэй ажилгүйчүүдийн 60 орчим хувь нь мэргэжилгүй, 70 хувь нь 35 хүртэлх насны залуучууд, 4,7 хувь нь ажилгүйдлийн тэтгэмж авдаг бөгөөд нийт бүртгэгдсэн ажилгүй 3 хүн тутмын зөвхөн нэг нь л жилийн хугацаанд ажилд зуучлагдаж байна.

Ажилд зуучлах үйлчилгээ нь хөдөлмөр эрхлэлтийн албадын гол чиг үүрэг юм. Хөдөлмөр эрхлэлтийн албад ер нь хүнийг шууд ажилд оруулагдгүй. Сул чөлөөтэй ажлын байр ба түүнд тохирч болох хүний хооронд зуучлах нь уг хүнийг яг ажилд оруулж байгаа явдал биш билээ. Харин хөдөлмөр эрхлэлтийн албад нь ажил олгогч эцсийн сонголтдоо хийж ажилд элсүүлэн авахад тохирох хүмүүсийн жагсаалтыг гаргадаг. Ер нь хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай ажил хайгчид болон олдоц сайтай мэргэжлийн хүмүүсийг хайж байгаа ажил олгогчдын хувьд зуучлах үйлчилгээ хийгддэг байна.

Ажилд орох буюу ажлаа өөрчлөхийг хүсч буй ажил хайгч болгон бүртгүүлэхийг сонирхдоггүй боловч тэд бүгд ажлын байрны тухай мэдээлэл авах эрмэлзэлтэй байдаг. Хөдөлмөрийн зах зээлийг "захиргаадалтын"⁶ аргаар зохион байгуулдаг зарчмын дагуу хөдөлмөр эрхлэлтийн албадын ажилтнаас "байцаалт"⁷ маягаар явуулдаг ярилцлага ч үр дүн багатай болж буй гэхэд хилсдэхгүй юм. Харин "АЖИЛД ЗУУЧЛАХ НЭЭЛТТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ"-г⁸ /үүнийг барууны орнуудад өөрөө өөртөө үйлчилдэг дэлгүүртэй адилтгах явдал ч байдаг/ илүү түлхүү нэвтрүүлэх нь чухал юм. Дээрх нээлттэй үйлчилгээ гэдгийг тайлбарлавал: Хөдөлмөр эрхлэлтийн албад мэдээлсэн сул чөлөөтэй ажлын байрны тухай мэдээллийг харагдахуйц газар байрлуулна. Ажил хайгчид энэ

мэдээллийг чөлөөтэй авч уг ажилд орох тухай хүсэлт гаргах эсэхээ бие даан буюу өөрөөр хэлбэл, хөдөлмөр эрхлэлтийн албадын ажилтны тусламжгүйгээр шийдэх боломжтой байдаг байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн албаны ажилтан нь сул чөлөөтэй ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолтыг гаргаж аль нэгэн ажилд хүн ажиллуулсан тухай мэдээ ирмэгц уг ажлын байрны тухай зарлааыг самбараас нэн даруй хасч байх л үүрэг гүйцэтгэдэг. Нийслэлийн хөдөлмөр зуучлалын албанд дэмжлэг, зуучлалын үйл ажиллагаа ажиглагдаагүй болохыг энд тэмдэглэх хэрэгтэй.

Үүнээс гадна хөдөлмөр эрхлэлтийн зарим албад нь сул чөлөөтэй ажлын байрыг ажил олгогчдын хаяггүйгээр мэдээллийн самбарт хадаж **“ХАГАС НЭЭЛТТЭЙ”**⁹ үйлчилгээ явуулдаг. Ил хадсан сул чөлөөтэй ажлын байрыг сонирхсон хүмүүс ажилд зуучлах ажилтантай уулзана. Ингэснээр хөдөлмөр эрхлэлтийн албанаас уг хүний мэргэжлийн чадварыг цаашид шалгах боломжийг олгодог. Монгол Улсад энэхүү зуучлал өргөн хэрэглэгдэх болжээ. 1998 оны 9 дүгээр сарын байдлаар ажил олгогчоос хөдөлмөр зохицуулалтын албанд 2595 сул чөлөөтэй ажлын байрны тухай захиалга иржээ.¹⁰ Мөн хугацаанд 1324 ажилгүй хүн бүртгүүлснээс нийт 1742-д нь зуучлан, сул ажлын байрны захиалгын 67,1 хувийг ашиглаж, үлдэгдэл нь сарын эцэст 878 байв.

-Ажил мэргэжлийн талаар зөвлөгөө өгөх, чиг баримжаа алгах: Энэ арга хэмжээний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албад нь хөдөлмөрийн зах зээл, хүн хүчний нөөц, хөдөлмөрийн харилцаа, ажил мэргэжлийн талаар иргэдэд болон ажилгүй хүн, ажил олгогч /эзэд/ зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх арга барил эзэмшүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн албад нь жижиг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хувьд ажлын байрны тодорхойлолт гаргахад нь туслах, хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөгөө өгөх, ажиллах хүчнийхээ талаар статистик мэдээ гаргахад нь туслалцаа үзүүлэх зэрэг зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх талаар анхаарч ажилладаг байна.

-Богино болоод урт хугацааны мэргэжлийн болон давшан сургалт зохион байгуулах: Цэвэр зуучлах үйлчилгээний зэрэгцээ хөдөлмөр эрхлэлтийн албад нь одоо байгаа болон бий болж болох сул чөлөөтэй ажлын байрны хооронд орших “мэргэжлийн цоорхой”¹¹ ба мэргэшсэн ажиллах хүчний нийлүүлэлтэнд үнэлгээ өгч, энэ цоорхойг нөхөхөд чиглэгдсэн арга хэмжээ авч явуулах нь нэн чухал юм. Энэ нь ерөнхий боловсролын сургууль төгссөн, мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлтэй залуучууд, хүн амын эмзэг хэсэгт хамрагдах мэргэжилгүй, мэргэжлийн ур чадвар муутай

ажилгүй хүн, эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах ажлын байргүйгээс мэргэжлээ өөрчлөх шаардлагатай болсон ажилгүй хүн зэрэгт хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн алба нь мэргэжлийн сургалт зохион байгуулах, эрх бүхий байгууллага иргэдтэй хамтран богино болоод урт хугацааны мэргэжлийн болон давтан сургалтад хамруулж тэдэнд ажил олох боломжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, аж ахуй эрхлэх чадвар эзэмшихэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ тухай Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 87 тоот тогтоолд хөдөлмөр эрхлээгүй хүмүүст зориулан богино хугацааны сургалтыг мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв болон хөдөлмөр зохицуулалтын албаны хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр зохион байгуулж байх тухай заажээ.

Мэргэжлийн сургалтын тогтолцоо улс орон бүрт өөр өөр байдаг боловч ихэнх орнууд ажлын байран дээрх практик сургалт ба онолын сургалтыг хослуулсан тогтолцоотой байдаг. Ихэнх улсуудад хөдөлмөр эрхлэлтийн албад нь өөрөө биечлэн хүмүүсийг сургадаггүй бөгөөд харин мэргэжил олгох болон сургалтын байгууллага ба үйлдвэр, аж ахуйн газруудыг хооронд нь холбох үүргийг гүйцэтгэдэг байна.

Мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлыг харгалзан зохион байгуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, мэргэжилгүй ажилчдын эрэлт буурч мэргэжилтэй боловсон хүчний эрэлт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Тиймээс маргаашийн ажилчдад өнөөдөр боловсрол олгож, мэргэшүүлэх нь зайлшгүй хэрэгтэй юм. Маргаашийн төлөөх сургалтыг өнөөдөр эхлэх нь хүн хүчний ноогийг урьдчилан харж, төлөвлөхөд чухал нөхцөлд тооцогддог байна. Судалгаанаас үзэхэд сард дунджаар 253 ажилгүйчүүд мэргэжлийн сургалтад шинээр хамрагдсанаас нийгмийн даатгалын байгууллагаас шилжүүлсэн ажилгүйдлийн сангийн хөрөнгөөр 215 хүн суралцаж, тэдэнд 3634.0 мянган төгрөг зарцуулжээ. Нийт ажилгүйчүүдийн 32837 хүн буюу 60,7 хувь нь мэргэжилгүй байгаа өнөө үед тэдэнд зориулсан мэргэжлийн сургалт өргөнөөр зохион байгуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

-Нийтийг хамарсан ажил: Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хамгааллыг дэмжих, дэд бүтцийг сайжруулахад чиглэгдсэн хөдөлмөр зарцуулалт ихтэй, мэргэжил, мэргэжлийн урьдчилсан бэлтгэл шаардахгүй, нийтээр ажиллах боломжтой хөдөлмөрийн үйл ажиллагаанд ажилгүй болон хөдөлмөр эрхлээгүй иргэдийг зохион байгуулалттайгаар оролцуулан ажиллуулахыг нийтийг хамарсан ажил гэх¹² бөгөөд энэ нь нийгмийн эрх ашиг сонирхолд нийцсэн байдаг.

Жишээ нь түр хугацааны болон улирлын чанартай ажил гүйцэтгүүлэх замаар улс, орон нутгийн болон тухайн байгууллагын хэрэгцээг хангах удаан хугацаагаар ажилгүй байгаа болон мэргэжилгүй буюу ажлын дадлага, туршлага багатай иргэдийн хөдөлмөрлөх идэвхийг өрнүүлэх зэрэг хэлбэртэй байна.

Ажлын байрыг ийнхүү “зориудаар” бий болгох нь ажилгүйдлийг бууруулахад төдий л нөлөөлөхгүй хэдий ч энэхүү нийтийг хамарсан ажил нь хөдөлмөрийн чөлөөт зах зээл дээр өрсөлдөх, нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн хувьд явуулах төрийн бодлогын чухал хэсэг юм. Зөв зохион байгуулж төлөвлөсөн тохиолдолд энэ арга хэмжээ нь хөдөлмөр эрхлэлтийн болон хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай хэрэгсэл болдог байна. Гэсэн хэдий ч тухайн орны эдийн засаг болон бусад онцлог байдлаас шалтгаалан тодорхой хязгаартайгаар хэрэглэдэг байна. Тухайлбал 1980-аад оны сүүлээр Герман улсад 2,3 сая гаруй ажилгүйчүүдээс 100000 орчим хүнд зориулан “зориудаар ажлын байр бий болгохыг дээд хязгаар” гэж тооцож байжээ.¹³

-Ажиллах хүч гадаадад гаргах. Хүн амын хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө оруулалтын бүтцийн бодлоготой уялдуулан ажиллах хүч гадаадад гаргах нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм. Харин гадаадад ажиллах хүч гаргахад иргэдийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал, цалин, хөдөлмөрийн хөлс, ажил амралтын цаг зэргийг уг орны хууль тогтоомжид заасан хэмжээнээс бууруулахгүй байх бодлого баримтлах бөгөөд энэ нь ажиллах хүч гаргах тухай хоёр улсын хоорондох гэрээ хэлцлүүдээр тодорхойлогддог. Жишээ нь: 1998 оны эхний 9 сарын байдлаар гадаадын улс орнуудаас Монгол Улсад 39 орны 1380 хүн хөдөлмөрийн гэрээгээр ажиллах зөвшөөрөл олгосон бөгөөд мөн хугацаанд хөдөлмөрийн гэрээний дагуу БНСУ-д 173 монгол иргэн ажиллаж байна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг тус улсад 1925 оноос эхлэн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж иржээ.

1925 оны алнаа хүчин үнэлэгчийн дүрмээс эхлээд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн хууль нь тус улс дахь хөдөлмөр эрхлэх харилцааг нэгдмэлээр зохицуулж байна. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнтэй холбоотойгоор иргэд хөдөлмөрийн гэрээний дагуу ажил үүрэг гүйцэтгэхээс гадна иргэний гэрээ болон бусад үндэслэлээр хөдөлмөрлөх явдал түгээмэл болсон байна. Үүнтэй холбоотойгоор иргэдийн хөдөлмөрлөх үйл ажиллагааг иргэний хуульд зааснаар ч зохицуулах болов. Өөрөөр хэлбэл, тус улсад хөдөлмөрийн болон Иргэний хуулиар иргэдийн

хөдөлмөрлөх үйл ажиллагааг зохицуулж байна. Харин гадаадын зарим оронд тухайлбал, Японд хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг Хөдөлмөрийн хууль, Ажилд авах тухай хууль, Боловсон хүчний чадварыг дээшлүүлэхийг дэмжих тухай хууль, Тодорхой цагаар ажилчин хөдөлмөр тухай хууль зэрэг багц хуулиудаар зохицуулдаг бол ОХУ-д Хөдөлмөрийн хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиудаар уг харилцааг зохицуулдаг байна.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг зохицуулсан нэгдмэл хуультай болох шаардлагатай байна.

Энэ хуульд:

1/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний төрөл, хамрах хүрээ, үйлчлэх субъект;

2/Ажилгүй хүн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй хүн гэдэгт ямар хүнийг хамааруулах вэ? гэдэг асуудал;

3/Хөдөлмөр эрхлэлтийн албадын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг;

4/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр түүнийг хэрхэн яаж зарцуулах тухай асуудал;

5/Ажилгүйдлийн тэтгэмж олгох үндэслэл, хүрээ, хязгаар, хэмжээ гэх мэт үндсэн асуудлуудыг багтаан зохицуулах нь зүйтэй байна.

Монгол улс Хөдөлмөрийн харилцааны салбар дахь олон улсын хөдөлмөрийн конвенц, зөвлөмжүүдийг хүлээн зөвшөөрч, түүнийг улс орондоо дагаж мөрдөх шаардлагатай байна. Энэ талаарх эхлэлүүдийг дэмжих нь зүйтэй санагдана. Бидний саналаар Хөдөлмөр эрхлэлтийн албаны тухай ОУХБ-ын 88 дугаар конвенц, хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлж ажилгүйдлээс хамгаалах тухай ОУХБ-ын 166, Хөдөлмөр, статистикийн тухай 160 дугаар конвенциудад Монгол Улс нэгдэн орох шаардлагатай байгаагийн сацуу нэгэнт нэгдэн орсон гэрээ конвенциудад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх нь чухал байна.

Монгол Улсад шинээр ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагуудад татварын хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлттэй нөхцөлөөр зээл олгох зэрэг татварын уян хатан бодлого явуулах зохицуулалтыг Монгол Улсын хуульд тусгах нь чухал юм. Энэ асуудлыг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулахад ажилгүйдлийн тоог бодитой тооцох шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр зохицуулалтын газар,

хөдөлмөрийн бирж, татварын болон иргэний бүртгэл мэдээллийн албадтай хамтарсан хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сүлжээг бий болгох зэрэг болно.

Жижиг дунд үйлдвэр олноор байгуулах нөхцөлийг бүрдүүлэх нь ажлын байр нэмэгдүүлэх гол эх үүсвэр гэж нэлээд хүмүүс ярьдаг. Үнэхээр “Аж ахуйн нэгжийн тухай” хууль 1991 оноос үйлчилж эхэлснээс хойш манай улсад 47 мянга орчим аж ахуйн нэгж шинээр байгуулагдсанаас хувийн хэвшлийн салбарт 400 орчим мянган ажлын байр бий болжээ. Ингэж хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд байгуулагдан ажлын байр бий болохын зэрэгцээ түүнээс дутахгүй хэмжээгээр аж ахуйн нэгжүүд татан буугдсан байна. Жишээлбэл, 1991-1995 онд улсын хэмжээнд 9.8 мянган аж ахуйн нэгж татан буугджээ.¹⁴

Хувийн аж ахуйн нэгж байгуулах иргэдэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх, энэ талаар эздийн байгууллагатай хамтран ажиллах, шинээр аж ахуйн нэгж бүртгүүлэх шат дамжлага, чирэгдлийг багасгах зэрэг асуудлыг нухаштай судалж хэрэгжүүлэх асуудал ч тавигдаж байна.

© 1999 он.

¹ Тус улсад албан ёсоор бүртгэгдсэн ажилгүй хүний тоо 1998 оны 8 дугаар сарын байдлаар 115 000 болжээ. /Л.М./

² Л.Баасан. Монгол улсын хөдөлмөрийн эрх зүй /Тусгай анги/. 1997 он.

³ А.С.Пашков. Трудовое право России. г. 1995. стр. 94.

⁴ С.Ожего. Словарь русского языка. г. 1998.

⁵ Л.Баасан. Хөдөлмөрийн эрх зүй /Тусгай анги/. 1997 он. 6-р тал.

⁶ Хөдөлмөрийн зах зээлийг төвлөрсөн байдлаар зохицуулдаг аргыг ийнхүү нэрлэв. /Л.М./

⁷ Ажил хайгчтай холбоотой мэдээллийг зуучлагч ажилтан олж авах аргыг дээрх байдлаар томъёолов. /Л.М./

⁸ ажил хайгч гадны ямар нэг оролцоогүйгээр ажлын байрны тодорхойлолтыг авч болно.

⁹ Уг үйлчилгээг дэлхийн ихэнх улсуудад өргөн хэрэглэж байна. /Л.М./

¹⁰ Хөдөлмөрийн зах зээлийн тайлан. 1998 оны 9 дүгээр сар.

¹¹ Ажлын байрны захиалгад дурасан мэргэжлийн шалгууруудыг хангахгүй байх гэдэг утгаар хэрэглэв. /Л.М./

¹² Засгийн газрын 1998 оны 87 дугаар тогтоолын хавсралтаар нийтийг хамарсан ажил зохион байгуулах журмыг тогтоосон байна.

¹³ Хөдөлмөр эрхлэлтийн төрийн албаны чиг үүргийн тухай TACIS хотолборийн зөвлөх Удо Главичийн илтгэл. 1998 он. 24-р тал.

¹⁴ Үндэсний татварын газрын статистик мэдээнээс авав. /Л.М./

«Шихихутуг» ХЗДС-ийн 1999-2000 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам

Нэг: Ерөнхий зүйл

1.1. Тус сургуульд 1999-2000 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхэд Гэгээрлийн Яамнаас баталсан «Мэргэжлийн сургуулийн элсэлтийн үлгэрчилсэн журам» болон энэхүү журмыг баримтална.

1.2. Элсэлтийн шалгалтыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон элсэлтийн комисс удирдан зохион байгуулна.

1.3. Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой хүмүүсийг элсэлтийн шалгалтанд оруулна.

1.4. Элсэлтийн шалгалтыг зөвхөн Улаанбаатар хотод явуулна.

Хоёр: Шалгуулагчдыг бүртгэх

2.1. Шалгуулагчдыг 1999 оны зургадугаар сарын 21-27-ний өдрүүдэд тус сургуулийн байран дээр бүртгэнэ.

2.2. Элсэлтийн шалгалт өгөх хүмүүс дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- Элсэхийн хүссэн өргөдөл,
- Иргэний паспорт,
- Боловсролын үнэмлэх,
- Сурагчийн хувийн хэрэг,
- 3x4 хэмжээний 1 хувь цээж зураг,
- 1997 оноос өмнө төгсөгчид МЕТ-ийн шалгалт өгсөн бичиг,
- Эчнээгээр суралцах ажиллагч албан байгууллагын тодорхойлолт,
- Бүртгэлийн хураамж 2500 төгрөг,

- Элсэлтийн шалгалт авч буй хичээлээр зохиогдсон улсын олимпиадад энэ хичээлийн жилд 1-3-р байрт шалгарсан байвал тухайн шалгалтаас чөлөөлөгдөнө. /Үүнийгээ нотлох баримт бичгийг авчирна./

2.3. Шалгуулагч өөрийн биеэр ирж элсэлтийн комисст бүртгүүлнэ.

2.4. Элсэлтийн шалгалтанд орох материалыг хуурамчаар бүрдүүлсэнтэй холбогдон гарах хариуцлагыг шалгуулагч өөрөө хүлээнэ.

Гурав: Элсэлтийн шалгалт авах, суралцах эрхийн бичиг олгох

3.1. Элсэлтийн шалгалтыг зөвхөн нэг удаа холимог тестээр авна. Тестийн шалгалтанд хоёр хичээл багтах бөгөөд тэдгээрийн тестэд эзлэх хувь нь:

- нийгмийн тухай мэдлэг - 70 %
- орос (англи) хэл - 30% байна.

3.2. Тестийн шалгалтын нийт оноо 100 байна.

3.3. Шалгуулагчдыг бүлэг болгон зохион байгуулж шалгана.

3.4. Шалгалт ил тод байна.

3.5. Боловсролын гэрчилгээ буюу дипломын дүнгийн дундаж оноон дээр тестийн оноог нэмэж нийт оноог гаргана.

3.6. Шалгуулагчдын нийт оноо тэнцсэн тохиолдолд

а/ Нийгмийн тухай мэдлэгийн шалгалтын оноогоор,

б/ Боловсролын баримт бичигт тавигдсан үнэлэлтийн дундаж болон МЕТ-ийн үнэлгээгээр аль илүү үнэлэгдсэн шалгуулагчыг шалгаруулна.

3.7. Шалгалтын явцад олон нийтийн зүгээс хяналт тавих боломж олгох зорилгоор шалгуулагчдын ар гэрийн төлөөлөлтэй

ажиглагчдын хэсгийг байгуулж ажиллуулна. Ажиглагчид элсэлтийн ажицд хүндрэл учруулахгүйгээр элсэлтийн явцад хяналт тавина.

3.8. Шалгалтын явцад вариант сольсон, хуулсан, өөрийн оронд хүн оруулсан, шалгалтын журмыг ноцтойгоор зөрчсөн шалгуулагчийг тухайн шалгалтаас хасаж, дараагийн шалгалтанд оруулахгүй.

3.9. Шалгалттай холбогдсон маргааныг элсэлтийн комисс тухайн үед нь эцэслэн шийдвэрлэнэ.

3.10. Элсэлтийн шалгалтын дүнгээр хяналтын тоонд багтсан хүмүүсийг эрүүл мэндийн үзлэгт оруулна.

3.11. Элсэлтийн шалгалт, эрүүл мэндээр тэнцсэн хүмүүст суралцах эрхийн бичиг олгоно.

3.12. Суралцах эрхийн бичиг авсан хүмүүс 1999 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө сургалтын төлбөрийн тооцоог хийж, суралцах гэрээ байгуулна.

«ШИХИХУТУГ» ХЗДС-ИЙН ЗАХИРГАА

МЭРГЭД ГАРАХЫН ОРОН

Албан бус орчуулга

СУУТНУУДЫН ХЭЛСЭН ҮГЭЭС:

1. Хороо гэж нэг хүний ажлыг хийж байгаа арван хоёр хүнийг хэлнэ. */Жон Кеннеди/*
2. -Юу амархан бэ?
-Бусдад зөвлөх л амархан. */Фалес. Долоон мэргэдийн нэг, Эртний Грекийн гүн ухаантан/*
3. Хүмүүсийг араасаа дагуулахын хүсвэл тэдний араас (толөө) явах хэрэгтэй. */Лао-Цзы. Эртний Хятадын гүн ухаантан/*
4. Ард түмэнд байгаа, үгүй эсэх нь мэдэгддэггүй удирдагч бол хамгийн сайн удирдагч юм. */Лао-Цзы/*
5. Ярьж чаддаггүй хүн тушаал дэвшихгүй (карьер хийж чадахгүй). */Наполеон/*
6. «НЭГ ЭХЛЭЛИЙН ЗАРЧИМ»: «Хоёр толгойтой бие бол мангас» */А. Файоль, америкийн зохион байгуулагч/*
7. Бүх бүдүүдэг зангийн нийтлэг гэм нь өөрийнхөө мэддэггүй зүйлийг ерөөсөө байдаггүй гэж үзэх явдал юм. */Леон-Баттиста Альберти/*
10. Хаалттай ам шүдтэй үлдэхэд тусалдаг.
11. Шоглоомонд битгий гомд. Тэгэхийн оронд шоглогчийг тэмдэглээд авчих. Хурал зөвөлгөөнд битгий хоцроорой. Хоцорвол эхний эгнээд сууна шүү.
12. Байгаль хоосролыг тэвчдэггүй: Хүмүүс үнэнийг мэдэхгүй байгаа үедээ тэрхүү үнэний хоосон орон зайг таамаглалаараа дүүргэдэг. */Бернард Шоу/*
13. Танд нэг алим, надад нэг алим байгаад, тэдгээрийг бид солилцоход танд ч нэг, надад ч нэг л алим үлдэнэ. Харин танд нэг шинэ санаа, надад нэг шинэ санаа байгаад, тэдгээрийг бид солилцвол бидний хэн хэн нь хоёр шинэ санаатай үлдэх болно. */Бернард Шоу/*
14. Төрийн зүтгэлтэн улс төрийн зүтгэлтнээс ялгагдах гол ялгаа нь улс төрийн зүтгэлтэн үйл ажиллагаагаа дараагийн сонгуульд чиглүүддэг бол, харин төрийн зүтгэлтэн үйл

- ажиллагаагаа дараагийн үед чиглүүлэн явуулдагт оршино.
/Уинстон Черчилль/
15. Аугаа ихээх инээдэмтэй байдал хүртэл ганц л алхам байдаг.
/Наполеон/
16. Улиг болсон энгийн үнэнийг тоогоогүйгээс болж хүмүүс хамгийн их хохирол хүлээдэг. */Фридрих Ницше/*
17. Залилуулах хамгийн найдвартай арга бол өөрийгөө бусдаас зальтай гэж бодох юм. */Ларошфуко, францын ёс зүйч/*
18. Цамаан зантай зөвлөхөөсөө өмнө өөрийнхөө түрийвчтэй зөвлөөрэй. */Бенжамин Франклин/*
19. Хуулиуд бол аалзны шүлстэй адил: сул доройчуудыг тэд ороодог, харин хүч чадалтнууд тэднийг урж тасддаг. */Солон, эртний долоон мэргэдийн нэг/*
20. Мэдлэг бол ухааныг орлож чадахгүй. */Пифагор/*
21. Үдийн хоолны өмнө өлсгөлөнтэй тэмцдэг, үдийн хоолны дараа нойртой тэмцдэг. */ардын аман зохиол/*
22. Ухаангүй хүмүүсийг удирдахад их ухаан, мэдлэггүй хүмүүсийг удирдахад их мэдлэг шаардлагагүй. */Эстебан де Эсмир, епископ/*
23. Одууд зөвхөн харанхуйд л харагддаг. */Витело, XIII зуун/*
24. Албан тушаал ихэнхдээ ааш занг хувиргадаг. */Сервантес, испанийн зохиолч/*
25. Ухаантай байхыг хүсвэл, ухаалаг асуулт тавьж, анхааралтай сонсож, тайван харнуулж, түүнчлэн өөр хэлэх юмгүй болсон үедээ яриагаа дуусгаж сур. */И.Лафатер, XVIII зууны швейцарын сэтгэгч/*
26. Чиний өөртөө итгэх итгэлийг алдагдуулах гээд байгаа хүмүүсээс хол яв. Энэ бол шалихгүй хүмүүсийн зан. Аугаа их хүмүүс бол харин эсрэгээр чамайг ч гэсэн аугаа их болж чадна гэдгийг мэдрүүлдэг юм. */Марк Твен/*
27. Хувьсгалыг үл гүйцэлдэх үзэлтнүүд */Утопист-ууд/* сэтгэж, хэт шүтэгчид */фанатик-ууд/* хэрэгжүүлж, түүний үр шимийг үл бүтэх этгээдүүд хүртдэг. */Энэ бол яав ч тэнэг хүний тэмдэглэл биш/*
28. Хүн үнэнч шударга байх тусмаа бусдыг үнэнч шударга биш гэж хардах нь бага байдаг. */Цицерон/*
29. Хүн төрөлхтөн өөрсдийнхөө өмнө зөвхөн шийдэж чадах

- зорилтуудаа л тавьдаг. /К.Маркс/
30. Дэлхий дээр хоёр төрлийн менежерүүд байдаг. Шинэ санаа гарч ирэхэд эхнийх нь «Энэ ямар үнэ, өртөгтэй вэ?» гэж асуудаг, харин хоёр дахь нь «Энэ санааг хэрэгжүүдсэнээр бидэнд ямар үр ашиг өгөх вэ?» гэж асуудаг. Хатуухан хэлэхэд, хоёр дахь хэлбэрээр асуулт тавьж буй удирдагчийг л жинхэнэ удирдагч гэж хэлж болно. /Вернер Зигерт, Лучия Ланг/
31. Дайснаа ялж чадахгүй бол түүнтэй нэгд. /Сенека/
32. Удаан боддог хүн тэр бүр оновчтой шийдвэр гаргадаггүй. /И.В.Гёте/
33. Ард түмнийг дуулгавартай байлгахын тулд албадаж болно. Харин мэдлэгтэй болгохын тулд албадаж болохгүй. /Конфуций/
34. Амьдрал бол тэмцээний талбартай адил юм. Зарим нь уралдах гэж ирдэг, зарим нь арилжаа, наймаа хийх гэж ирдэг. Харин хамгийн аз жаргалтай хүмүүс бол үзэгчид юм. /Пифагор/

*П.С.Тарапов, канд.философских наук.
«АФОРИЗМЫ МЕНЕДЖМЕНТА»
номноос Д.Уурцайх орчуулав.*

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ